

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ” НЭВТРҮҮЛЭХ
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх

Тендерийн дугаар: МХЕГ/202010020

Улаанбаатар хот
2020 он

ГАРЧИГ

ХЭСЭГ 1 – ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

- Бүлэг I. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТӨӨЗ)**
Энэ бүлэг нь тендер бэлтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг тендерт оролцогчдод өгнө. Тендер ирүүлэх, тендер нээх, үнэлж шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээлэл, мөн хамгийн сайн тендерийг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон тендерт оролцогч тухайн гэрээг гүйцэтгэх чадвартай эсэхийг тогтоох чадварын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах чадварын доодшаардлагууд энд бичигдсэн байна. Нэгдүгээр бүлэг дэх зүйл заалтуудыг захиалагч өөрчлөхгүйгээр ашиглах ёстой.
- Бүлэг II. Тендер шалгаруулалтын өгөгдөлийн хүснэгт (ТШӨХ)**
Энэ бүлэг нь тухайн худалдан авах ажиллагаа бүрт тохирсон онцлог заалтуудыг агуулах бөгөөд эдгээр нь нэгдүгээр бүлгийн холбогдох зүйл заалтуудыг тодруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.
- Бүлэг III. Тендер шалгаруулалтын маягт**
Энэ бүлэгт тендер ирүүлэх маягт, үнийн хуваарийн хүснэгт, тендерийн баталгааны маягт болон үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн маягт зэрэг тендерт оролцогчоос өөрийн тендерийн хамт бөглөж ирүүлэх шаардлагатай маягтууд багтана.

ХЭСЭГ 2 – БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Бүлэг IV. Техникийн тодорхойлолт болон бусад шаардлага**
Энэ бүлэг нь худалдан авах бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний жагсаалт болон тэдгээрийг захиалагчид хүргэх, дуусгах хуваарь, техникийн тодорхойлолт болон тухайн худалдан авах бараа болон дагалдах үйлчилгээг тайлбарласан, дүрсэлсэн Зураг зэрэг мэдээллүүд багтана.

ХЭСЭГ 3 – ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

- Бүлэг V. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН)**
Энэ бүлэг нь аливаа захиалагч байгууллагаас бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан ерөнхий нөхцөл, заалтуудыг агуулна. ГЕН-ийн заалтуудын үг, үсэг, агуулгыг өөрчилж үл болно.
- Бүлэг VI. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)**
Энэ бүлэгт тухайн худалдан авах барааны онцлогт тохируулан гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл заалтыг тодруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ.
- Хавсралт. Тендерийн Урилга**
Тендерийн урилгын маягтыг энэхүү тендерийн баримт бичгийн төгсгөлд жишээ болгон орууллаа.
- Жич:** Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн хэсэг, бүлгийн оноосон нэр, гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэсэн бөгөөд ямар нэгэн агуулга, хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж

Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер /чанарын шаардлага хангасан барааг эрсдэл багатайгаар нийлүүлэх санал/ бэлтгэхтэй холбоотойгоор тендерт оролцогчдод шаардагдах бүрэн мэдээллийг энэ бүлэгт тусгана. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх, хамгийн сайн тендерийг шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг багтаана. Эдгээр үйл ажиллагааг явуулахдаа захиалагч тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

Нийлүүлэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус 3 дугаар бүлэгт буюу гэрээний ерөнхий нөхцөлд, 4 дүгээр бүлэгт буюу гэрээний тусгай нөхцөлд тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь тендерийн баримт бичгийн бүрэлдэхүүн болох ба харин гэрээний хэсэг болохгүй.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|--|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /ТШӨХ/-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан мэдээллийн систем /МС/-ийг нийлүүлэх, суурилуулах гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Мэдээллийн системийг нийлүүлэх, суурилуулах нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> <p>1.3. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.</p> <p>1.4. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | <p>2.1. Захиалагч дээр дурдсан барааны нийлүүлэлт, суурилуулалтын ажлыг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.</p> |
| 3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл | <p>3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, нийлүүлэгч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.</p> |
| 4. Эрх бүхий тендерт оролцогч | <p>4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.</p> <p>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> |

- 4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
 - 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.5. Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
 - 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
 - 4.2.8. Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
 - 4.2.9. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчид энэхүү тендерт оролцохдоо нэг/адил хууль ёсны төлөөлөгчтэй бол;
 - 4.2.10. Энэхүү тендерийн баримт бичгийн 18 дугаар зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд тухайн тендер шалгаруулалтад нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй.)
 - 4.2.11. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар төр ашгийн төлөө үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан явуулахаар заасан тул эдгээрээс бусад төрийн байгууллага, албан газар тендерт оролцох эрхгүй/.
- 4.3. Тендерт оролцогч 4.2.1-4.2.11 дахь заалтад дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчийн тавьсан үндэслэл бүхий шаардлагын дагуу тендерт оролцогчид холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

**5. Эрх бүхий
бараа,
үйлчилгээ**

5.1. Энэхүү тендерийн баримт бичигт Мэдээллийн систем гэдгийг дараах утгаар ойлгоно. Үүнд:

(а) гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлж, угсарч суурилуулах шаардлагатай мэдээлэл боловсруулалт болон харилцаа холбооны техник хангамж, программ хангамж, бусад бараа, дагалдах зүйлсийг хамруулсан мэдээллийн технологи ба холбогдох бүх бичиг баримтууд, холбогдох дагалдах материалууд, нийлүүлж, суурилуулж нэгтгэн ашиглалтад бэлэн болгох барааг (ТОӨЗ-ны зарим заалтуудад бүхэлд нь Бараа гэж нэрлэсэн); мөн

(б) холбогдох программ хангамжийн шинэчлэлт, сайжруулалт, тээвэрлэлт, даатгал, суурилуулалт, нэмэлт тохируулгын ажил, туршилт, ашиглалтад бэлэн болгох, хянан шалгах, сургалт, техник тусламж, засвар үйлчилгээ болон тендэрт шалгарсан оролцогчийн гэрээний дагуу нийлүүлэх мэдээллийн системийг хэвийн ажиллуулахад шаардлагатай бусад үйлчилгээ зэрэг болно.

5.2. Гэрээнд заасан мэдээллийн системд хамаарах аливаа бараа, үйлчилгээ нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болох ба гэрээний дагуу хийгдэх төлбөр нь ТОӨЗ-ны 1.1-д дурдсан барааны хүрээнд хийгдэнэ.

Энэхүү зааварчилгааны 5.2 дах заалтад дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

6. Түншлэл

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл” гэх, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер шалгаруулалтад оролцох тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:

- (а) тендер нь түншлэлийн бүх гишүүдийн хувьд хүчин төгөлдөр байхаар гарын үсэг зурагдсан байх;
- (б) түншлэлийн нэг гишүүнийг уг түншлэлийг төлөөлөх эрх бүхий гишүүнээр томилж, түншлэлийн бүх гишүүдийн албан ёсны баталгаажсан гарын үсэг зурагдсан итгэмжлэлийг ирүүлэх;
- (в) ТООЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;
- (г) гэрээний нийт гүйцэтгэл, түүний төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцох;
- (д) мэдээллийн системийн тодорхой хэсгийг хариуцсан түншлэлийн аль нэг гишүүн эсхүл гишүүд нь тухайн бүрэлдэхүүн хэсэгт хамаарах чадварын доод шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх;
- (е) эрх бүхий тендерт оролцогч нь дангаараа болон түншлэлийн гишүүн болж тендерт ирүүлж болох ба энэ тохиолдолд бусад тендерт туслан гүйцэтгэгч болохгүй. Энэ шаардлагыг хангаагүй бүх тендерт оролцогчийн холбогдох тендерээс татгалзана. Энэ заалтыг зөрчилгүйгээр дангаар буюу түншлэлийн гишүүний хувьд тендер ирүүлээгүй тохиолдолд эрх бүхий этгээд хэдэн ч тендерт туслан гүйцэтгэгчээр оролцож болно
- (ж) гэрээний нөхцлийн дагуу гэрээг хэрэгжүүлэхэд түншлэлийн бүх гишүүд хамтдаа болон тус тусдаа хариуцлага хүлээх бөгөөд энэ тухай ТООЗ-ны 6.2 (б)-д дурдсан эрх олгосон баримт болон гэрээнд (тендер нь шалгарсан бол) дурдана.

7. Тендер шалгаруулал -тад оролцох зардал

7.1. Тендерт оролцогч тендер бэлтгэж ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах бөгөөд захиалагч ямар ч тохиолдолд энэ зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

8. Ажлын талбайтай танилцах

8.1. Тендерт оролцогч нь мэдээллийн системийн хэрэгжих ажлын талбай, түүний байршил, нөхцөл байдалтай газар дээр нь буюу тендерт оролцох болон гэрээ байгуулснаар учирч болох хариуцлага, эрсдлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авах, хянах, судлах зорилгоор биечлэн танилцах хүсэлт гаргаж болно. Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцахад гарах бүх зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.

8.2. Тендерт оролцогч захиалагчид тэднийг ажлын талбайтай танилцуулах ажиллагааг зохион байгуулах боломжит хугацааг олгох буюу энэ тухай хүсэлтээ албан ёсоор хамгийн багадаа 14 хоногийн өмнө хүргүүлнэ. Нөгөө талаас, захиалагч нь ажлын талбайтай танилцуулах эсхүл уг ажиллагааг тендерийн өмнөх уулзалттай хамтад нь ТООЗ-ны 11.2 дугаар зүйлийн дагуу ТШӨХ-д тодорхойлсноор зохион байгуулж болно. Ажлын талбайтай танилцаагүй нь тухайн тендерт оролцогчийг чадваргүй гэж үзэх үндэслэл болохгүй.

8.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш болон гэрээ байгуулах эрх олгохоос өмнө ажлын талбайтай танилцах ажиллагааг зохион байгуулахгүй.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

9. Тендерийн баримт бичгийн агуулга

9.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ын 11 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт/ТШӨХ/
Бүлэг 3. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтүүд
Бүлэг 4. Тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягтууд
- Тендерийн маягт болон үнийн хуваарь
 - Тендерийн баталгааны маягт
 - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

II ХЭСЭГ

- Бүлэг 4. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлагууд, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

- Бүлэг 5. Гэрээний ерөнхий нөхцөлүүд
Бүлэг 6. Гэрээний тусгай нөхцөлүүд
Бүлэг 7. Гэрээний маягтууд
- Гэрээний маягт
 - Гүйцэтгэлийн баталгааны маягт
 - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт
- Бүлэг 8. Бусад шаардлагатай материал

9.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

9.3. Хэрэв тендерт оролоцох сонирхолтой аливаа этгээд тендерийн баримт бичгийг захиалагчаас шууд аваагүй бол тендерийн баримт бичиг болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт дутуу байх, мэдээлэл буруу байхтай холбоотой хариуцлагыг Захиалагч хүлээхгүй.

9.4. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөлүүд болон шаардлагатай маягтууд, техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.

- 10. Тендерийн баримт бичгийг тодруулах**
- 10.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор **ТШӨХ-д заасан** захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас **ТШӨХ-д заасан** хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.
- 10.2. Тухайн тодруулгын үр дүнд Захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 11 дугаар зүйл, 21.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.
- 11. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 11.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Ийнхүү хийсэн аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг захиалагчаас тендерийн баримт бичиг шууд худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.¹ Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 11.3. Шаардлагатай бол тендерийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг тендер бэлтгэхдээ авч үзэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох үүднээс захиалагч 23.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 12. Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 12.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 13. Тендерийн хэл**
- 13.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалууд болон бусад баримт материалуудыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь **ТШӨХ-д** заасан хэл дээр байна.
- 13.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичгүүд, урьд өмнө хэвлэгдсэн материалууд нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг үнэлэх, хянан үзэхэд харгалзана.
- 14. Тендерийн иж бүрдэл**
- 14.1. Тендерт оролцогчийн ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

¹ Иймд захиалагч тендерийн баримт бичиг худалдан авсан бүх этгээдийн нэр, хаягийг бүрэн бөгөөд нягт нямбай тэмдэглэж авах үүрэгтэй.

- (a) Тендерт оролцогчийн бүрэн гүйцэд бөглөсөн, гэрээ байгуулах эрх бүхий этгээд /этгээдүүд/-ийн гарын үсэг, тамга тэмдэгээр албан ёсоор баталгаажсан Тендерийн маягт;
- (б) ТООЗ-ны 17, 18, 23 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн, гэрээ байгуулах эрх бүхий этгээд /этгээдүүд/-ийн гарын үсэг, тамга тэмдгээр албан ёсоор баталгаажсан Үнийн хуваарь;
- (в) ТООЗ-ны 22 дүгээр зүйлд заасны дагуу Тендерийн баталгаа;
- (г) ТООЗ-ны 19.1 (б) дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах эрхийг баталгаажуулсан бичиг;
- (д) Хавсралтууд:
 - (i) Хавсралт 1: Эрх бүхий тендерт оролцогч:
Урьдчилсан сонголт явуулаагүй тохиолдолд тендерт оролцогч нь ТООЗ-ны 4 дүгээр зүйлд тодорхойлсны дагуу захиалагчийн шаардлагад нийцсэн эрх бүхий этгээд гэдгийг нотлох баримт;
 - (ii) Хавсралт 2: Тендерт оролцогчийн чадвар:
Тендер нь шалгарсан тохиолдолд тендерт оролцогч ТООЗ-ны 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотолсон мэдээллийг ирүүлнэ. Урьдчилсан сонголт явуулсан тохиолдолд тендерт оролцогчийн ирүүлсэн аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон бол ТООЗ-ны 6.1 (а)-д заасны дагуу өөрчлөгдсөн мэдээлэл, нотолгоог ирүүлэх, өөрчлөгдөөгүй бол энэ тухай мэдэгдэл; ТООЗ-ны 6.1 (б)-д заасны дагуу ТШӨХ-д шаардсан Үйлдвэрлэгчийн итгэмжлэл;
 - (iii) Хавсралт 3: Эрх бүхий бараа, үйлчилгээ:
Тендерт оролцогчийн нийлүүлж, угсарч суурилуулах мэдээллийн системийн бүрдэл бараа, үйлчилгээ нь ТООЗ-ны 5 дугаар зүйлд тодорхойлсны дагуу эрх бүхий эсэхийг нотлох баримтуудыг ирүүлэх, хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсон бол мэдээллийн системийн тухайн бүрдэл нь эрх бүхий эсэхийг нотлохдоо тухайн барааны ачилтын өмнө гаргасан гарал үүслийн гэрчилгээ;
 - (iv) Хавсралт 4: Мэдээллийн систем тендерийн баримт бичигт нийцэх:
Тендерт оролцогчийн нийлүүлж, угсарч суурилуулах мэдээллийн системийн бүрдэл болох бараа, үйлчилгээ нь ТООЗ-ны 20 дугаар зүйлд тодорхойлсны дагуу энэхүү тендерийн баримт бичигт нийцэхийг нотлох баримт;
 - (v) Санал болгож буй туслан гүйцэтгэгчид:
Бараа, үйлчилгээний голлох хэсгийг худалдан авах буюу туслан гүйцэтгүүлэх бол санал болгож буй туслан гүйцэтгэгч, нийлүүлэгчийн нэр болон бусад мэдээлэл
 - (vi) Хавсралт 6: Оюуны өмч
 - (1) ГЕН-ийн 1.1 (в)-д заасан программ хангамжийн төрөл тус бүрт хамаарах Тендерт оролцогчийн тендерт заагдсан аливаа програм хангамжийн жагсаалт:
 - (а) Систем, үндсэн болон хэрэглээний програм хангамж;
 - (б) Стандарт болон тусгайлсан програм хангамж.
 - (2) ГЕН-ийн 1.1 (в)-д тодорхойлсон Тендерт оролцогчийн тендерт заагдсан аливаа тусгайлсан материал.

ГЕН-ийн 1.1 (в)-д тусгасан бичиг баримт гэж тодорхойлсоноос бусад материалыг стандарт бичиг баримт гэж үзнэ.

Программ хангамж ба бичиг баримтын ангиллыг ГЕН-ийн 38 (Системийг өөрчлөх)-д заасны дагуу шаардлагатай бол гэрээний явцад дахин үнэлнэ.

- 15. Тендерийн маягт болон үнийн хуваарь**
- 15.1. Тендерт оролцогч нь Тендерийн жишиг маягт (Бүлэг 4)-д заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний загварыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.
- 15.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа, түүнийг дагалдах үйлчилгээнд үнийн хуваарь ирүүлнэ. Үнийн хуваарийг Тендерийн жишиг маягт (Бүлэг 4)-д тусгасан тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.
- 16. Хувилбарт тендер**
- 16.1. **ТШӨХ**-д өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
- 17. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**
- 17.1. Тендерийн маягтад болон Үнийн хуваарьт тусгаж харуулах тендерт оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байх ёстой.
- 17.2. Бүх багцууд болон нэр төрлүүдийг үнийн хуваарьт жагсааж, тус бүрийг нь тусад нь үнэлсэн байх.
- 17.3. Тендерийн маягтад санал болгосон үнэ нь санал болгож буй аливаа үнийн хөнгөлөлт тооцогдоогүй тухайн тендерийн нийт үнэ байх ёстой.
- 17.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусгасан байх ёстой.
- 17.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон бусад ижил төстэй нөхцөлүүдийг Олон улсын худалдааны танхимаас хэвлэн гаргасан Incoterms-ийн одоогийн буюу **ТШӨХ**-д дурдсан хувилбараар тайлбарлан, зохицуулна.
- 17.6. Нийлүүлэх барааны үнийг Тендерийн маягтууд буюу 4 –р бүлэгт заасан Үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ.
- 17.7. Энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас **14** хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна. Тендерт оролцогч гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгана.
- 17.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-1.2 –оос үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно
- 17.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна :
- (а) Монгол улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:
1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, эсхүл агуулахын, лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд дараах зүйлд

төлсөн буюу төлөх гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар, хураамжуудыг оруулна:

- а) барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан, үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, эсхүл
 2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;
 3. барааг **ТШӨХ-д** заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (б) Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:
1. **ТШӨХ-д** захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИП/СІР/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /СІР/ үнэ;
 2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
 3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас **ТШӨХ-д** заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (в) Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:
1. Барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
 2. Импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
 3. Тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар, зөрүү;
 4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
 5. барааг **ТШӨХ-д** заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

17.10. **ТШӨХ-д** гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг тохируулж өөрчилөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 33.4 дугаар зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч, **ТШӨХ-д** үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

17.11. **ТШӨХ-д** үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

17.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

- 18. Тендерийн валют**
- 18.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.
- 19. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**
- 19.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
 - (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
 - (в) **ТШӨХ-д** шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.
- 20. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**
- 20.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:
- (а) Хэрэв **ТШӨХ-д** шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай Үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг тендерийн маягтууд (4-р бүлэг)-д заасан маягтыг ашиглан ирүүлнэ;
 - (б) санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн **ТШӨХ-д** заасан тоо бүхий жилийн баталгаажсан санхүүгийн тайлан;
 - (в) гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
 - (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн **[ТШӨХ-д заасан тоо]** жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
 - (д) Хэрэв **ТШӨХ-д** шаардсан бол Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
 - (е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
 - (ё) одоогийн ба сүүлийн **[ТШӨХ-д заасан тоо]** жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
 - (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчдээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлэх.
- 20.2. Тендерт оролцогч ТӨӨЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх тухай гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үүнд:
- (а) Сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь **ТШӨХ-д** заасан дүнгээс багагүй байх;
 - (б) сүүлийн **[ТШӨХ-д заасан тоо]** жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
 - (в) **ТШӨХ-д** заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь олж (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
 - (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон

авах боломжтой зээл нь **ТШӨХ-д** дурдсан дүнгээс багагүй байх;

(д) сүүлийн **ТШӨХ-д** дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

20.3. Тендерт оролцогч түншлэл нь 20.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 20.2 (а), (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь **25 хувийг**, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь **40 хувийг** хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. **ТШӨХ-д** өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй. Тендерт оролцогч 20.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

20.4. **ТШӨХ-д** тусгайлан заасан бол Монгол улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлж буй тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамт ирүүлэх үүрэгтэй.

21. Нийлүүлэх мэдээллийн систем нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох

21.1. ТӨӨЗ-ны 14.1 (д) (iv)-д заасны дагуу тендерт оролцогч гэрээгээр нийлүүлж суурилуулах Мэдээллийн систем нь ТББ-д нийцэж буйг тогтооход шаардлагатай баримт бичгүүдийг тендерийн хамт ирүүлнэ.

21.2. Нийлүүлэх бараа тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт нь тайлбар, нийтлэл, зураг, гэрчилгээ, өмнөх захиалагчийн тодорхойлолт хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн техникийн санал буюу дэлгэрэнгүй техникийн шийдэл нь Бүлэг 5 - Техникийн шаардлага болон ТББ-ын бусад нөхцөл шаардлагад нийцсэн тухай;

(б) нийлүүлэх Мэдээллийн систем нь Техникийн шаардлагад нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, тендерт оруулсан нэмэлт мэдээлэл, техникийн тодорхойлолт болон каталог, бусад материал нь тайлбараас зөрсөн бол тайлбарыг баримтална.

(в) Гэрээ байгуулах эрх олгогдсон тохиолдолд тендерт оролцогчийн хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг харуулсан Урьдчилсан ажлын төлөвлөгөө, санал болгож буй хүний нөөц болон бусад эх үүсвэрийн тухай мэдээлэл;

(г) Мэдээллийн системийн бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь ТББ-д шаардсаны дагуу амжилттай нэгтгэгдэж хэвийн ажиллах хариуцлагыг баталгаажуулсан тендерт оролцогчийн бичгээр гаргасан мэдэгдэл.

(д) санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн **ТШӨХ-д** заасан тоо бүхий жилийн баталгаажсан санхүүгийн тайлан;

(е) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн **[ТШӨХ-д заасан тоо]** жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;

(ё) Хэрэв **ТШӨХ-д** шаардсан бол Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг

Монгол улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт.

21.3. ТООЗ-ны 21.2 (б)-д заасны дагуу тайлбар ирүүлэхдээ Захиалагчийн техникийн шаардлагад дурдсан барааны тэмдэг, загварын дугаар болон барааны стандартад холбогдох мэдээлэл нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүй гэдгийг тендерт оролцогч анхаарна. ТООЗ-д тусгайлан хориглоогүй бол тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн шаардлагад заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

22. Тендерийн баталгаа

22.1. **ТШӨХ-д** шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь **ТШӨХ-д** заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

22.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

22.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

22.4. Тендерийн баталгаа нь Монгол улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг Тендерийн жишиг маягт (Бүлэг 4)-т заасан маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

22.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

22.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

22.7. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

22.8. Шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааг 23.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор багтаан хүчингүй болгоно.

22.9. Тендерт шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг 43 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, 44 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлэхэд хүчингүй болгоно.

22.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно:

- (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
- (б) тендерт оролцогч 34.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТООЗ-ын 41.2-т заасан нөхцөл үүссэн бол;
- (в) тендерт шалгарсан оролцогч заасан хугацаанд багтаан:
 - 1) 43 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй бол;

2) 44 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.

(г) тендерт оролцогчийн гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана. Тендерт оролцогч нь ТӨӨЗ-ны 23.2 дугаар зүйлийн дагуу ТШӨХ-д заасан тендер хүчинтэй байх хугацаа сунгагдах тохиолдолд үүний дагуу өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунган, хэрэв шаардлагатай бол ТӨӨЗ-ны 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг ирүүлнэ.

23.2. Онцгой нөхцөл байдал үүсэж тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх оролцогчдод хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлт болон түүний хариуг бичгээр мэдэгдэнэ. Хэрэв тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг зөвшөөрвөл түүний тендерийн баталгааны хугацаа мөн адил сунгагдана. Тендерт оролцогч тендерийн баталгаагаа үл гүйцэтгүүлэн хүсэлтээс татгалзах эрхтэй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчоос тендерээ өөрчлөхийг зөвшөөрөх эсхүл шаардахыг хориглох боловч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг ТӨӨЗ-ны 21-д заасанд нийцүүлэн сунгахыг шаардаж болно.

24. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

24.1. Тендерт оролцогч 14 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд "ЭХ ХУВЬ" гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна **ТШӨХ-д заасан тоо** ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж "ХУУЛБАР ХУВЬ" гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

24.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг бичиг баримт үүнд хамаарахгүй.

24.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- 25. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх**
- 25.1. Тендерт оролцогчид өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр/биеэр захиалагчид хүргүүлнэ.
- 25.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТООЗ-ны 25.3, 25.4 –т заасныг баримтлана.
- 25.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- (а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх,
 - (б) **ТШӨХ-д заасан** хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;
 - (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д**тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;
 - (г) ТООЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.
- 25.4. Хэрэв бүх дугтуйг 25.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө задарсанд захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 25.5. ТООЗ-ны 24.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.
- 25.6 Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Захиалагч тендерүүдийг ТООЗ-ны 25.3-т дурдсан захиалагчийн хаягаар, **ТШӨХ-д заасан** огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 26.2. Захиалагч ТООЗ-ны 11 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
- 27. Хугацаа хоцорсон тендер**
- 27.1. ТООЗ-ны 26 дүгээр зүйлийн дагуу ТШӨХ-д заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг захиалагч “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр тендерт оролцогчид буцаана.
- 28. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх,**
- 28.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгч, өөрийн ирүүлсэн тендерээ өөрчлөх эсхүл буцаан авах эрхтэй.

**тендерийг
буцаан авах**

28.2. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлтийг дараах байдлаар бэлтгэн, гарын үсэг зурж, бичиглэл хийн ирүүлнэ:

- (а) Тендерт оролцогч аливаа нэмэлт өөрчлөлтийг ТООЗ-ны 28.1 дүгээр зүйлийн дагуу ТШӨХ-д заасан эх болон хуулбар хувь/ууд/-ийн тоогоор тусад нь “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ–ЭХ ХУВЬ”, “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ–ХУУЛБАР ХУВЬ. [дугаар]” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд битүүмжлэн тэдгээрийг дахин нэг дугтуйд битүүмжлэн “Тендерт нэмэлт өөрчлөлт хийх тухай” гэсэн бичиглэл хийн ирүүлнэ.
- (б) Тендерт нэмэлт өөрчлөлтийг ТООЗ-ны 25.2, 25.3 болон 25.4 дүгээр зүйлд заасан нөхцөлүүдэд нийцүүлэн бичиглэл хийн, битүүмжлэн ирүүлнэ.

28.3. Тендерт оролцогч өөрийн ирүүлсэн тендерээ буцаан авахыг хүсвэл тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгнө. Тендер буцаан авах мэдэгдлийг электрон хэлбэрээр буюу факсаар ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцроолгүй дугтуйлан битүүмжилж “Тендер буцаан авах тухай” гэсэн бичиглэл хийн ирүүлэх ба уг мэдэгдэлийг:

- (а) ТООЗ-ны 25.3 (а)-ийн дагуу ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар хаяглана;
- (б) “Тендер буцаан авах тухай мэдэгдэл” гэсэн бичиглэл болон гэрээний нэр, тендерийн урилга, түүний дугаарыг бичнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирсэн мэдэгдлийг хүчингүй болгож, өмнө ирүүлсэн тендерийг хүчинтэйд тооцно.

28.4. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТООЗ-ны 23 дугаар зүйлд заасан тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцаан авах нь ТООЗ-ны 22.7 дугаар зүйлийн дагуу тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

**29. Тендерт
оролцогч нэг
этгээд нэг
тендер
ирүүлэх**

29.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, эсхүл ирүүлэхэд оролцсон бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана. Энэ нөхцөл нь туслан гүйцэтгэгчийн хувьд болон 16 дүгээр зүйлийн дагуу зөвшөөрсөн хувилбарт тендерийн хувьд тус тус хамаарахгүй.

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

**30. Тендерийг
нээх**

30.1. Захиалагч тендерийн нээлтийг **ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт** зохион байгуулж, явуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

30.2. Захиалагч эхлээд “Тендерийг буцааж авах тухай” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ” дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.

- 30.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, хэрэв захиалагч шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт хийсэн бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.
- 30.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна.
- (а) Тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ солисон эсэх;
 - (б) Тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ), шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
 - (в) Захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.
- 30.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлснээс бусад тендерээс тендерийн нээлтийн үед татгалзахыг хориглоно.

31. Нууцлал

- 31.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 31.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.
- 31.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

32. Тендерийг тодруулах

- 32.2. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Энэ хүсэлт болон түүний хариултыг бичгээр үйлдэнэ. Гэхдээ 33 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

33. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 33.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараах шаардлагыг хангаж буйг хянан үзнэ:
- (а) ТООЗ-ны 3 дугаар зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасаныг;
 - (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсаныг;
 - (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагад нийцсэн тендерийн баталгаа ирүүлсэнийг;
 - (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэнийг;
 - (д) тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасныг тус тус тогтооно.

33.2. ТООЗ-ны 33.1 дэх хэсгийн (а), (б), (в), (г) болон (д) дэд заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд тухайн тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

33.3. Шаардлагад нийцсэн тендер гэдэг нь тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн чадвар, санал болгосон бараа 20.2-ын дагуу хүлээн зөвшөөрөхүйц эсэхийг шалгах нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр биелүүлсэн тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг томоохон зөрүү гэж үзнэ:

(а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;

(б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;

(в) зөрүүг хүлээн зөвшөөрч (rectified)засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

33.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

34. Алдааг залруулах

34.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

34.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

35. Нэг мөнгөний нэгжээр илэрхийлэх

35.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТООЗ-ны 18 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

36. Тендерийг үнэлэх, харьцуулах

36.1. Захиалагч зөвхөн 33 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна

36.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно:

(а) 34 дүгээр зүйлийн дагуу алдааг залруулах;

(б) 34 дүгээр зүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцож, үнэд залруулга хийх;

- (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
- (г) Захиалагч зөвхөн ТООЗ-ны 36.3-т тодорхойлсон үнэлгээнд харгалзах хүчин зүйлүүдээс ТШӨХ-д тусгайлан заасан хүчин зүйлийг тэдгээрт холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;
- (д) ТШӨХ-д зөвшөөрснөөр дотоодын давуу эрхийн зөрүү олгох бол холбогдох аргачлалын дагуу тооцох

36.3. ТШӨХ-д тусгайлан заагаагүй бол захиалагч үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзахгүй:

(а) *Гэрээний болон арилжааны зөрүү:*

Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өртгийг тооцоолж үнэлгээнд харгалзана.

(б) *Хүргэх хугацаа:*

Энэ тендерийн баримт бичгийн дагуу нийлүүлэгдэх барааг техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу болон түүнд багтааж хүргэх шаардлагатай. Тендерт оролцогчийн үнэ тус хуваарьт үндэслэсэн байх шаардлагатай. Тус хуваарьт зааснаас өмнө дуусгавар болгохыг санал болгосон тендерт урамшуулал олгохгүй. Тус хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн **[хувь]²** хувийг тендерийн үнэ дээр нэмнэ. Барааг хуваарьт зааснаас **[тоо]³**-аас илүү сар хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана.

(в) *Төлбөрийн хуваарийн зөрүү:*

Гэрээний тусгай нөхцөлд дурдсан төлбөрийн хуваариас өөр хуваарь санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор төлбөрийн хуваарьт зааснаас урьд төлөгдөх дүнд сарын **[хувь]⁴** -ийн хүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

(г) *Ашиглалтын зардал:⁵*

Барааны ашиглалтын зардал тухайн барааны өртгийг тодорхойлох чухал хүчин зүйл учраас захиалагч энэ зардлыг тендерт оролцогчийн ирүүлсэн үнэ, өөрийн туршлагад үндэслэн тооцно. Энэ зардлыг тендерийн үнэ дээр үнэлгээнд харгалзах зорилгоор нэмнэ.

Тооцоонд ашиглах ашиглалтын зардлын хүчин зүйл нь:

1. эхний ашиглалтын хугацаа **[тоо]⁶** жилээр;
2. ашиглалтын зардал **[хүчин зүйлийг жагсаана]⁷**;
3. 2-т заасан зардлын 1-т заасан хугацаанд гарах жил бүрийн ирээдүйн зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцоход хэрэглэсэн дискаунтчилах /хорогдуулж тооцох/ хувь.

(д) *Барааны ашиглалт, үйл ажиллагааны баталгаа:*

1. Тендерт оролцогч санал болгож буй бараандаа техникийн тодорхойлолтод нийцсэн үйл ажиллагаа, үр ашиг болон

² Ихэвчлэн 0.05 хувь.

³ Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичнэ. Ихэвчлэн 3 сар байна.

⁴ Энэ хүү нь тендер зарлах үеийн тендерийн валютын арилжааны зээлийн зонхилох хүү байна.

⁵ Ашиглалтын зардал нь худалдан авах барааны шинж чанараас хамаарах бөгөөд шатахууны зарцуулалт, сэлбэг, нэмэлт тоног төхөөрөмж, нэг өдөр болон долоо хоногт ажиллах цаг зэргийг ихэвчлэн агуулдаг. Харьцуулах боломжийг хангах зорилгоор эдгээр хүчин зүйлийг нарийвчлан тодорхойлж, зардлыг үнэлж тооцох аргыг тендерийн бичиг баримтад тусгана.

⁶ Ердийн тохиолдолд эхний ашиглалтын хугацаа нь эхний их засвар хийгдтэл байхыг зөвлөж байна. Ихэнх тохиолдолд 5-10 жил байна.

⁷ Жишээлбэл, шатахуун, эсхүл бусад тэжээл, түүний нэгж үнэ, нэг жилийн болон нийт ашиглалтын хугацааны зарцуулалт

ашиглалтын баталгаа гаргана. Санал болгосон бараа нь техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангасан тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзнэ. Энэ доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангаагүй бараа санал болгосон тендерээс татгалзана.

2. Техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшингээс дутсан (эсхүл илүү гарсан) зөрүүг үнэлгээнд харгалзах зорилгоор дутагдал (эсхүл илүүдэл) бүрт тохируулах итгэлцүүр⁸ тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

(е) *Барааны дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардал:*

Монгол улсын гаднаас санал болгох барааны орох боомтоос захиалагчийн агуулах хүртэл, эсхүл Монгол улсын дотроос санал болгох барааг үйлдвэрлэгчээс захиалагчийн агуулах хүртэл дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардлыг үнэлгээний зорилгоор тендерийн EXW, CIF, CIP, эсхүл FOB үнэ дээр нэмнэ.

36.4. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 36.2, 36.3-т заасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна. Хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

36.5. Барааг 1.1-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль тохиромжтой хэлбэрээр тендерийг үнэлж, харьцуулна.

34.6. Олон багцтай тендер шалгаруулалтад хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулахдаа хэд хэдэн багцын комбинацийг авч үзсэний үндсэн дээр хамгийн ашигтай хувилбарыг сонгож болно.

37. Дотоодын давуу эрх

37.1. Захиалагч **ТШӨХ-д** тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй

38. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах

38.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

38.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 20-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 32-ийн дагуу хийсэн тодруулгад үндэслэн захиалагчийн ТООЗ-ны ... –д заасан чадварын шаардлагыг хангасан эсэхэд үндэслэн тодорхойлно. Үнэлгээ ба чадварын шалгуурт заагаагүй шалгуурыг ашиглахгүй.

38.3. “Хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлахад

⁸ Энэ тайлбарыг тендерийн бичиг баримтад үлдээнэ. /Уг өгүүлбэрийг тендерийн бичиг баримтаас хасна/. Тендерийн үнэлгээнд ашиглах тохируулах итгэлцүүр нь техникийн тодорхойлолтын [холбогдох зүйлийн дугаарыг бичнэ үү]-т заасан хэмжээнээс, эсхүл хамгийн сайн ашиглалт, үйл ажиллагааны баталгааны үзүүлэлтийг санал болгосон тендерийн уг хэмжээнээс 1 хувь дутах (илүү гарах) бүрт [дүн, тендерийн үнэлгээний валютаар] тооцно. Бүхэл хувь хүрэхгүй бол энэ дүнг мөн харьцаагаар бууруулна.

шаардлага хангасан тохиодолд гэрээ байгуулах эрх олгоно. Харин шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан дараагийн сайн гэж үнэлэгдсэн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

39. Захиалагчтай харилцах

39.1 Тендерийг нээснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд тендерт оролцогч нь захиалагчтай аливаа асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана.

39.2 Тендерт оролцогчийн зүгээс захиалагчид тендерийн үнэлгээний явцад болон гэрээ байгуулах эрх олгоход нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.

Е. ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДВАР, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

40. Гэрээг хэрэгжүүлэх чадвар

40.1 Захиалагч ТООЗ-ны 5 дугаар зүйлийн дагуу шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч (ТООЗ-ны 5.1 (а) зүйлийн **ТШӨХ-д** заасан шалгуурыг хангасан түншлэлийн гишүүд болон аливаа туслан гүйцэтгэгчийг оролцуулан)-ийг гэрээг хэрэгжүүлэх чадвартай гэж тодорхойлно.

Энэ тендерийн баримт бичигт хамаарах гэрээнд зориулж урьдчилсан сонголт явуулсан бол хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн чадварт гэрээг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй томоохон өөрчлөлт урьдчилсан сонголтын дараа гарсан эсэхийг захиалагч тогтооно.

40.2. ТООЗ-ны 5 ба 15 дугаар зүйл мөн **ТШӨХ-д** нэмж зааснаар, тендерт оролцогчийн санхүүгийн, техникийн болон загвар дизайн, нэгтгэл, нэмэлт тохируулга, үйлдвэрлэл, удирдлага зохион байгуулалтын чадварын түвшинг тодорхойлохдоо тендерт оролцогчийн чадварыг нотлох баримт болон захиалагчийн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн холбогдох бусад мэдээлэлд үндэслэнэ.

Ийнхүү тодорхойлохдоо энэ тендертэй холбоотой тендерт оролцогчийн үйлчлүүлэгчидтэй очиж уулзах, газар дээр нь шалгах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Түүнчлэн, хэрэв захиалагч чадварыг дахин нягтлах үед санал болгож буй мэдээллийн систем нь гүйцэтгэл болон үйл ажиллагааны хувьд ТШ-д нийцсэн эсэхийг тодорхойлохын тулд сорил/тест/ хийх бол энэ тухай **ТШӨХ-д** тусгана.

40.3 Хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин нягтлан шаардлага хангасан тохиодолд гэрээ байгуулах эрх олгоно. Харин шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан дараагийн сайн гэж үнэлэгдсэн тендерт оролцогчийн чадварыг нягтална.

41. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

41.1 ТООЗ-ны 36 дүгээр зүйлийг харгалзан, захиалагч нь хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн, ТООЗ-ны 30 дүгээр зүйлийн дагуу гэрээ хэрэгжүүлэх чадвартай гэж тодорхойлсон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

41.2 Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, "Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

42. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

42.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж тендерт шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид шийдвэр гаргасан өдөрт багтаан нэгэн зэрэг бичгээр тэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

42.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно.

42.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 44 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 43 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.

42.4. Захиалагч нь засгийн газрын худалдан авах цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараахь мэдээллийн хамтаар нийтэлнэ:

- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр үнийн санал;
- 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- 5) Тендерт шалгарагчийн нэр, түүний санал болгосон үнэ, түүнчлэн батлагдсан гэрээний дүн.

42.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

42.6. Тендерт шалгарсан оролцогч ТӨӨЗ-ын 44 зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа болон гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсний дараагаар захиалагч ТӨӨЗ-ын 22.4 заасан тендерийн баталгааг цуцлах талаар шалгараагүй оролцогч нарт мэдэгдэнэ.

43. Гэрээнд гарын үсэг зурах

43.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт тендерт шалгарсан оролцогчид илгээнэ.

43.2. Тендерт шалгарсан оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа **ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн** дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

43.3. Захиалагч нь тендерт шалгарсан оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

44. Гүйцэтгэлийн баталгаа

44.1. Тендерт шалгарсан оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор гэрээний тусгай нөхцөлд

заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягтаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.

44.2. Гүйцэтгэлийн баталгааг:

- (а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар, эсхүл
- (б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.

44.3. Тендерт шалгарсан оролцогч ТООЗ-ны 41.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

45. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх

45.1. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг **ТШӨХ-д** заасан өсгөж, бууруулах хувиар өөрчлөх эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендерийн дагуу худалдан авах Системийн талаарх дор дурдсан тусгайлсан өгөгдөлүүд нь тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТӨӨЗ)-ны холбогдох зүйл, заалтуудыг тодотгох, нөхөн гүйцээх болон нэмэлт өөрчлөлт оруулах зорилготой. Тендер шалгаруулалтын өгөгдөлийн хүснэгт (ТШӨХ) болон ТӨӨЗ-ны заалтууд хоорондоо зөрчилдвөл ТШӨХ-ийн заалтуудыг баримтална.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, Засгийн газрын-ын XII байр
ТӨӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх Тендерийн дугаар: МХЕГ/202010020
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө
Б. Тендерийн баримт бичиг	
ТӨӨЗ 9.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, Засгийн газрын XII байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн С.Болор-Эрдэнэ, утас: 51-264261
ТӨӨЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хуанлийн 3 хоногоос багагүй байна. Тодруулгын хариуг хүсэлт ирүүлсэн хаягаар /цахимаар, албан бичгээр/ хүргүүлнэ.
В. Тендер бэлтгэх	
ТӨӨЗ 13.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна.
ТӨӨЗ 14.1 (д)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none">1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.2. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлнэ.3. Тендерийн маягтыг ТББ-т заасан МАЯГТ №: ТМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.4. Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага болон одоо хэрэгжиж буй гэрээний мэдээллийг МАЯГТ №: ТМ-2-ын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.5. Ажиллах хүчний чадавхийн талаарх мэдээллийг МАЯГТ №: ТМ-3-ын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.6. Шүүхийн төрөлжсөн архивийн лавлагаа ирүүлэх;7. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар /өртэй эсэх/ цахим тодорхойлолт ирүүлэх;8. Харилцагч бүх банкны тодорхойлолт /Хугацаа хэтэрсэн өртэй эсэх/

	<p>9. Мэдээллийн системийн тендерийн баримт бичигт нийцсэн эсэхийг тогтоох баримт бичиг.</p> <p>10. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>11. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материалын бичвэр тод, гаргацтай байх шаардлагатай.</p> <p>ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 15.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй” .
ТӨӨЗ 17.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна.”
ТӨӨЗ 18.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТӨӨЗ 20.1(б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “Шаардлагатай”
ТӨӨЗ 20.1(г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он.
ТӨӨЗ 20.2(а)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь 12,500,000 /арван хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс багагүй байх.
ТӨӨЗ 20.2(б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он.
ТӨӨЗ 20.2(в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: шаардлагагүй
ТӨӨЗ 20.2(г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 6,250,000 /зургаан сая хоёр зуун тавин мянган/ төгрөг байна.
ТӨӨЗ 20.2(д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: : Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он.
ТӨӨЗ 20.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”
ТӨӨЗ 23.1	Тендер хүчинтэй байх хугацаа нь 30 хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 22.1	Тендерийн баталгааны үнийн дүн: 500,000 /таван зуун мянган/ Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 11 дүгээр сарын 26-ний өдөр
ТӨӨЗ 24.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: 1
Г. Тендер ирүүлэх	
ТӨӨЗ 25.3	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, Засгийн газрын XII байр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨӨЗ 25.3	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх. Тендерийн дугаар: МХЕГ/202010020 Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.

ТӨӨЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТӨӨЗ 29.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, Засгийн газрын XII байр Давхар болон өрөөний дугаар: Засгийн газрын XII байр, 2 дугаар давхар, 226 тоот хурлын танхим. Аймаг, хот: Улаанбаатар хот Утас: 51-264261 Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨӨЗ 37.1	Дотоодын давуу эрхийн зөрүүг үнэлгээнд “харгалзахгүй” .

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

Тендер шалгаруулалтын маягтыг бөглөх санамж

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, үнийн хуваарийг бөглөж, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Арифметик алдаа, хүлээн зөвшөөрөгдөх зөрүү (төлбөрийн хуваарь, барааг хүргэх хуваарь гэх мэт), сэлбэг болон барааны тоо ширхэгийг тендерийн баримт бичгийн дагуу залруулж, өөрчилсний дараа гэрээний маягтад гарын үсэг зурна.

Тендерт шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]** төрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.

2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш **[тоо]** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.

3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт **[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үүнд хэрэглэх аргачлалыг хэрэглэх талаарх саналаа оруул]** үзүүлнэ.

4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **[тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.

5. Бид, энэхүү тендерийн дагуу нийлүүлэгдэх бараа болон бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон тендерийн хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.

6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

7. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ТУСГАЙ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТУРШЛАГА

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

3.5.3.а. маягтын дагуу тендерт оролцогч ТООЗ-ны 6.1 (а)-д харгалзан ТШӨ-д заасан хугацаанд, заасан тоо хэмжээгээр тендерийн баримт бичигт тодорхойлсонтой ойролцоо, ижил төрлийн мэдээллийн системийн гэрээ гүйцэтгэсэн туршлагыг харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг гэрээ тус бүрээр ирүүлнэ. Түншлэлийн гишүүн бүр энэ маягтыг өөрийн гүйцэтгэсэн холбогдох гэрээ тус бүрээр ирүүлнэ. Бүрэн хэрэгжиж дууссан болон заасан хугацаанаас өмнө хэрэгжиж байгаа гэрээний дүнг төгрөгөөр илэрхийлж бөглөнө.

3.5.3.А ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН ТУРШЛАГА

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	Мэдээллийн системийн уг сурвалж болон ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлогууд	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэл дэх хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн:	
7.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
8.	Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн мэдээллийн системийн дундаж хувийн жин, тухайн мэдээллийн системийн уг сурвалжийг тусгах.	

3.5.4 НЭГДСЭН ХҮСНЭГТ: ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээгээ хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Мэдээллийн системийн үнийн дүн (төгрөг)	Дуусгавар болох төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх дүнгийн сарын дундаж (₮/сар)
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЧАДАВХИ

Тендерт оролцогчийн нэр

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллах холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаар мэдээллийг 3.5.6а маягтад тус тусад ирүүлнэ.

Тендерт оролцогч нь хувилбарт удирдлага, хэрэгжилтийн зохион байгуулалтын хүрээнд ажиллах голлох ажлын хүчний туршлагын талаар мэдээллийг мөн ирүүлнэ.

1.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
2.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
3.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр

3.5.6А НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Тендерт оролцогчийн нэр

Албан тушаал		Нэр дэвшигч <input type="checkbox"/> Үндсэн <input type="checkbox"/> Хувилбарт
Нэр дэвшигчийн мэдээлэл	Нэр дэвшигчийн нэр	Төрсөн огноо
	Мэргэжлийн ур чадвар	
Одоогийн ажил эрхлэлтийн байдал	Ажил олгогчийн нэр	
	Ажил олгогчийн хаяг	
	Утас	Холбоо барих (удирдлага / ажилтан)
	Факс	Телекс
	Нэр дэвшигчийн албан тушаал	Тухайн ажил олгогчид ажилласан жил

Төслийг гүйцэтгэхтэй холбогдох тусгай техникийн болон удирдлагын сүүлийн 2 жилийн байдлаар мэргэжлийн туршлагыг он дараалуулан бичнэ.

Эхэлсэн	Дууссан	Компани/төсөл/ холбогдох техникийн болон удирдлагын туршлага

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.
- (3) төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ. Төлбөр төлөх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

Энэхүү баталгаа нь **[огноог оруул]** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыг үндэслэн баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.
- (3) төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй Засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ. Засгийн газрын бонд шилжүүлэх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

Энэхүү баталгаа нь **[огноог оруул]** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржидмэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийнтамга

Огноо:

Хаяг:

5. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тооогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлж, суурилуулж, ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-нээс _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

- (а) Энэхүү гэрээ болон түүний хавсралтууд
- (б) Гэрээний тусгай нөхцөл
- (в) Гэрээний ерөнхий нөхцөл
- (г) Техникийн шаардлага (Хэрэгжүүлэх хуваарь-ийг оролцуулан)
- (д) Нийлүүлэгчийн ирүүлсэн тендер, үнийн хуваарь
- (е) **[нэмж оруулах: аливаа шаардлагатай баримт бичиг]**

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1 Нийлүүлэгчийн төлөөлөгч
- Хавсралт 2 Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид
- Хавсралт 3 Программ хангамжийн төрөл
- Хавсралт 4 Тусгайлсан бичиг баримт
- Хавсралт 5 Шинэчилсэн үнийн хуваарь (хэрэв байгаа бол)
- Хавсралт 6 Гэрээнд өөрчлөлт оруулахаар харилцан эцэслэсэн хэлэлцээр

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

Хавсралт 1. Нийлүүлэгчийн төлөөлөгч

ГЕН-ийн 1.1(б)(iv)-ийн дагуу нийлүүлэгчийн томилсон Төлөөлөгч:

Нэр: [оруулах: **Нэр**, эсхүл, заах: **“Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дотор томилно.”**]

Албан тушаал: [оруулах: **албан тушаал**, эсхүл заах: **“Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дотор тодорхойлно.”**]

Хавсралт 2. Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид

[тодорхойлох: **гүйцэтгэх ажил, зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид, тэдгээрийн бүртгэгдсэн газар болон гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай захиалагчийн зөвшөөрсөн бусад мэдээлэл. шаардлагатай бол хуудас нэмэх**]

Гүйцэтгэх ажил	Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгч	Бүртгэгдсэн газар

Хавсралт 3. Программ хангамжийн төрөл

Дараах хүснэгтэд гэрээний дагуу нийлүүлж, суурилуулах программ хангамж бүрийг (i) системийн программ хангамж, (ii) үндсэн программ хангамж, (iii) хэрэглээний программ хангамж гэсэн 3 төрөлд, мөн (i) стандарт программ хангамж, (ii) тусгайлсан программ хангамж гэсэн 2 төрөлд тус тус хувааж бөглөнө.

Программ хангамжийн нэр	(аль нэгийг сонгох)			(аль нэгийг сонгох)	
	Системийн программ хангамж	Үндсэн программ хангамж	Хэрэглээний программ хангамж	Стандарт программ хангамж	Тусгайлсан программ хангамж

Хавсралт 4. Тусгайлсан бичиг баримт

Дараах хүснэгтэд гэрээний дагуу нийлүүлэгчийн хүргүүлэх тусгайлсан бичиг баримтуудыг жагсаана.

Тусгайлсан бичиг баримтууд

Хавсралт 5. Шинэчилсэн үнийн хуваарь

Шинэчилсэн үнийн хуваарь нь (хэрэв өөрөөр заагаагүй бол) гэрээний нэг хэсэг болох бөгөөд нийлүүлэгчийн ирүүлсэн тендер дэх үнийн хуваариас ялгаатай байвал түүнийг

орлоно. Энэ шинэчилсэн үнийн хуваарь нь ТООЗ-ны 18.3, 26.2, болон 33.1 дүгээр зүйлд заасны дагуу аливаа залруулга, тохируулгыг тусгана.

Хавсралт 6. Гэрээнд өөрчлөлт оруулахаар харилцан эцэслэсэн хэлэлцээр

Гэрээний өөрчлөлт (хэрэв өөрөөр заагаагүй бол) нь хэрэв ГЕН, ГТН болон техникийн шаардлагаас ялгаатай байвал түүнийг орлох ба ГЕН-ийн 1.1 (а) (ii)-д заасны дагуу гэрээний хэсэг болно.

7. СУУРИЛАЛТЫН БОЛОН АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭН АВАХ ГЭРЧИЛГЭЭ

7.1 СУУРИЛУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ МАЯГТ

Огноо:

Тендерийн урилгын дугаар:

Гэрээний нэр, дугаар:

Хаана, хэнд: *[оруулах: Тендерт оролцогчийн нэр хаяг]*

[оруулах: гэрээ байгуулагдсан өдөр]-ны өдөр *[оруулах: Мэдээллийн системийн товч тодорхойлолт]*-ын *[оруулах: захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх) –тай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 26 дугаар зүйлийн дагуу (Системийн суурилуулалт) систем (эсхүл дэд систем, эсхүл системийн дийлэнх хэсэг) –ийн суурилуулалтын ажил дор дурдсан өдөр бүрэн гүйцэд хийгдэж дууссаныг танайд үүгээр баталгаажуулж байна.

1. Систем (эсхүл дэд систем, эсхүл системийн дийлэнх хэсэг)-ийн тодорхойлолт:

[оруулах: тодорхойлолт]

2. Суурилуулалт дууссан өдөр: *[оруулах: огноо]*

Энэ гэрчилгээнд хавсаргасан ажлыг бүрэн гүйцэт биелүүлсэн байх шаардлагатай. Энэ батламж нь гэрээний дагуу системийг ашиглалтанд хүлээлгэн өгөх болон баталгаат засварын хугацаанд биелүүлэх танай аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

Захиалагчийг төлөөлж:

Гарын үсэг:

Огноо:

Эрх бүхий ажилтан: *[оруулах: “Төслийн удирдагч” эсхүл, заах: захиалагч байгууллагын удирдах албан тушаалтан]*

7.2 АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

Огноо:
Тендерийн урилгын дугаар:
Гэрээний нэр, дугаар:

Хаана, хэнд: *[оруулах: Тендерт оролцогчийн нэр хаяг]*

[оруулах: гэрээ байгуулагдсан өдөр]-ны өдөр *[оруулах: Мэдээллийн системийн товч тодорхойлолт]*-ын *[оруулах: захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх) –тай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 27 дугаар зүйлийн дагуу (Системийн туршилт, ашиглалтанд хүлээн авах) систем (эсхүл дэд систем, эсхүл системийн дийлэнх хэсэг) –ийн гэрээнд заасан ашиглалтанд хүлээн авах туршилт амжилттай хийгдэж дууссаныг танайд үүгээр баталгаажуулж байна. Гэрээний нөхцөлийн дагуу захиалагч нь дор дурдсан өдрөөс систем (эсхүл дэд систем, эсхүл системийн дийлэнх хэсэг) –ийг хяналт, хамгаалалт болон бүрэн бүтэн байдлыг хариуцах үүргийг хүлээн авч байна.

1. Систем (эсхүл дэд систем, эсхүл системийн дийлэнх хэсэг)-ийн тодорхойлолт:
[оруулах: тодорхойлолт]

2. Ашиглалтанд хүлээн авсан өдөр: *[оруулах: огноо]*

Гарын үсэг:

Огноо:

Эрх бүхий ажилтан: *[оруулах: “Төслийн удирдагч” эсхүл, заах: захиалагч байгууллагын дээд удирдлагын албан тушаалтан]*

ХОЁРДУГААР ХЭСЭГ

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ”-ИЙН ТЕХНИКИЙН БОЛОН БУСАД ШААРДЛАГА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.17-д “мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болгох, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй холбох”, Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэржилт 21:100” Үндэсний хөтөлбөрийн Зорилт 2-т “Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хянах мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээг бий болгох”, Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” Үндэсний хөтөлбөрийн 3.3.1-т “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэлийг боловсронгуй болгох”, хөтөлбөрийн 3.3.2-т “хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах, ул мөрийг мөрдөн тогтоох мэдээллийн цахим сан бий болгох” гэж тус тус заасан болно.

Монгол Улсын “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2013 оны “Заавар батлах тухай” 37 дугаар тушаал, 2014 оны “Заавар батлах тухай” 129 тушаалаар тус тус батлан мөрдөж байна.

Цаашид шаардлага хангасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх программ, мэдээллийн сан бий болсноор хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд түүнийг буцаан болон татан авах, тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, ул мөрийг мөрдөн мөшгөх тогтолцоог хянах нөхцөл бүрдэх юм.

Мөн хүнсийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, савлах, шошголох, хадгалах, тээвэрлэх, худалдах, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, импортлох, экспортлох бүх үе шатанд аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтыг нэвтрүүлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хоол хүнснээс шалтгаалсан хордлого, халдварыг бууруулахаас гадна хүнсний аюулгүй байдал хангагдах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болох юм.

Иймд дээр дурдсан хуулиудын хэрэгжилтийг хангуулах, бусад программын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуй нэгжид хүртээмжтэй, ил тод хүргэх зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн системийг шинэчлэх шаардлагатай байна.

Системийн ерөнхий шаардлага

- Вэб технологи суурьтай программ хангамж /онлайн/
- Мэргэжлийн хяналтын байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний цахим системд өгөгдөл гаргаж өгөх боломжит API сервистэй байх.
- Real time Notification буюу мэдэгдлийн боломжтой байх.
- Өндөр түвшний хамгаалалтын шийдлүүдтэй байх.
- Нэмэлт тоног төхөөрөмж шаардагдахгүй байх.
- Бүх модулиуд, интерфэйсүүдийг Монгол хэл дээр хөгжүүлсэн байх.
- Windows7 болон түүнээс дээш үйлдлийн систем дээр алдаагүй ажилладаг байх.
- Түгээмэл ашиглагддаг интернэт хөтөч дээр алдаагүй, эвдрэлгүй ажилладаг байх..
- Системийн харагдац хялбар, хэрэглэхэд хялбар шийдэлтэй, хэрэглэгчийн дэлгэцний хэмжээг ашигтайгаар зохион байгуулсан байх.
- E-Mongolia (ДАН) танилт нэвтрэлтийн системээр иргэн болон хуулийн этгээдийн мэдээллийг баталгаажуулан бүртгэл хийдэг байх.

Техник хангамжийн хувьд:

1	Интернэт болон аюулгүй байдал	сүлжээ аюулгүй	- Гадны халдлагаас хамгаалагдсан байх - Ажлын байрнаас гадна бусад газруудаас хандах боломжтой байх - Сервер архивлалт, back-up өдөр тутам хийдэг байх - Систем сэргээлт түргэн найдвартай байх - Сервес үйлчилгээг тогтмол үзүүлдэг байх - Системд нэвтэрсэн хэрэглэгчийн IP хаяг, компьютерийн нэр зэрэг мэдээллийн бүртгэдэг байх
2	Сервер чадал	хүчин	- Үндэсний дата төв-д сервер байрлах нь давуу тал болно. - МХЕГ-ын сервер дээр нөөц хувь ажиллах боломжтой байх

Б.СИСТЕМИЙН ШААРДЛАГА

1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ

1.1 Хамрах хүрээ

Мэргэжлийн хяналтын байгууллагаас хүнсний аюулгүй байдлын хяналтыг 21 аймаг, нийслэлд 200 гаруй улсын /ахлах/ байцаагчид хэрэгжүүлж байна.

Тус системд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч давхардсан тоогоор 350000 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийн бүртгэлийг хөтлөн, мэдээллийн сан бий болно.

1.2. Үндсэн шаардлага

Шаардлагын дугаар	Шаардлагын тодорхойлолт
ADM	Администраторын систем
CMS	Агуулга удирдах систем

REG	Хэрэглэгчийн бүртгэлийн систем, хандалтын түвшин
LES	Бүртгэл, лавлагаа, үйлчилгээний мэдээлэл
CDB	Гадаад холболт, солилцох мэдээлэл урсгалын систем
DES	Вэбийн дизайн
LANG	Хэлний сонголт
SEO	Хайлтын систем
ODB	Мэдээллийн агуулга ба хэрэглээний шийдэл

1.2.1. Администраторын систем /ADM/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Хэрэглэгчийн бүртгэл, хэрэглэгчийн нэвтрэх зөвшөөрөл, тохиргоо	Хэрэглэгч бүртгэх үйл ажиллагааг идэвхитэй болгох, идэвхигүй болгох, нэвтрэх формыг идэвхижүүлэх, хаах зэрэг үйлдлийг гүйцэтгэнэ.
2	M	Системийн тохиргоо	Портал системд засвар хийх үед мэдээлэх хуудас гаргах, мета тохиргоог хийх, портал системийн нэршил өөрчлөх, хайлтын системд нийцтэй тохиргоо хийх зэрэг үйлдэл гүйцэтгэнэ.
3	M	Статистик тайлангууд гаргах	Мэдээллийн статистик, хэрэглэгчид болон зочдын хандалт, авсан үйлчилгээний нэр, төрөл, хэрэглэгчийн бүртгэлийн мэдээлэл, шийдвэрлэлтийн хугацаа, төлөв, статистик гаргахдаа холбогдож буй төхөөрөмжийн төрөл мэтээр ялгах боломжтой үйлдлийг гүйцэтгэнэ.
4	M	Нууцлал, хамгааллын тохиргоо	Файл дамжуулалт, администраторын нэвтэрсэн огноо харуулах
5	M	Электрон шуудангийн тохиргоо	Портал систем шинээр бүртгэгдсэн хэрэглэгчид илгээх электрон шуудан, мартсан нууц үг, хэрэглэгчийн нэр сэргээхэд илгээх электрон шуудан, шинэ мэдээ, мэдээллийн талаарх электрон шууданг илгээх зэрэг үйлдлийг автоматаар хийх, огноо тохируулах зэрэг тохиргоо хийнэ.
6	M	Олон нийтийн үйлчилгээг удирдах удирдлага	Social Network-уудтай холбогдон ажил-лах нөхцөлийг удирдах бүхий л боломжоор хангагдсан байх бөгөөд ерөнхий зарчим нь www.facebook.com сайттай төстэй байна.

1.2.2. Агуулга удирдах систем /CMS/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Агуулга удирдах системд өөр хаягаар нэвтэрдэг байх	
2	M	Мэдээллийн удирдлагатай байх	Хэрэглэгчийн оруулсан "Хүсэлтийн форм"-оор оруулсан мэдээллийг харах, төлөв оруулах, талбар бичиж буцааж илгээдэг байх Мэдээллийн бүрээр ангиллаж статистик мэдээлэл гаргадаг хугацааны болон бүр төрлийн зааглалт хийж өгдөг байх

3	M	Хэрэглэгчийн удирдлагатай байх	Хэрэглэгчийн жагсаалттай, жагсаалтаас үндсэн мэдээлэл харагддаг байх, шинээр хэрэглэгч нэмэх, хэрэглэгчийн мэдээллийг засварлах, устгах, хандах түвшинг сонгох зэрэг үйлдэл гүйцэтгэдэг байх.
4	M	Хүсэлтийн удирдлагатай байх	Шинээр цэс үүсгэх, цэсийг засварлах, цэсний байрлалыг сонгох, хандалтын түвшинд хязгаарлалттай харагдуулах тохиргоо хийх зэрэг үйлдлийг гүйцэтгэнэ.
5	M	Модулийн удирдлагатай байх	Сайтын төлөвлөгдсөн байрлалд шинээр модуль нэмэх, засварлах, хасах, модулийн агуулгыг тодорхойлох зэрэг үйлдлийг гүйцэтгэнэ.
6	M	Баннер, зар сурталчилгааны удирдлагатай байх	Зар, сурталчилгаа шинээр оруулах, засварлах, устгах, хугацаатайгаар оруулах, зар байрлуулах үйлчлүүлэгчийг сонгох, сурталчилгаан дээр дарсан хандалтын статистик гаргадаг, төлбөр, тооцоог бодох үйлдлийг гүйцэтгэнэ.
7	M	Электрон шуудангийн удирдлагатай байх	Портал системийн нийт бүртгэлтэй хэрэглэгчдэд шинээр оруулсан мэдээ, мэдээллийн талаар электрон шуудангаар автоматаар мэдээлдэг байх, илгээгдсэн болон ирсэн электрон шуудангийн жагсаалттай, шинээр электрон шуудан илгээх, устгах, засварлах үйлдэлтэй байна.
8	M	Хэлэлцүүлгийн удирдлагатай байх	Сайтад гишүүнчлэлтэй хэрэглэгчид хэлэлцүүлэг үүсгэн санал авдаг байна. Үүсгэсэн хэлэлцүүлэг, хичнээн гишүүн оролцсон зэргийг тайлагнадаг, хэлэлцүүлгийг үүсгэх, устгах, идэвхигүй болгох, засах, гишүүнд хэлэлцүүлэг өрнүүлэх эрх олгодог байх зэрэг удирдлагатай байна.
9	M	Санал асуулгын удирдлагатай байх	Санал асуулга үүсгэх, сонгох саналыг оруулах формтой, хэд хэдэн санал асуулга өрнүүлэх зэрэг боломжтой байна. Мөн санал асуулгыг устгах, шинэчлэх, өөрчлөх, хураагдсан саналыг тэглэх зэрэг үйлдэлтэй байна. Санал асуулгын хугацааг тохируулдаг байна. Санал асуулга бүрээр үр дүн тайланг харуулдаг байна.
10	M	Вэб холбоосын удирдлагатай байх	Вэб лавлах буланд харуулах вэб хуудсуудыг оруулах, устгах, шинэчлэх зэрэг үйлдэлтэй. Вэб хуудас оруулахад нэр, байгууллага, холбоос, зураг, тодорхойлолт, идэвхитэй эсэх гэсэн формуудыг бөглөдөг байна.

1.2.3 Хэрэглэгчийн бүртгэл хүсэлтийн систем, хандалтын түвшин /REG/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Хэрэглэгчийн бүртгэлийн формтой байх	
2	M	Нүүр хуудас дахь бүртгэлийн форм нь	Логин нэвтрэх хэсэгтэй Хэрэглэгчийн сэтгэгдэл урсах хэсэгтэй /сэтгэгдэлийг админ хянаж байх боломжтой байх/ Хэрэглэгчийн цахим систем хөгжүүлэгч болон хэрэглэгч байгууллагын мэдээлэл байх

			Мэдээллийн баннар оруулж өгөх хэсэгтэй байх Холбогдох төрийн байгууллагын мэдээллийг үзэх шилждэг хэсэгтэй байх
3	M	Нэвтрэх хэсэг Хэрэглэгчийг бүртгэхдээ үндсэн мэдээллүүдийг заавал оруулдаг байх	“Дан” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем, Гар утасны дугаар болон тоон гарын үсэг ашиглан бүртгүүлсэн хэрэглэгч нэвтрэх боломжтой байх. Нэвтрэн орсон хэрэглэгчид өмнө нь авч байсан үйлчилгээний мэдээлэл, гаргасан хүсэлт хаана ямар шатандаа явааг харуулдаг байх
4	M	Хүсэлт гаргах формтой байх /сонгогдсон/	Тухайн гаргасан хүсэлттэй холбоотой анхаарах асуудал, шийдвэрлэх хугацаа, ямар тохиолдол хүлээн авсан материалыг буцаах, хэрэглэгчийн санал сэтгэгдэлийг авах гарцын мэдээлэл зэрэг байх ААН, иргэний оноосон нэр, регистрийн дугаар оруулдаг Үндсэн мэдээллээс регистрийн дугаараар дуудаж мэдээллийг авдаг байх Энэ хэсэгт заавал оруулж өгөх хэсгийн өнгөөр ялгаж * оор тэмдэглэх
5	M	Хүсэлт шийдвэрлэх үе шат	Хэрэглэгч хүсэлт гаргах формыг бөглөхөөс эхлүүлэн хийгдэж байгаа үе шат бүрийг харуулсан хэсэгтэй байх Хийгдсэн хэсэг нь үндсэн өнгөнөөс өөрөөр болж шилждэг байх Хүсэлтийн төрлөөс хамаарч өөр өөр байх тул тооцох Үе шат бүрт нийцсэн тухай үйл ажиллагаатай холбоотой icon дүрс зураг байх /өнгө GRAY -20%-иас бага байх/
6	M	Хэрэглэгчийн хандалтын түвшинд харгалзах хүрээ	

1.2.4. Бүртгэл, лавлагаа, үйлчилгээний мэдээлэл /LES/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable – Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Хайлт	Ухаалаг хайлтын арга нь агуулга сонгох сонголттой байж болох бөгөөд аль болох тохиргоо бага хийдэг байх ёстой.
2	M	Жагсаалт	Системээр гаргасан хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар иргэн, аж ахуй нэгжийн нэр, өмчийн хэлбэр, гаргасан хүсэлтийн тэргүү, төлөв, хугацаа, тайлбар гэсэн хүснэгтэн мэдээллийн нээлттэйгээр харах боломжтой байх
3	M	Төлөв	ААН, иргэдийн гаргасан хүсэлтийн шийдвэрлэлт, явцын талаар хүлээн авсан ажилтан өөрийн удирдлагын хэсгээс төлөв, тайлбар оруулахад мэдээлэл нь харагддаг байх
4	M	Явцын мэдээлэл харах	Гаргасан хүсэлт бүрт өөрийн гэсэн код өгөгдөх бөгөөд өгөгдсөн кодоор хайлт хийхэд ямар үе шатандаа явааг харах боломжтой хялбар байх

1.2.5 Гадаад холболт, солилцох мэдээлэл урсгалын систем /CDB/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /DI/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
---	-----	-----------	-----------

1	M	Төлбөрийн системтэй байх	Холбогдох хүсэлтийн шийдвэрлэлтэд хуулийн дагуу авах төлбөрийг хэрэглэгч хүсэлт гаргах явцаж тухай дансанд төлбөрийг цахим хэлбэрээр төлж барагдуулах боломжтой байх, төлбөр төлсөн мэдээллийг хариуцсан ажилтан татаж харж болдог байх
2	M	“ХУР” системээс шаардлагатай мэдээллийн татаж авч тулгалт шалгалт хийдэг байх	ААН, иргэнийн бүртгэлийн мэдээлэл, хүчинтэй хугацаа гэх мэт
4	M	Зөвшөөрлийн үйл ажиллгаанд оролцогч байгууллага нэвтрэх, мэдээлэл оруулах формтой байх	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл, квотын мэдээллийг хариуцсан мэргэжилтэн системд нэвтрэх эрхээр орж урьдчилсан бэлтгэсэн форм бөглөж баталгаажуулалт хийж системд оруулдаг байх

1.2.6 Вэбийн дизайн /DES/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	D	Текстын дизайны удирдлага	Фонтын шрифт, хэмжээ сонгох, сайтын талбаруудад ялгаатай тохиргоо хийдэг байна.
2	M	График дизайны удирдлага	Логоны төрөл сонгох /зураг, флаш/, Модулийн гарчигийн зураг сонгох, сайтын дэвсгэр өнгө, зураг сонгох гэх мэт.
3	M	Дизайн угсрах удирдлага	Талбар сонгох, өөрөө талбаруудын байрлал, хэмжээг сонгон шинэ дизайн үүсгэх үйлдлийг гүйцэтгэнэ.
4	M	Төрийн байгууллагын өнгө төрийг шингээсэн 2-3 өнгөтэй байх	
5	M	Responsive дэмжих	Систем хэрэглэгчийн ашиглаж буй дэлгэцийн хэмжээнээс хамаарч ажиллахад хялбар, орон зайг зөв ашигласан байна;

1.2.7. Хэлний сонголт /LANG/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Хэлний сонголт монгол хэл болон англи хэл байх	Анхдагч сонголт нь монгол хэл байна. /Default language/
2	M	Англи хэлний сонголтын үед англиар орчуулагдсан интерфэйс гарч ирэх бөгөөд англи хэл дээр өгөх шаардлагатай мэдээллүүд харагддаг байх	

1.2.8. Хайлтын систем /SEO/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable – Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Ухаалаг хайлтын систем: Энэ нь утгын хайлт байх бөгөөд үгийн нөхцөл, дагавар, хувирсан байдал мөн ямар агуулгатай мэдээлэлд хамаарагдаж байгаа зэргээс хамгийн оновчтой гэсэн мэдээллүүдийг харуулдаг байх, ухаалаг хайлтын тохирсон аргуудыг хэрэглэсэн байх	Ухаалаг хайлтын арга нь агуулга сонгох сонголттой байж болох бөгөөд аль болох тохиргоо бага хийдэг байх ёстой.
2	M	Тайлангууд: Ухаалаг хайлтын тайлан гаргадаг байх /Хайлтад хэрэглэгдсэн үг, нэвтэрсэн хэрэглэгч, нэвтэрсэн хэрэглэгчид харгалзсан хайлтын утга болон үр дүнгийн тайлангууд/	Өдөр, 7 хоног, сар, жилээр тайланг харуулдаг байна.

1.2.9 Мэдээллийн агуулга ба хэрэглээний шийдэл /ODB/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

№	M/D	Шаардлага	Тэмдэглэл
1	M	Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах шаардлагын стандартыг хангасан байх	Цахим хуудас нь Стандарчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс 2010 онд баталсан "ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДСАНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН СТАНДАРТ" /MNS ISO 8072: 2010/-Д үндэслэн, хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар, өргөн агуулгатай байх зарчмыг баримталж, техникийн болон физик хүчин зүйлүүдээс хамаарахгүй динамик байна.
2	M	Олон нийт, харилцан холбоотой ажилладаг байгууллага, хүмүүстэй мэдээлэл солилцох арга замыг бий болгосон байх;	
3	M	Мобайл төхөөрөмжөөс ороход ашиглагддаг тусгай модультай байх;	
4	M	Хэрэглэгчийн оруулах мэдээ, мэдээллийн үсгийн фонтыг Unicode систем хүлээн авах боломжтой байх;	
5	M	Архивлагдсан мэдээллийг үзэх боломжтой байх;	
6	M	Холбогдох бусад байгууллагын мэдээ мэдээлэл, холбоосуудыг агуулсан байх;	
7	M	Хэрэглэгчид шаардлагатай тодорхой төрлийн мэдээллийг татан авах боломжтой байх /маягт, олон нийтэд зориулсан баримт материалууд/;	

8	м	Бусад документ хэлбэрээр /word, excel, pdf/ файл харуулах боломжтой байх;	
9	м	Хурал уулзалтад зориулан бүртгэлийн хэсэгтэй байх;	
10	м	Бусад вэбээс мэдээллийг RSS болон бусад хэлбэрээр авч мэдээлэл нь баяжигддаг байх;	Хянагчийн түвшинд баяжигдсан мэдээллийг шүүж нийтэд мэдээлэх үзүүлэх зөвшөөрлийг өгдөг байх

2. СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

Шаардлагын дугаар	Шаардлагын тодорхойлолт
PPP	Төслийн урьдчилсан төлөвлөгөө
CNC	Програм хангамжийн тохиргоо ба арга
PRF	Чадлын тодорхойлолт
BKU	Нөөцлөлт ба сэргээлт
PSF	Портал системийн програм хангамж
PEC	Портал системийн аюулгүй байдал
TRN	Сургалт
TEC	Техникийн үйлчилгээ
DOC	Баримтжуулалт

2.1 Төслийн урьдчилсан төлөвлөгөө /PPP/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
PPP1	M	Төслийг гүйцэтгэх хугацааг тодорхойлох	7 хоногоор хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулж танилцуулах.
PPP2	D	Төслийн загвар буюу адилтгах системийг танилцуулах	
PPP3	M	Төслийг гүйцэтгэх алхамуудыг тодорхойлох	Баримт боловсруулан танилцуулна.

2.2 Програм хангамжийн тохиргоо ба арга /CNC/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
CNC1	M	Програм хангамжийг серверт тохируулах	Портал сайтыг администраторт эзэмшүүлнэ.
CNC2	D	Програм хангамжийн сайжруулалт буюу update хийх аргыг тодорхойлох	Портал сайтыг администраторт эзэмшүүлнэ.

2.3 Чадлын тодорхойлолт /PRF/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай

/M/ Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
PRF1	M	Серверийн өгөгдөл дамжуулалт	Хугацааны нэг эгшинд хичнээн хандалт хүлээн авах чадалтай

		эсэхийг тодорхойлсон баримт бэлтгэн өгөх, туршин харуулсан байна.
--	--	---

2.4 Нөөцлөлт ба сэргээлт /BKU/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай

/M/ Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
BKU1	M	Системийн нөөцлөлт автоматаар тохируулсан хугацаанд хийгддэг байх	Системийн нөөцлөлтийг хянах аргыг системийн администраторт зааж сургасан байна.
BKU2	M	Нөөцөөс сэргээлт хийх боломжтой байх	Сэргээлт хийх арга зөвлөмжийг боловсруулсан байх бөгөөд системийн администраторт зааж сургасан байна.

2.5 Портал системийн програм хангамж /PSF/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
PSSF1	M	Системийн програм хангамжийг PHP, Java, Javascript гэх мэт орчин үеийн шинэ хэл дээр нээлттэй эхийн технологид тулгуурлан бичсэн байх	Портал сайтыг Java технологи ашиглан бүтээвэл илүү сайн. Сайтыг бүтээхдээ бусад технологиудыг хамтад нь ашиглах юм.
PSSF2	M	Өгөгдлийн сангийн систем нь MySQL, PostgreSQL зэрэг нээлттэй эхийн лицензтэй байх	
PSSF3	D	Програмчлалын технологи нь объект хандалтат байх ба AJAX ашигласан байх	AJAX ашигласнаар хуудас ачаалах нь хурдан болно.
PSSF4	M	Вэб браузер хамааралгүй байх	Ямар ч вэб браузер аас хандахад дизайн болон үйл ажиллагааны хувьд ялгалгүй ажиллана.

2.6 Портал системийн аюулгүй байдал /PES/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
PSEC1	M	Хамгаалалтын програмыг серверт тохируулан суулгах	Системийн файлуудыг скрипт вирусаас хамгаалахад хэрэглэгдэнэ.
PSEC2	M	Програм хангамжийн хувьд аюулгүй байдлыг хангах	Энд вэб систем аюулгүй ажиллахад шаардлагатай бүх хамгаалалтын асуудлууд багтана.

2.7 Сургалт /TRN/

Mandatory – Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
TRN1	M	Сервер удирдах талаар портал сайтын администраторуудад сургалт явуулах	Энэхүү сургалтад портал сайтын администраторууд хамрагдах бөгөөд

			систем администраторт эрхийг шилжүүлнэ.
TRN2	M	Өгөгдлийн сангийн бүтцийг тайлбарласан сургалт явуулах	Энэхүү сургалтад портал сайтын администраторууд хамрагдах бөгөөд систем администраторт эрхийг шилжүүлнэ.
TRN3	M	Сайтын бүтэц, ажиллагааны талаар сургалт явуулах	Энэхүү сургалтад портал сайтын администраторууд хамрагдах бөгөөд портал администраторт эрхийг шилжүүлнэ.
TRN4	M	Сүлжээний бүтэц, хамгаалалт, өргөтгөл зэргийг танилцуулах сургалт явуулах	Энэхүү сургалтад портал сайтын администраторууд хамрагдах бөгөөд сүлжээний администраторт эрх болон баримтыг шилжүүлнэ.

2.8 Техникийн үйлчилгээ /TEC/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
TEC1	M	Портал системийг серверт суурилуулах, өгөгдлийн сантай холбох	Администраторуудтай хамтран гүйцэтгэх
TEC2	M	Баталгаат хугацаанд илэрсэн алдааг засварлах, тохируулах	Администраторуудтай хамтран гүйцэтгэх

2.9 Баримтжуулалт /DOC/

Mandatory - Зайлшгүй шаардлагатай /M/

Desirable - Хэрэгтэй /D/

Дугаар	M/D	Шаардлага	Тэмдэглэл
DOC1	M	Портал системийн хэрэглэгчийн гарын авлага боловсруулах	
DOC2	M	Портал системийн администраторуудын гарын авлагыг боловсруулах	
DOC3	D	Портал системийн боловсруулсан програмчлалын хэл, ашигласан системүүдийн хувилбарууд, тоног төхөөрөмжийн үзүүлэлт зэргийг тусгасан танилцуулга бэлтгэх	

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгаж өгнө.

А. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Нэр томьёо** 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
- (a) гэрээний зүйлс
- (i) “Гэрээ” гэж захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээ хэлцэл, үүнд хамаарах гэрээний баримт бичгүүдийг хэлнэ. Гэрээ хэлцэл, гэрээний бүх баримт бичгүүдийг хамтад нь гэрээ гэсэн өргөн утгаар ойлгоно.
 - (ii) “Гэрээний баримт бичиг” гэж гэрээний маягтын 1.1 дүгээр зүйлд дурдсан баримт бичгүүд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүдийг хэлнэ.
 - (iii) “Гэрээ хэлцэл” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тендерийн баримт бичигт заасан гэрээний маягтын дагуу бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ. Гэрээ байгуулагдсан огноог гарын үсэг зурагдсан гэрээний маягтад заасан байна.
 - (iv) “ГЕН” гэдэг нь гэрээний ерөнхий нөхцөлийн товчилсон нэр болно.
 - (v) “ГТН” гэдэг нь гэрээний тусгай нөхцөлийн товчилсон нэр болно.
 - (vi) “Техникийн шаардлага” гэдэг нь тендерийн баримт бичгийн техникийн шаардлага гэсэн бүлэг болно.
 - (vii) “Хэрэгжүүлэх хуваарь” гэдэг нь техникийн шаардлага бүлгийн Хэрэгжүүлэх хуваарь гэсэн дэд бүлэг болно.
 - (viii) “Гэрээний үнэ” гэж гэрээний маягтын 2 дугаар зүйл (гэрээний үнэ болон төлбөрийн нөхцөл)-д дурдсан үнийг хэлнэ.
 - (ix) “Тендерийн баримт бичиг” гэж тендер шалгаруулалтыг зохион байгуулах, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг сонгох, захиалагч нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах гэрээний загвар, нөхцөл болзлуудыг тусган захиалагчийн боловсруулсан цогц баримт бичгийг хэлнэ. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлүүд, Техникийн шаардлага болон тендерийн баримт бичигт багтсан бусад баримт бичгүүд нь гэрээний удирдлагын явцад мөрдөгдөх дүрэм, зохицуулалт болж мөрдөгдөнө.
- (б) Оролцогч этгээд
- (i) “Захиалагч” гэж ГТН-д заасан мэдээллийн системийг худалдан авагч этгээд эсхүл түүний эрх залгамжлагчийг хэлнэ.
 - (ii) “Төслийн удирдагч” гэж ГЕН-ийн 18.1 дүгээр зүйлд заасаны дагуу захиалагчийн сонгож ГТН-д нэрлэсэн, захиалагчийн төлөөлүүлсэн үүргийг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.
 - (iii) “Нийлүүлэгч” гэж гэрээг гүйцэтгүүлэхээр захиалагчийн хүлээн зөвшөөрсөн тендер ирүүлсэн, гэрээнд дурдсан этгээд эсхүл түүний эрх залгамжлагчийг хэлнэ.
 - (iv) “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж ГЕН-ийн 18.2 дугаар зүйлд заасны дагуу нийлүүлэгч нэр дэвшүүлсэн бөгөөд захиалагч хүлээн зөвшөөрч гэрээнд дурдсан, нийлүүлэгчийн төлөөлүүлсэн үүргийг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.
 - (v) “Туслан гүйцэтгэгч” гэж мэдээллийн системийн болон бусад бараа үйлчилгээ нийлүүлэх, эсхүл зураг төсөл бэлтгэх зэрэг нийлүүлэгчийн үүргийг хэрэгжүүлэхээр нийлүүлэгчтэй шууд болон шууд бусаар туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулсан этгээд эсхүл түүний хууль ёсны залгамжлагчийг хэлнэ.
- (в) Цар хүрээ
- (i) “Мэдээллийн систем” буюу “Систем” гэж гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бүхий л мэдээллийн технологи, материал болон нийлүүлж, угсарч суурилуулж, нэгтгэж ажилд бэлэн болгох (нийлүүлэгчийн тоног ТШӨХөөрөмжөөс гадна) бусад барааг хамтад нь ойлгоно.

- (ii) “Дэд систем” гэж гэрээнд заасан системийн аливаа дэд хэсгийг хэлэх бөгөөд нийт системийн туршилтын үр дүнг хэлэлцэхийн өмнө дэд систем нь нийлүүлэгдэж, суурилуулагдаж, туршилт хийгдэн, урьдчилсан дүгнэлт гаргагдсан байж болно.
- (iii) “Мэдээллийн технологи” гэж нийлүүлэгчийн гэрээний дагуу нийлүүлж суурилуулах шаардлагатай бүхий л мэдээлэл боловсруулалт, техник хангамж, программ хангамж, бараа нийлүүлэлт болон дагалдах зүйлсийг хэлнэ.
- (iv) “Бараа” гэж мэдээллийн технологи, материалаар хязгаарлахгүйгээр гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх эсхүл нийлүүлж суурилуулах шаардлагатай бүх тоног ТШӨХөөрөмж, техник хэрэгсэл, биет материалууд, бусад зүйлсийг хэлнэ. Нийлүүлэгчийн тоног ТШӨХөөрөмжийг үүнд хамааруулахгүй.
- (v) “Үйлчилгээ” гэж нийлүүлэгчийн гэрээний дагуу нийлүүлэх техникийн болон материал хангамж, удирдлага зохион байгуулалт болон аливаа нийлүүлэх, суурилуулах, нэмэлт тохируулга, засвар үйлчилгээ хийх, нэгтгэх болон системийн үйлчилгээг хийхийг хэлнэ. Үйлчилгээ гэдгийг тухайлбал удирдлагын үйл ажиллагаа, баталгаа, батлан даалт, дизайн зураг төсөл, боловсруулалт, нэмэлт тохиргоо, баримтжуулалт, тээвэрлэлт, даатгал, шалгалт, тохируулга, ажлын талбайг бэлтгэх, суурилуулалт, нэгтгэл, сургалт, мэдээлэл суулгах, урьдчилсан шалгалт, туршилтын үр дүнг хэлэлцэх, засвар үйлчилгээ, техник тусламж зэрэг өргөн утгаар ойлгох ба үүгээр мөн хязгаарлагдахгүй.
- (vi) “Ажлын төлөвлөгөө” гэж ГЕН-ийн 19 дүгээр зүйлийн дагуу нийлүүлэгч гэрээний шаардлага болон өөрийн тендерт ирүүлсэн эхний ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж захиалагчаар батлуулсан баримт бичгийг хэлнэ. “Эцэслэн тохиролцсон ажлын төлөвлөгөө” нь ГЕН-ийн 19.2 дугаар зүйлийн дагуу захиалагч зөвшөөрч баталгаажуулсан байна. Ажлын төлөвлөгөө нь гэрээтэй зөрчилдөх тохиолдолд гэрээний холбогдох заалтууд, түүнд орсон нэмэлт өөрчлөлт давуу байна.
- (vii) “Программ хангамж” гэж системийн үндсэн бүрдэл хэсэг бөгөөд тусгай үйлдлийг гүйцэтгэх мэдээлэл боловсруулах дэд системийг хэлнэ.
- (viii) “Системийн программ хангамж” гэж гэрээний Хавсралт 3-т тодорхойлогдсон техник хангамж болон түүний бүрдэл хэсгийн үйлдлийн болон удирдлагыг хангах программ хангамж буюу талууд харилцан бичгээр системийн программ хангамж гэж хүлээн зөвшөөрсөн, бусад программ хангамжийг хэлнэ. Үүнд техник хангамжид суулгасан микро-код (үйлдвэрлэгчийн программ), үйлдлийн системүүд, холболтууд, системийн болон сүлжээний удирдлага, хэрэглээний программ хангамж зэргийг хамруулан ойлгох ба үүгээр мөн хязгаарлагдахгүй.
- (ix) “Үндсэн программ хангамж” гэж оффисын ердийн үйл ажиллагаа, программ хангамж боловсруулалтыг дэмжсэн программ хангамж бөгөөд Гэрээний маягтын Хавсралт 3-т тодорхойлогдсон болон хоёр тал бичгээр Үндсэн программ хангамж гэж тодорхойлсон программ хангамжийг хэлнэ. Эдгээр программ хангамж нь бичгийн, тооцооны хүснэгтүүд болон ерөнхий мэдээллийн баазын удирдлага болон хэрэглээний программ хангамжийг агуулсан байж болох ба үүгээр хязгаарлахгүй.

- (x) “Хэрэглээний программ хангамж” гэж бизнесийн болон техникийн тусгай үйлдэл, интерфэйсийг гүйцэтгэхээр Системийн бизнесийн болон техникийн тусгай хэрэглэгчдэд зориулагдан болосвруулагдсан бөгөөд Гэрээний маягтын Хавсралт 3-т тодорхойлогдсон болон хоёр тал бичгээр тохиролцсон программ хангамжийг хэлнэ.
 - (xi) “Стандарт программ хангамж” гэж гэрээний Хавсралт 3-т тодорхойлогдсон болон талууд харилцан бичгээр стандарт программ хангамж гэж хүлээн зөвшөөрсөн бусад программ хангамжийг хэлнэ.
 - (xii) “Тусгайлсан программ хангамж” гэж гэрээний Хавсралт 3-т тодорхойлогдсон болон талууд харилцан бичгээр тусгайлсан программ хангамж гэж хүлээн зөвшөөрсөн бусад программ хангамжийг хэлнэ.
 - (xiii) “Эх код” гэж программ хангамжийг дамжуулах, гүйцэтгэх, дараагийн засвар үйлчилгээг хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийн баазын бүтэц, толь бичиг, тодорхойлолтууд, программын эх файлууд, аливаа тэмдэгт дүрслэлүүд (ерөнхий буюу тусгайлсан программ хангамжид зориулагдаагүй)-ийг хэлнэ.
 - (xiv) “Бичиг баримт” гэж гэрээний дагуу захиалагчийг хангах аливаа хэвлэмэл болон хэвлэх боломжтой баримт бичиг, бүх төрлийн хэлбэр (дуу болон дүрс бичлэг, бичвэр)-ээр байгаа зааварчилгаа, тайлбар, бусад хэрэгслийг хэлнэ.
 - (xv) “Стандарт бичиг баримт” гэж тусгайлсан бичиг баримт гэж заагаагүй бүх бичиг баримтыг хэлнэ.
 - (xvi) “Тусгайлсан бичиг баримт” гэж гэрээний дагуу захиалагчийн зардлаар нийлүүлэгчийн боловсруулсан, гэрээний маягтын Хавсралт4-т зүйлд тодорхойлсон болон талууд харилцан бичгээр тусгайлсан бичиг баримт гэж хүлээн зөвшөөрсөн бичиг баримтыг хэлнэ. Тусгайлсан бичиг баримт нь стандарт бичиг баримтаас үүссэн бичиг баримтыг агуулна.
 - (xvii) “Оюуны өмчийн эрх” гэж аливаа болон бүхий л зохиогчийн эрх, ёс суртахууны эрх, худалдааны тэмдэг, патент болон бусад оюуны болон өмчийн эрхийг хэлнэ
 - (xviii) “Нийлүүлэгчийн тоног ТШӨХөөрөмж” гэж мэдээллийн технологи болон системийн бүрдэл болох бусад зүйлст орохгүйгээр системийн суурилуулалт, нэгтгэлт болон засвар үйлчилгээнд нийлүүлэгчээс шаардагдах бүх төрлийн тоног ТШӨХөөрөмж, багаж хэрэгсэл бусад зүйлсийг хэлнэ.
- (г) үйл ажиллагаа
- (i) “Хүргэлт” гэж гэрээнд дурдсан тухайн үеийн Инкотермс-ийн нөхцлийн дагуу барааг нийлүүлэгчээс захиалагчид шилжүүлэхийг хэлнэ.
 - (ii) “Суурилуулалт” гэж гэрээнд дурдсан систем болон дэд системийг ГЕН-ийн 26 дугаар зүйлд заасны дагуу туршихад бэлэн болгохыг хэлнэ.
 - (iii) “Урьдчилсан туршилт” гэж нийлүүлэгч ГЕН-ийн 26 дугаар зүйлд (суурилуулалт) заасны дагуу системийг туршихад бэлтгэх буюу техникийн шаардлагын дагуу аливаа шаардлагатай шалгалт, туршилт хийх үйл ажиллагааг хэлнэ.
 - (iv) “Туршилт” гэж системийг ашиглалтанд хүлээн авах шалгалт хийх зорилгоор ГЕН-ийн 27.1 дүгээр зүйлд заасны дагуу нийлүүлэгч суурилагдсан систем болон аливаа дэд системийг ажиллуулж туршихыг хэлнэ.
 - (v) “Ашиглалтанд хүлээн авах шалгалт” гэж техникийн шаардлага болон эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд тодорхойлсон систем, дэд системийн үйл ажиллагаа, функцид тавигдах шаардлагыг бүрэн хангаж буй эсэхийг мэдэх зорилгоор ГЕН-

ийн 27.2 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлэх техникийн шаардлага болон эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан шалгалтыг хэлнэ.

(vi) “Ашиглалтанд хүлээн авах” гэж систем (эсхүл гэрээнд системийг хэсэгчилэн ашиглалтанд хүлээн авахаар заасан бол аливаа дэд системүүдийг) ГЕН-ийн 27.3 дугаар зүйлд заасны дагуу захиалагч хүлээн авахыг хэлнэ.

(д) байршил ба хугацаа

(i) “Нийлүүлэгчийн улс” гэж гэрээнд дурдсан, нийлүүлэгчийн хууль ёсоор үүсгэн байгуулагдсан улсыг хэлнэ.

(ii) “Ажлын талбай” гэж ГТН-д заасан системийг нийлүүлэх, суурилуулах газар(ууд)-ыг хэлнэ.

(iii) “Өдөр” гэж хуанлийн хоногийг хэлнэ.

(iv) “Долоо хоног” гэж Даваа гарагаас эхлэн дараалсан хуанлийн долоон (7) хоногийг хэлнэ.

(v) “Сар” гэж хуанлийн сарыг хэлнэ.

(vi) “Жил” гэж дараалсан арван хоёр (12) сарыг хэлнэ.

(vii) “Хүчин төгөлдөр болох өдөр” гэж систем болон дэд системийг нийлүүлэх, суурилуулах болон ашиглалтанд хүлээн авах өдрийг тодорхойлох зорилгоор гэрээний маягтын 4 дүгээр зүйл (ашиглалтанд хүлээн авах хугацааг тодорхойлох)-д заасан бүх нөхцлийг биелүүлсэн огноог хэлнэ.

(viii) “Гэрээний хугацаа” гэж энэхүү гэрээний дагуу захиалагч нийлүүлэгчийн хооронд системийн холбогдолтой үүрэг хариуцлага, харилцаа үргэлжлэх, ГТН-д заасан хугацааг хэлнэ.

(ix) “Гэмтэл согогыг хариуцах хугацаа” гэж (Баталгаат засварын хугацаа) систем, дэд системийг Ашиглалтанд хүлээн авах гэрчилгээг олгосон өдрөөс хойш нийлүүлэгчийн өгч буй баталгаат засварын хүчинтэй хугацааг хэлэх ба энэ хугацаанд нийлүүлэгч нь ГЕН-ийн 29 дүгээр зүйлийн дагуу систем болоод холбогдох дэд системийн гэмтэл согогыг хариуцна.

(x) “Хамрах хугацаа” гэж засвар үйлчилгээ, техник тусалцаа, бусад үйлчилгээ (хэрэв шаардлагатай бол) хийх боломжтой байх долоо хоногийн өдрүүд, тэдгээр өдрийн цагийг хэлнэ.

2. Гэрээний баримт бичиг

2.1. Гэрээний бүрдэл баримт бичгүүд нь харилцан уялдаатай, нэг нь нөгөөгөө нөхөн гүйцээж тайлбарласан шинжтэй байх бөгөөд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний маягтын 5-р зүйлд бичигдсэн дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

3. Тайлбар

3.1. Хэл

3.1.1. Гэрээний хэл нь гэрээний тусгай нөхцөлд заасан хэл байна. Захиалагч, нийлүүлэгчийн хоорондын аливаа бүхий л харилцаанд гэрээний хэлийг ашиглана.

3.1.2. Нийлүүлэгчийн ирүүлсэн аливаа хэвлэмэл бичиг баримт нь ГЕН-ийн 3.1.1-д заасанаас өөр хэл дээр байх тохиолдолд гэрээний хэл дээр хөрвүүлсэн албан орчуулгыг хамт ирүүлэх бөгөөд Захиалагч уг орчуулгыг баримтална. Орчуулгын зардал, бусад эрсдэлийг эх бичиг баримтыг бэлтгэсэн тал хариуцна.

3.2. Нэг ба олон тоо

Агуулгад харшлахгүй бол ганц тоо нь олон тоог, олон тоо нь ганц тоог илэрхийлж болно.

3.3. Гарчиг

ГЕН-ийн гарчиг ба тодотгосон бичиглэлүүд нь холбогдох заалтыг ашиглахад хялбаршуулах зорилготой бөгөөд гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй.

3.4. Этгээд

Этгээд эсхүл талууд гэдэгт хуулийн этгээд, компани, корпораци болон засгийн газрын байгууллага зэргийг хамруулан ойлгоно.

- 3.5. Инкотермс
Энэ гэрээний заалттай зөрчилдсөнөөс бусад тохиолдолд аливаа худалдааны нөхцөл болон талуудын эрх, үүргийг инкотермс-д тодорхойлсноор тайлбарлана. Инкотермс гэдэг нь Парис дахь Олон улсын худалдааны танхимын гаргасан худалдааны нөхцлүүдийг зохицуулах олон улсын дүрэм /сүүлчийн хэвлэл/ юм.
- 3.6. Үндсэн тохиролцоо
Энэ гэрээ нь захиалагч нийлүүлэгч хоёрын хооронд хийгдсэн бүх тохиролцоог илэрхийлэх буюу гэрээ байгуулагдахаас өмнөх талуудын хооронд хийгдсэн бүх харилцаа, хэлэлцээ, тохиролцоог (амаар болон бичгээр) орлоно.
- 3.7. Нэмэлт өөрчлөлт
Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж, огноо тавигдаж, энэ гэрээнд тодорхой хамааруулан, талуудын төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажсан тохиолдолд хүчин төгөлдөр болно.
- 3.8. Бие даасан нийлүүлэгч
Нийлүүлэгч нь гэрээг гүйцэтгэхдээ бие даасан байна. Гэрээгээр гэрээний талуудын хооронд аливаа байгууллага, түншлэл эсхүл хувь нийлүүлсэн харилцаа үүсэх ёсгүй.
- 3.9. Түншлэл ба консерциум
Хэрэв нийлүүлэгч нь хоёр ба түүнээс дээш тооны этгээдээс бүрдсэн түншлэл эсхүл консерциум бол захиалагчийн өмнө гэрээний нөхцөлийг хамтдаа болон тус тусдаа хэрэгжүүлж, төлөөлөх эрх бүхий нэг этгээдийг сонгоно. Түншлэл ба консерциумын бүтэц болон бүрэлдэхүүнийг захиалагчаас урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр өөрчлөхийг хориглоно.
- 3.10. Эрх хязгаарлахгүй байх
- 3.10.1 ГЕН-ийн 3.10.2 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол талуудын нэг нь нөгөө талдаа гэрээний нөхцөлийг хэрэгжүүлэх явцад хугацааг удаашруулах, сунгах, гэрээний нөхцөлүүдийг хөнгөлөх, чөлөөлөх эсхүл гэрээнд заасан эрх, үүргийг хязгаарласан шинжтэй гэрээг үргэлжлүүлэн зөрчихөд хүргэсэн аливаа шийдвэрийг хориглоно.
- 3.10.2 Гэрээнд заасан талуудын эрх мэдэл, үүрэг хариуцлагад аливаа өөрчлөлт оруулсан бол энэ нь тухайн эрхийг олгосон албан тушаалтны гарын үсэг, огноогоор баталгаажсан, бичгээр үйлдэгдсэн байна. Үүнд эрхийг ямар хэмжээгээр өөрчилснийг дурдана.
- 3.11. Үл хамаарал
Хэрэв гэрээний аль нэг нөхцөл буюу заалт нь хориглогдсон эсхүл хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд тэдгээр хориглолт, хүчин төгөлдөр бус байдал нь гэрээний бусад нөхцөлүүд буюу заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
- 3.12. Гарал үүслийн улс
Гарал үүслийн улс гэдэгт мэдээллийн технологи, материал, тоног ТШӨХөөрөмж, бусад барааг системд зориулан үйлдвэрлэсэн, боловсруулсан эсхүл хийж бүтээсэн газар болон үйлчилгээ үзүүлж буй этгээдийн улсыг хэлнэ. Барааг хийж бүтээсэн гэж программ хангамжийг боловсруулсан, үйлдвэрлэсэн эсхүл эд ангиудыг бүхэлд нь болон дийлэнх хэсгийг нь угсарч, эдгээр эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бүтээгдэхүүн гаргаж ирэхийг хэлнэ. Бараа, үйлчилгээний гарал үүсэл нь нийлүүлэгчийн аль улсын байхаас хамаарахгүй тул ижил биш байж болно.
4. Мэдэгдэл
- 4.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээтэй холбогдуулж гаргах аливаа мэдэгдлийг талууд бичгээр үйлдэж албан шуудангаар эсхүл факсаар ГТН-д заасан хаягаар холбогдох талд хүргүүлэх бөгөөд дараах шаардлагыг баримтална. Үүнд:

- 4.1.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол факсаар явуулсан мэдэгдлийн эх хувийг илгээснээс хойш 2 өдрийн дотор албан шуудангаар ирүүлж баталгаажуулна.
 - 4.1.2. Албан шуудангаар явуулсан мэдэгдлийг илгээсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор хүргэгдсэнд тооцно. Шуудан илгээсэн гэдгийг нотлох баримт нь уг мэдэгдлийн дугтуй нь зөв хаяглагдсан, шуудангийн алба байгууллагаар тамгалагдаж, баталгаажсан байна.
 - 4.1.3. Факсаар явуулсан мэдэгдлийг тухайн өдөртөө багтаж хүргэгдсэнд тооцно.
 - 4.1.4. Шуудангийн болон факсийн хаяг нь солигдсон гэрээний тал 10 хоногийн дотор энэ тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 4.2. Мэдэгдэлд гэрээний дагуу өгөх аливаа зөвшөөрөл, шийдвэр, зааварчилгааг тусгасан гэж үзнэ.
5. **Үйлчлэх хууль**
6. **Маргаан шийдвэрлэх**
- 5.1. Энэхүү гэрээнд Монгол улсын хуулийг дагаж мөрдөнө.
 - 6.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг аль нэг талын бичгээр гаргасан гомдол, хүсэлтийг 14 хоногийн дотор зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхийн байгууллагад хандах эрхтэй.

Б. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

7. **Системийн цар хүрээ**
- 7.1. ГТН, техникийн шаардлагад тусгайлан хязгаарлаж зааснаас бусад тохиолдолд нийлүүлэгчийн үүрэг нь гэрээ болон талуудын харилцан тохирч, эцэслэсэн ажлын төлөвлөгөөнд заасан аливаа баримт бичиг, төлөвлөгөө, тодорхойлолт, зураг төсөл, код, ажлын горим, үе шатны дагуу мэдээллийн технологи, материал, бусад бүх барааг нийлүүлэх, шаардагдах системийн загвар дизайн, зураг төсөл боловсруулалт хэрэгжүүлэлт (худалдан авалт, чанарын баталгаа, угсралт, ажлын талбайг бэлтгэх, бараа хүргэлт, урьдчилсан туршилт, суурилуулалт, шалгалт- туршилт, туршилт)-ийн үйлчилгээг үзүүлэх зэргийг хамарсан байна.
 - 7.2. Нийлүүлэгч нь гэрээнээс тусгайлан зааж хассанаас бусад тохиолдолд гэрээнд тодорхой заасан бүх ажил /гэрээнд тусгайлан заагаагүй ч системийг ашиглалтанд хүлээн авах үед шаардлагатай бүх материал, зүйлсийг нийлүүлэх, ажил шаардагдах бол уг ажлыг гүйцэтгэх/-ыг гүйцэтгэж, бүх нэр төрөл, бичиг баримтыг нийлүүлнэ.
 - 7.3. Нийлүүлэгч нь хэрэв шаардсан бол өөрийн ирүүлсэн тендерийн “Урсгал зардлын хүснэгт”-д дурдсан дагалдах зүйлс, сэлбэг хэрэгсэл, техник үйлчилгээ (засвар үйлчилгээ, техник болон үйл ажиллагааны туслалцаа гэх мэт) зэрэг бараа, үйлчилгээг ГТН-д заасан нөхцөл, тодорхойлолт, хугацааны дагуу нийлүүлнэ.
8. **Эхлүүлэх болон ашиглалтанд хүлээн авах хугацаа**
- 8.1. Нийлүүлэгч нь системийн ажлыг ГЕН-ийн 28.2-т заасныг үл харгалзан ГТН-д заасан хугацаанд эхэлж “Техникийн шаардлага” бүлгийн “Хэрэгжүүлэх хуваарь”-т заасан хугацааны хуваарь болон талуудын харилцан тохирч, эцэслэсэн ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.
 - 8.2. Нийлүүлэгч нь систем эсхүл дэд системүүдийг ГТН-д заасан хугацаанд, “Техникийн шаардлага” бүлгийн “Хэрэгжүүлэх хуваарь”-т заасан хугацааны хуваарь болон талуудын харилцан тохирч,

эцэслэсэн ажлын төлөвлөгөөний дагуу (гэрээнд систем эсхүл дэд системүүдийг хэсэгчилэн гүйцэтгэх талаар заасан тохиолдолд уг хэсгийг дуусгахаар заасан хугацаанд) эсхүл ГЕН-ийн 39 (Ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах)-д заасны дагуу нийлүүлэгчийн сунгасан хугацаанд хүлээлгэн өгнө.

**9. Нийлүүлэгч
ийн үүрэг
хариуцлага**

- 9.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасны дагуу хамгийн шилдэг мэдээллийн технологи, мэдээллийн системийг нийлүүлэх, засвар үйлчилгээ, сургалт болон бусад холбогдох үйлчилгээг үзүүлэх зэрэг ажлуудыг оновчтой, чадварлаг, мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, дуусгавар болгох үүрэг хүлээнэ. Ялангуяа нийлүүлэгчийн ажиллах хүчин, техникийн мэргэжилтнүүд, хяналтын ажлын баг нь ажилдаа дадлагажиж, туршлагажсан, зохих шаардлагыг хангасан байна.
- 9.2. Нийлүүлэгч нь гэрээ байгуулахдаа системийн талаарх захиалагчийн өгсөн мэдээллийг зохих ёсоор судалсан, ажлын талбайтай биечлэн (хэрэв ажлын талбайд очих боломжтой бол) танилцсан, болон тендер ирүүлэх хугацаанаас хорин найм (28) хоногийн өмнөх байдлаар өөрийн мэдэх боломжтой системтэй холбоотой бусад тоо мэдээллийг авсан зэрэгт үндэслэн гэрээ байгуулсан тухайгаа батална. Нийлүүлэгч нь дээрх мэдээллүүдийг мэдээгүйгээс үүсэх аливаа бэрхшээл, гарах зардлыг хариуцаж гэрээг амжилттай хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
- 9.3. Нийлүүлэгч нь харилцан эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу (ГЕН-ийн 19.2 дугаар зүйл) бүх нөөц, эх үүсвэрүүд, мэдээлэл, шийдвэрийг “Техникийн шаардлага” бүлгийн “Хэрэгжүүлэх хуваарь”-т заасан хугацааны хуваарийн дагуу хугацаанд нь гарган өгөх үүрэгтэй. Нийлүүлэгч шаардлагатай нөөц, эх үүсвэр, мэдээлэл, шийдвэрийг гаргаагүй нь ГЕН-ийн 40.2 дугаар зүйлд заасны дагуу гэрээг цуцлах үндэслэл болж болно.
- 9.4. Нийлүүлэгч нь гэрээний гүйцэтгэлд шаардагдах төрийн болон орон нутгийн, засгийн газрын байгууллагууд эсхүл Монгол улсын нутаг дэвсгэр дэх төрийн үйлчилгээнээс шаардагдах бүх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, батламжтай байна. Үүнд нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн ажиллагсдын хязгаарлалтгүйгээр хилээр зорчих, түүнчлэн нийлүүлэгчийн импортолж буй бүх тоног ТШӨХөөрөмжийг хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл зэргээр үл хязгаарлагдан бусад зөвшөөрөлийг болон ГЕН-ийн 10.4 дүгээрт заасан захиалагчийн хүлээх үүрэгт үл хамаарах бусад зөвшөөрлийг өөрийн нэр дээр авсан байна.
- 9.5. Системд шаардагдах аливаа мэдээллийн технологи, бараа, үйлчилгээ нь ГЕН-ийн 3.12 дугаар зүйлд заасны дагуу гарал үүсэлтэй байна.
- 9.6. Нийлүүлэгч нь хэрэв захиалагч шаардлагатай гэж үзвэл гэрээний гүйцэтгэлтэй холбоотойгоор нийлүүлэгчийн дансны хуулгыг шалгах, захиалагчийн сонгосон аудиторроор шалгалт хийлгэхийг захиалагчид зөвшөөрнө.
- 9.7. Нийлүүлэгчийн хүлээх бусад үүрэг хариуцлагыг ГТН-д дурдсан болно.

10. Захиалагчийн үүрэг хариуцлага

- 10.1. Захиалагч нь гэрээнд тодорхойлон дурдсанаас гадна нийлүүлэгчид гаргаж өгөх бүх мэдээлэл, өгөгдлийн бодитой байдлыг хариуцна.
- 10.2. Захиалагч нь харилцан эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу (ГЕН-ийн 19.2 дугаар зүйл) бүх нөөц, эх үүсвэрүүд, мэдээлэл, шийдвэрийг “Техникийн шаардлага” бүлгийн “Хэрэгжүүлэх хуваарь”-т заасан хугацааны хуваарийн дагуу хугацаанд нь нийлүүлэгчид гарган өгөх үүрэгтэй. Захиалагч шаардлагатай нөөц, эх үүсвэр, мэдээлэл, шийдвэрийг гаргаагүй нь ГЕН-ийн 40.3.1 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ цуцлах үндэслэл болж болно.
- 10.3. Захиалагч нь ажлын талбайг хуулийн дагуу ашиглах, байрлах зөвшөөрөл, гэрээний дагуу хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бусад газарт нэвтрэх, холбогдох зөвшөөрлийг хариуцана.
- 10.4. Гэрээг гүйцэтгэх явцад нийлүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгчид төрийн болон орон нутгийн, засгийн газрын байгууллагууд эсхүл Монгол улсын нутаг дэвсгэр дэх төрийн үйлчилгээнээс зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, батламж авах зайлшгүй шаардлага үүссэн үед гүйцэтгэгч хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч аль болох талаар туслах үүрэг хүлээнэ.
- 10.5. Техникийн шаардлага, ГТН, Эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд нийлүүлэгч эсхүл өөр бусад тал цахилгаан холбоо, эрчим хүчний асуудлыг хариуцсан тохиолдолд захиалагч уг үйлчилгээг цаг хугацаанд нь хангахад аль болох туслах үүрэгтэй.
- 10.6. Захиалагч нь системийг суурилуулах, ашиглалтанд хүлээн авахтай холбогдсон шаардлагатай бүх эх үүсвэрүүд, мэдээллээр хангах, үйл ажиллагааг (шаардагдах цахилгаан холбоо, эрчим хүчээр хангах зэрэг үйлчилгээгээр үл хязгаарлан) нийлүүлэгчийн гэрээний дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанаас гадна харилцан эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу хугацаанд хэрэгжүүлэх үүрэгтэй. Захиалагч уг ажиллагааг хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчийн хүсэлтээр системийн ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгаж болно.
- 10.7. Гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч нь нийлүүлэгчийн шаардсаны дагуу зохих шаардлагыг хангасан буюу бараа хүргэлт, урьдчилсан туршилт, суурилуулалт, туршилт, ашиглалтанд хүлээн авах ажлыг гүйцэтгэх техникийн ажиллагсдыг “Техникийн шаардлага” бүлгийн “Хэрэгжүүлэх хуваарь” болон харилцан эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд нь эсхүл түүнээс өмнө томилон ажиллуулна.
- 10.8. Захиалагч нь техникийн шаардлага, ГТН, харилцан эцэслэн баталсан ажлын төлөвлөгөө болон гэрээний бусад бичиг баримтад заасны дагуу өөрийн холбогдох ажилтнуудыг нийлүүлэгчийн зохион байгуулах сургалтанд хамруулна.
- 10.9. Захиалагч нь системийг ашиглалтанд хүлээн авах шалгалт, туршилтыг ГЕН-ийн 27.2 дугаар зүйлийн дагуу хийх ба хүлээн авснаас хойш системийн тасралтгүй ажиллагааг хангах үүрэгтэй. Гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагчийн энэ хариуцлага нь

системийг хүлээн авснаас хойш нийлүүлэгчийн хүлээх үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

10.10. Гэрээнд нийлүүлэгчийн хүлээх үүрэг гэж тодорхой зааснаас бусад тохиолдолд захиалагч нь программ хангамж, мэдээллийн баазын нөөц хадгалалтыг тохирох хугацаанд нь, мэдээллийн системийн удирдлагын холбогдох дүрэм журам, зарчмын дагуу хийж байх үүрэгтэй.

10.11. ГЕН-ийн 10 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх буюу ГЕН-ийн 27.2 дугаар зүйлийн дагуу системийн ажиллагааг шалган ашиглалтанд хүлээн авах туршилтын үед гарах аливаа зардлыг захиалагч хариуцна.

10.12. Захиалагчийн хүлээх бусад үүрэг хариуцлагыг ГТН-д дурдсан болно.

В. ТӨЛБӨР

11. Гэрээний үнэ

11.1. Гэрээний үнэ нь гэрээний маягтын хавсралт 2 (Гэрээний үнэ ба төлбөрийн нөхцөл)-т заасан үнэ байна.

11.2. Гэрээний үнэ нь тогтмол нийт үнэ байх бөгөөд дор дурдсанаас бусад тохиолдолд өөрчлөгдөхгүй. Үүнд:

- (а) ГЕН-ийн 38 дүгээр зүйлийн дагуу болон гэрээний бусад заалтын дагуу системд өөрчлөлт орох;
- (б) ГТН-д хэрэв заасан бол үнийн тохируулга хийх томъёоллын дагуу өөрчлөлт хийх.

11.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний үнэд нийлүүлэгч гэрээний дагуу хүлээх бүх үүрэг хариуцлагыг багтаасан гэж үзнэ.

12. Төлбөрийн нөхцөл

12.1. Нийлүүлэгч нь холбогдох систем, дэд систем(үүд), бараа хүргэлт, урьдчилсан туршилт, суурилуулалт, ашиглалтанд хүлээн авах ажлуудын гүйцэтгэлийн тухай баримт бичгүүдийг нэхэмжлэхийн хамт ГЕН-ийн 22.5 дугаар зүйл болон гэрээнд заасан бусад үүрэг биелэгдсэний дараа төлбөр авах хүсэлт гаргана. Гэрээний үнийг ГТН-д заасны дагуу төлнө.

12.2. Төлбөр гүйцэтгэсэн нь захиалагчаас систем эсхүл дэд систем(үүд)-ийг хүлээж авсныг илэрхийлэхгүй.

12.3. Захиалагч нь нийлүүлэгчийг гүйцэтгэлийн хамт нэхэмжлэх хүргүүлснээс хойш төлбөрийг дөчин тав (45) хоногоос хэтрүүлэлгүй гүйцэтгэнэ. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг гүйцэтгээгүй бол уг хугацаа хоцорсон төлбөрийн дүнгээс ГТН-д заасан хувиар хүү бодож, шүүхийн шийдвэрийн өмнө, хойно байгаагаас үл хамааран хугацаа хоцроосон өдрөөс төлбөрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд нийлүүлэгчид төлнө.

12.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн мөнгөний нэгж-валют(ууд)-ыг гэрээний маягт болон ГЕН-ийн 11 дүгээр зүйлд заана. Дотоодоос нийлүүлж буй бараа, үйлчилгээний төлбөрийг ГТН-д өөрөөр заагаагүй бол төгрөгөөр гүйцэтгэнэ.

12.5. ГТН-д өөрөөр заагаагүй бол Монгол улсын гаднаас нийлүүлж буй барааны төлбөрийг гадаад валютаар гүйцэтгэх бол холбогдох баримт бичгүүдэд үндэслэн Монгол улсын нэр хүндтэй банкинд үл буцах аккредитив нээлгэнэ. Энэхүү аккредитив нь Парисын Олон

улсын худалдааны танхимаас гаргасан “Uniform Customs and Practice for Documentary Credits”-ийн хамгийн сүүлийн хэвлэлтийн 10 дугаар зүйлд нийцсэн байна.

- 13. Баталгаа нууд**
- 13.1. Баталгаа гаргах
Нийлүүлэгч нь дор дурдсан баталгаануудыг хугацаанд нь, тохирох мөнгөн дүн, хэлбэрээр захиалагчид гаргаж өгөн.
- 13.2. Урьдчилгаа төлбөрийн баталгаа
- 13.2.1. ГТН-д заасны дагуу нийлүүлэгч нь урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцэх хэмжээний баталгааг ирүүлэх ба уг баталгаа нь системийг ашиглалтанд хүлээн авах хүртэл хүчинтэй байна.
- 13.2.2. Захиалагч нь баталгааг тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлнэ. Баталгааны хугацааг дуусгавар болоход уг баталгааг даруй хүчингүй болгож буцаана.
- 13.3. Гүйцэтгэлийн баталгаа
- 13.3.1. Нийлүүлэгч нь гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авснаас хойш хорин нэг (21) хоногийн дотор гэрээний гүйцэтгэлийн баталгаа болгож ГТН-д заасан үнийн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг ирүүлнэ.
- 13.3.2. Баталгаа нь дор дурдсан хэлбэрүүдийн аль нэгээр байж болно. Үүнд:
- (а) тендерийн баримт бичгийн жишиг маягт бүлэгт заасан банкны баталгаа,
 - (б) засгийн газрын бонд,
 - (в) засгийн газрын хүлээн зөвшөөрсөн бусад үнэт цаас хэлбэрээр байж болно.
- 13.3.3. Захиалагч нь гүйцэтгэлийн баталгааг нийлүүлэгчийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж дууссан өдөр /баталгаат засварын болон аливаа сунгагдсан хугацааг оруулан тооцно/-өөс хойш 28 хоногийн дотор хүчингүй болгож буцаана.
- 14. Татвар хураамж**
- 14.1. Монгол улсын гаднаас нийлүүлж буй бараа, үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотойгоор Монгол улсын гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамж, зөвшөөрлийн төлбөр болон бусад төлбөрүүдийг нийлүүлэгч бүрэн хариуцна. Эдгээр бараа үйлчилгээг импортлохтой холбоотой аливаа гаалийн татвар хураамж, бусад төлбөрийг гэрээний маягтын хавсралт 2 “Үнийн хуваарь”-т тусгах буюу гэрээний үнэд багтаан нийлүүлэгч хариуцахаас бусад тохиолдолд захиалагч хариуцана.
- 14.2. Дотоодоос нийлүүлж буй бараа, үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотойгоор төлөх ёстой бүх төрлийн татвар, хураамж, зөвшөөрлийн төлбөр болон бусад төлбөрүүдийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 14.4. Гэрээний гүйцэтгэлийг хангах зорилгоор гэрээний маягтын хавсралт 2 “Үнийн хуваарь”-т тусгах гэрээний үнэд аливаа татвар хураамжийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хорин найм (28) хоногийн өмнө мөрдөгдөж буй холбогдох татварын хууль тогтоомжийн дагуу тооцно.

Г. ОЮУНЫ ӨМЧ

- 15. Зохиогчийн эрх**
- 15.1. Бүх стандарт программ хангамж, стандарт бичиг баримтын оюуны өмчийн эрх нь тухайн эрхийн хууль ёсны эзэмшигчид хадгалагдан үлдэнэ.

16. Программ хангамжийн тусгай зөвшөөрөл-лицензийн гэрээ

15.2. ГТН-д, мөн холбогдох лицензийн гэрээнд өөрөөр заагаагүй бол стандарт программ хангамж болон түүний хэсэг, стандарт баримт бичгийг ашиглах гэрээгээр хүлээсэн захиалагчийн эрхийг бусдад шилжүүлж, зөвшөөрөлгүйгээр ашиглуулж болохгүй.

15.3. Талууд нь (хэрэв заасан бол) ГТН-д заасан бүх программ хангамжийн эх кодтой холбогдсон асуудлаар гуравдагч этгээдтэй (escrow) ГТН-д заасны дагуу харилцана.

16.1. Захиалагчид хууль ёсны дагуу байгаа программ хангамжийн оюуны өмчийн эрхийг хадгалагдаж байгаагаас бусад тохиолдолд нийлүүлэгч нь захиалагчийг уг программ хангамжийг зохион бүтээлт, дизайн зураг төсөл болон тэмдэгтүүдийн хамт хэрэглэх, ашиглах эрхийн лицензээр хангана.

Программ хангамжийг хэрэглэх, ашиглах тусгай зөвшөөрөл-лиценз:

- (a) дараах шинжтэй байна:
- (i) халдашгүй дархан;
 - (ii) үл буцах хэлбэрээр бүрэн төлөгдсөн (ГЕН-ийн 40.1 эсхүл 40.3 дугаар зүйлийн дагуу гэрээг цуцалсанаас үл хамааран);
 - (iii) Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр (эсхүл ГТН-д заасан нутаг дэвсгэрт);
 - (iv) ГТН-д заасан бусад нэмэлт хязгаарлалтын (хэрэв заасан бол) дагуу.
- (б) программ хангамжийн зөвшөөрөгдөх хэлбэр:
- (i) хэрэглээнд зориулж (хэрэв техникийн шаардлага болон нийлүүлэгчийн тендерт заасан бол) үндсэн болон нөөц хадгалалтын компьютер, тоног төрөөрөмжид сууж бэлэн болсон, хэрэглэгдсэн эсхүл олшруулагддаг байх, мэдээлэл дамжуулагдах үед үндсэн болон нөөц хадгалалтын мэдээллийн баазын хооронд дамжуулагддаг байх;
 - (ii) ГТН-д зааснаар программ хангамжийг анх суулгасан компьютер, тоног төрөөрөмжийг өөрчлөх бол шилжүүлэн суулгах нийлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлөөс гадна техникийн шаардлага болон нийлүүлэгчийн тендерт заасантай ижил төрлийн компьютер тоног ТШӨХөөрөмжийн тусгай зөвшөөрөл-лицензийг авсан байх;
 - (iii) нэмэлт хадгалалт эсхүл нөөц хадгалалтад зориулан мэдээлэл боловсруулах;
 - (iv) шаардлагатай тохиргоо хийгдсэн эсхүл захиалагчийн ашиглах компьютер, программ хангамжид тохируулсан, гэрээг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх уламжлалт хэрэглээний программ хангамжид бүрэн нийцсэн байх;
 - (v) ГТН-д зааснаар нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчээс үзүүлэх дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх (энэ тохиолдолд захиалагч нь тухайн ажилтанд программ хангамжийг хэрэглэх, хуулбарлах дэд зөвшөөрөл олгож болно), зайлшгүй шаардлагатай бол тэдгээр дагалдах үйлчилгээг үзүүлэх гэрээнүүдийг сунгах, энэхүү гэрээнд заасан ижил хязгаарлалтуудыг хэрэгжүүлэх.

16.2. ГТН-д заасан нөхцөлийн дагуу нийлүүлэгчээр стандарт программ хангамж нь дээр дурдсан лиценз-тусгай зөвшөөрлийн гэрээнд нийцсэн эсэхийг шалгуулж болно.

**17. Нууц
мэдээлэл**

17.1. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч болон нийлүүлэгч нь нууцыг хадгалах ёстой бөгөөд нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээтэй холбоотой аливаа баримт бичиг, өгөгдөл болон “нууц мэдээлэл” гэсэн тодотголтой бусад мэдээллийг гуравдагч этгээдэд гэрээ байгуулагдахаас өмнө, гэрээ хэрэгжих явцад болон гэрээ дууссанаас хойшхи аль ч хугацаанд задруулж болохгүй.

**Д. СИСТЕМИЙН НИЙЛҮҮЛЭЛТ, СУУРИЛУУЛАЛТ, ШАЛГАЛТ, ТУРШИЛТ,
АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭН АВАХ**

18. Төлөөлөгчид

18.1. Төслийн удирдагч

Гэрээнд төслийн удирдагчийн нэрийг дурдаагүй бол захиалагч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван дөрвөн (14) хоногийн дотор төслийн удирдагчийг томилж энэ тухай нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ. ГТН-д заасан сунгалт, хязгаарлалт (хэрэв заасан бол)-ын дагуу төслийн удирдагч нь системтэй холбоотой өдөр тутмын болон гэрээнээс үүссэн аливаа асуудлаар захиалагчийг төлөөлөх эрхтэй байна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу гарч буй аливаа мэдэгдэл, заавар, тушаал, гэрчилгээ, зөвшөөрөл болон бусад мэдээллийг төслийн удирдагч гаргана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгчээс захиалагчид гарган өгөх аливаа мэдэгдэл, заавар, мэдээллийг төслийн удирдагчид өгнө.

18.2. Нийлүүлэгчийн төлөөлөгч

18.2.1. Хэрэв гэрээнд нийлүүлэгчийг төлөөлөн ажиллах хүний нэрийг дурдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван дөрвөн (14) хоногийн дотор өөрийн төлөөлөгчийг томилж, уг хүнийг хүлээн зөвшөөрөх хүсэлтийн хамт бичгээр мэдэгдэнэ.

18.2.2. ГТН-д заасан сунгалт, хязгаарлалт (хэрэв заасан бол)-ын дагуу нийлүүлэгчийн төлөөлөгч нь системтэй холбоотой өдөр тутмын болон гэрээнээс үүссэн аливаа асуудлаар нийлүүлэгчийг төлөөлөх эрхтэй байна. Гэрээний дагуу гарч буй аливаа мэдэгдэл, заавар, мэдээллийг төслийн удирдагчид өгнө.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу гарч буй нийлүүлэгчид өгөх аливаа мэдэгдэл, заавар, тушаал, гэрчилгээ, зөвшөөрөл болон бусад мэдээллийг нийлүүлэгчийн төлөөлөгчид, хэрэв байхгүй бол түүний орлогчид өгнө.

18.2.3. Нийлүүлэгч нь захиалагчийн урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрийн төлөөлөгчийг өөрчилж болохгүй. Хэрэв захиалагч зөвшөөрсөн бол нийлүүлэгч өөрийн төлөөлөгчийг ГЕН-ийн 18.2.1-д заасан журмын дагуу ижил түвшний эсхүл илүү чадвартай хүнээр сольж томилно.

18.2.4. Нийлүүлэгчийн төлөөлөгч болон бусад ажилтнууд төслийн удирдагч болон бусад ажилтнуудтай хамтран ажиллах үүрэгтэй бөгөөд гэрээний нөхцөлтэй уялдуулан захиалагчийн гаргасан чиглэл, өөрийн эрх хэмжээний хүрээнд ажиллана. Захиалагчийн төлөөлөгч нь өөрийн ажилтнууд болон туслан гүйцэтгэгчийн ажилтнуудын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

18.3. Татгалзах ба өөрчлөх

- 18.3.1. Захиалагч зүй бусаар, хариуцлагагүй ажилласан гэж үзсэн тохиолдолд нийлүүлэгчийн аливаа төлөөлөгч, ажилтныг гэрээний хэрэгжилтэд оролцуулахыг татгалзсан мэдэгдэлийг бичгээр өгч болно. Захиалагч энэ тухайгаа нотолсоныг үндэслэн нийлүүлэгч тэр хүнийг систем дээр цаашид ажиллуулахгүй.
- 18.3.2. Хэрвээ нийлүүлэгч ГЕН-ийн 18.3.1-ийн дагуу өөрийн төлөөлөгч эсхүл ажилтныг ажлаас чөлөөлсөн тохиолдолд өөр хүнийг яаралтай сольж томилно.

19. Ажлын төлөвлөгөө

- 19.1. Нийлүүлэгч захиалагчтай нягт хамтран ажлын урьдчилсан төлөвлөгөө болон өөрийн тендерт үндэслэн гэрээнд заасан бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргана. Ажлын төлөвлөгөөний агуулга нь ГТН болон Техникийн шаардлагад заасны дагуу байна.
- 19.2. Нийлүүлэгч Ажлын төлөвлөгөөг захиалагчид ГТН-д заасан журмын дагуу албан ёсоор танилцуулна.
- 19.3. Шаардлагатай бол, Эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөг гаргах явцад тохиролцсон өөрчлөлтийг тусгасан Хэрэгжүүлэх хуваарийн нөлөөлөлийг ГЕН-ийн 38, 39-д заасны дагуу хийгдэх өөрчлөлтөөр гэрээнд тусгана.
- 19.4. Нийлүүлэгч системийн нийлүүлэлт, суурилуулалт, шалгалт-туршилт болон туршилтыг Эцэслэн баталсан ажлын төлөвлөгөө ба гэрээний дагуу гүйцэтгэнэ.
- 19.5. ГТН-д заасан явцын тайлан болон бусад тайланг нийлүүлэгч бэлтгэж Техникийн шаардлагад заасан хэлбэрээр, заасан хугацаанд захиалагчид ирүүлнэ.

20. Туслан гүйцэтгэх ажлын гэрээ

- 20.1. Гэрээний хавсралт 2 (Зөвшөөрсөн туслан гүйцэтгэгчийн жагсаалт)-д захиалагчийн зөвшөөрөх туслан гүйцэтгэгчид болон тэдгээрийн нийлүүлэх бараа, үйлчилгээ тус бүрийг заасан болно.
- 20.2. Нийлүүлэгч нь ГЕН-ийн 20.1 дүгээр зүйлийн дагуу жагсаалтад орсон туслан гүйцэтгэгчээс тухайн ажилд томилон ажиллуулна.
- 20.3. Гэрээний хавсралт 2-т урьдчилан зөвшөөрсөн туслан гүйцэтгэгчийн жагсаалтад ороогүй зүйлийн хувьд нийлүүлэгч нь дараахь нөхцөл хангагдсан үед туслан гүйцэтгэгч авч ажиллуулж болно. Үүнд:
- (i) нийлүүлэгч нь туслан гүйцэтгэгч авч ажиллуулахаас хорин найман (28) хоногийн өмнө захиалагчид мэдэгдэнэ;
 - (ii) захиалагч нь дээрх хугацаа дуусахаас өмнө уг мэдэгдэл зөвшөөрсөн эсхүл татгалзсан эсэхээ хариу мэдэгдэнэ. Хэрэв захиалагч мэдэгдлийн хариу өгөх хугацаанд татгалзсан хариу өгвөл уг туслан гүйцэтгэгчийг нийлүүлэгч авч ажиллуулахгүй. Бичгээр татгалзсан хариу өгөөгүй бол санал болгож буй туслан гүйцэтгэгчийг захиалагч хүлээн зөвшөөрч байна гэж тооцно.

21. Дизайн зураг төсөл, инженерчлэл

- 21.1. Техникийн тодорхойлолт, зураг
- 21.1.1. Нийлүүлэгч нь системийг суурилуулахад зайлшгүй шаардагдах үндсэн болон дэлгэрэнгүй зураг төсөл дизайн, хэрэгжүүлэх ажиллагааг гэрээнд заагдсан эсхүл заагдаагүйгээс үл хамааран үйлдвэрлэлийн тэргүүн туршлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

Нийлүүлэгч нь төслийн удирдагчийн баталсан эсэхээс үл хамааран бэлтгэсэн тодорхойлолт, зураг болон бусад техникийн баримт бичиг дэх аливаа зөрчил, алдаа дутагдал, орхигдуулалтыг хариуцна. Тухайн зөрчил, алдаа дутагдал, орхигдуулалт нь захиалагч болон түүний нэрийн өмнөөс нийлүүлэгчид бичгээр өгсөн ташаа мэдээллээс болсон бол нийлүүлэгч хариуцахгүй.

21.1.2. Нийлүүлэгч нь захиалагч болон түүний нэрийн өмнөөс нийлүүлэгчид өгсөн аливаа тодорхойлолт, зураг болон бусад техникийн баримт бичиг, өөрчлөлттэй холбоотой хариуцлагаас татгалзах эрхтэй ба энэ тухай мэдэгдлээ төслийн удирдагчид мэдэгдэнэ.

21.2. Төслийн удирдагч техникийн баримт бичгийг баталгаажуулах, хянах

21.2.1. Нийлүүлэгч нь төслийн удирдагчид хянуулах болон баталгаажуулах баримт бичгийг ГН-д заасны дагуу бэлтгэнэ.

Төслийн удирдагчийн зөвшөөрсөн байх шаардлагатай бичиг баримттай холбоотой системийг аливаа хэсгийг зөвхөн түүний зөвшөөрлийг авсны дараа хийж гүйцэтгэнэ. ГЕН-ийн 21.2.2 –с 21.2.5 дугаар заалтууд нь зөвхөн төслийн удирдагчийн зөвхөн зөвшөөрч баталгаажуулах шаардлагатай баримт бичгүүдэд хамаарах бөгөөд хянагдах баримт бичигт хамаарахгүй болно.

21.2.2 Төслийн удирдагч нь ГЕН-ийн 21.2.1 дүгээр зүйлийн дагуу зөвшөөрөл авах шаардлагатай аливаа баримт бичгийг хүлээн авсанаас хойш арван дөрөв (14) хоногийн дотор баталгаажуулж холбогдох баталгаажуулсан баримт бичгүүдийн нэг хувийг бичгээр гаргасан мэдэгдлийн хамт нийлүүлэгчид буцаан хүргүүлнэ. Зөвшөөрч баталгаажуулаагүй бол үүний шалтгаан, шаардлагатай өөрчлөлтийн саналыг мэдэгдэлд дурдана. Хэрэв төслийн удирдагч арван дөрөв (14) хоногийн дотор уг арга хэмжээг аваагүй бол тухайн баримт бичгүүдийг зөвшөөрсөнд тооцно.

21.2.3 Хэрэв төслийн удирдагч зөвшөөрөл өгөхөөс татгалзвал нийлүүлэгч ГЕН-ийн 21.2.2 дугаар зүйлийн дагуу баримт бичгүүдийг өөрчлөн төслийн удирдагчид дахин хүргүүлнэ. Төслийн удирдагч зөвшөөрөл өгөхдөө зарим зүйлсийг өөрчлөхөөр заасан бол нийлүүлэгч уг шаардлагатай өөрчлөлтийг тусгасанаар ГЕН-ийн 21.2.5 дугаар зүйлийн дагуу зөвшөөрөгдсөнд тооцно. ГЕН-ийн 21.2.2-с 21.2.4 дугаар зүйлийн заалтууд төслийн удирдагч тухайн баримт бичгийг зөвшөөрөх хүртэл давтагдаж болно.

21.2.4 Төслийн удирдагч нийлүүлэгчийн гаргаж өгсөн баримт бичгийг өөрчлөн эсхүл үл өөрчлөн зөвшөөрөл олгосон бол захиалагчийн шаардсан өөрчлөлтөөс хамааран сөрөг үр дүн гарсан эсхүл захиалагч болон түүний нэрийн өмнөөс ташаа мэдээллээр хангаснаас бусад тохиолдолд нийлүүлэгчийн гэрээний дагуу хүлээх аливаа хариуцлагаас чөлөөлөхгүй.

21.2.5 Нийлүүлэгч нь ГЕН-ийн 21.2 дугаар зүйлийн дагуу төслийн удирдагчийн зөвшөөрсөн аливаа баримт бичгийг өөрчлөхгүй. Хэрэв төслийн удирдагч өмнөх зөвшөөрөгдсөн баримт бичгийг эсхүл уг баримт бичигт тулгуурлан өөр баримт бичгийг өөрчлөх хүсэлт гаргавал ГЕН-ийн 38 дугаар заалт (Системд өөрчлөлт оруулах)-ыг мөрдөнө.

22. Худалдан авалт, хүргэлт, тээвэрлэлт

22.1. ГЕН-ийн 14.2 дугаар зүйлийн дагуу нийлүүлэгч нь бүх мэдээллийн технологи, бичиг баримт болон бусад барааг үйлдвэрлэх буюу худалдан авч ажлын талбайд түргэн шуурхай, эмх цэгцтэйгээр тээвэрлэн хүргэнэ.

22.2. Мэдээллийн технологи, бичиг баримт, бусад барааны нийлүүлэлт нь техникийн шаардлагад заасны дагуу байна.

22.3. Цагаас өмнө болон хэсэгчилэн хүргэхэд захиалагчаас бичгээр зөвшөөрөл авах ба захиалагч зөвшөөрөл олгохоос шалтгаангүйгээр татгалзаж үл болно.

22.4. Тээвэрлэлт

22.4.1 Нийлүүлэгч нь барааг тээвэрлэлтийн явцад гэмтэхээс сэргийлсэн найдвартай баглаа боодлоор хангана. Баглаа боодлын гадна болон доторхи бичиг баримтын бүрдэл, тэмдэглэгээ шошго нь захиалагчийн зааврын дагуу байна.

22.4.2. Нийлүүлэгч нь барааг инкотермсийн нөхцөлийг тусгасан үнийн хуваарьт заасан нөхцөлөөр ажлын талбайд хүргэх тээврийн зардлыг хариуцна.

22.4.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол нийлүүлэгч нь аль ч улсын тээврийн байгууллагад хандах, даатгалд хамрагдаж болно.

22.5. ГТН-д өөрөөр заагаагүй бол нийлүүлэгч нь захиалагчид дор дурдсан тээврийн болон бусад баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

22.5.1. Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:

Тээвэрлэлт хийхдээ нийлүүлэгч нь захиалагч болон ачаа тээшийн тээврийн даатгалыг хийхээр нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан даатгалын байгууллагад тээвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг утсан холбоогоор мэдэгдэнэ. Нийлүүлэгч нь дараах баримт бичгүүдийг шуудан эсхүл хүргэх үйлчилгээний аль тохиромжтойгоор захиалагчид, хуулбар хувийг нь даатгалын байгууллагад түргэн шуурхай илгээнэ.

(а) барааны нэр тодорхойлолт, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг тусгасан нийлүүлэгчийн нэхэмжлэх 2 хувь;

(б) холбогдох тээврийн баримт;

(в) даатгалын гэрчилгээ;

(г) гарал үүслийн гэрчилгээ; болон

(д) ажлын талбайд хүргэгдэх баримжаалсан хугацаа.

22.5.2. Дотоодоос нийлүүлэх барааны хувьд:

Тээвэрлэлт хийхдээ нийлүүлэгч нь захиалагчид тээвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг утсан холбоогоор мэдэгдэнэ. Нийлүүлэгч нь дараах баримт бичгүүдийг шуудан эсхүл хүргэх үйлчилгээний аль тохиромжтойгоор захиалагчид түргэн шуурхай илгээнэ.

(а) барааны нэр тодорхойлолт, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг тусгасан нийлүүлэгчийн нэхэмжлэх 2 хувь;

(б) хүргэх бичиг, төмөр замын эсхүл ачааны машины тасалбар буюу тээврийн баримт;

(в) даатгалын гэрчилгээ;

(г) гарал үүслийн гэрчилгээ; болон

(д) ажлын талбайд хүргэгдэх баримжаалсан хугацаа.

22.6. Гаалийн бүрдүүлэлт:

(а) Захиалагч нь гэрээний мхягтын 2 дахь хэсэгт дурдсан үнийн хуваарьт заасан Монгол улсын гаднаас санал болгож буй барааны инкотермсийн нөхцөлийн дагуу

Монголд оруулах гаалийн бүрдүүлэлт болон зардлыг хариуцна.

- (б) Захиалагчийн хүсэлтээр нийлүүлэгч нь Монгол улсын гаднаас импортолж буй барааны гаалийн бүрдүүлэлтийн явцад өөрийн төлөөлөгчийг бэлэн байлгана. Нийлүүлэгчээс хамаарахгүйгээр гаалийн бүрдүүлэлт саатуулагдвал:
- (i) нийлүүлэгч нь системийг ашиглалтад хүлээн авах хугацааг ГЕН-ийн 39 дүгээр зүйлд заасны дагуу сунгах эрхтэй байна;
 - (ii) хугацаа хоцорсноос хамааран гарах хадгалалтын зардлын дүнг нийлүүлэгчид нөхөн төлөхөөр гэрээний үнийг тохируулна.

23.Бүтээгдэхүүн-ийг шинэчлэх

23.1. Гэрээг гүйцэтгэх явцад нийлүүлэгчид нь өөрийн тендерт ирүүлсэн буюу нийлүүлэгдэж буй мэдээллийн технологийн дэвшлийн чиг хандлагын талаар танилцуулж байх ёстой ба уг мэдээллийн технологийн хамгийн сүүлийн хувилбарыг буюу өмнөх санал болгосон мэдээллийн технологитой тэнцүү эсхүл илүү боловсронгуй хэлбэрийг, ГЕН-ийн 38 дүгээр зүйлийн дагуу ижил эсхүл бага үнээр нийлүүлэхээр захиалагчид санал болгоно.

23.2. Гэрээг гүйцэтгэх явцад ГЕН-ийн 38 дүгээр зүйлийн дагуу нийлүүлэгч Монгол улс дахь бусад үйлчлүүлэгчиддээ санал болгож буй мэдээллийн технологийн сайжруулсан, шинэчилсэн хувилбар болон тоног ТШӨХөөрөмжийн үнийн өөрчлөлтийн талаар захиалагчид мэдээлж байна.

23.3. Гэрээг гүйцэтгэх явцад нийлүүлэгч нь стандарт программ хангамжийн бүх шинэ хувилбарууд, шинэчлэл болон түүнтэй холбоотой бүх баримт бичиг, техник үйлчилгээг нийлүүлэгчийн Монгол улс дахь бусад үйлчлүүлэгчдэд нийлүүлэхэд бэлэн болсноос хойш гуч (30) хоногийн дотор, эсхүл уг программ хангамжийн зохиогдсон улсад хэрэглэгчдэд хүрсэнээс хойш арван хоёр (12) сарын дотор захиалагчид санал болгоно. Нийлүүлэгчийн санал болгох үнэ нь тендерт санал болгосон үнээс хэтэрч үл болно.

23.4. ГТН-д өөрөөр заагаагүй бол, баталгаат хугацаанд нийлүүлэгч нь системд ашиглагдаж буй стандарт программ хангамжийн бүх сүүлийн хувилбар, шинэчлэлийг захиалагчид нэмэлт зардалгүйгээр нийлүүлнэ.

23.5. Нийлүүлэгч нь программ хангамжийн шинэ хувилбар, шинэчлэл үйлдвэрлэлд бэлэн болсон тухай баримт гарсанаас хойш (18) сарын дотор шинэ хувилбар, шинэчлэлтүүдийг системд нэвтрүүлнэ. Үүний тулд уг шинэ хувилбар, шинэчлэл нь системийн үйл ажиллагаанд хортойгоор нөлөөлөхгүй, эсхүл ажиллагаа их шаардахгүй байх шаардлагатай. Энэхүү шинэ хувилбар, шинэчлэл нь системийг дахин өөрчлөх ажиллагаа ихтэй бол урьд нь ашиглаж байсан хувилбарыг шинэ хувилбар, шинэчлэлийг нэвтрүүлэхэд шаардагдах хугацаанд үргэлжлүүлэн хэрэглэнэ. Нийлүүлэгч нь аль ч тохиолдолд захиалагчийг дараагийн шинэ хувилбар, шинэчлэлийг үйлдвэрлэлд бэлэн болсон тухай баримт хүлээн авсанаас хойш хорин дөрвөн (24) сарын дотор засвар үйлчилгээгээ зогсоож болохгүй. Захиалагч нь 24 сарын хугацаанд аливаа шинэ хувилбар, шинэчлэлийг нэвтрүүлэхэд бүх хүч чармайлтаа гаргана.

- 24. Хэрэгжилт, суурилуулалт, бусад үйлчилгээ**
- 24.1. Нийлүүлэгч нь гэрээнд болон эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан бүх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд шударгаар хийж гүйцэтгэнэ.
- 24.2. Гэрээнд тусгагдаагүй (тусгагдсан боловч тендерийн урсгал зардлын хүснэгтэд бүрдэл болж ороогүй) нийлүүлэгчийн үзүүлэх үйлчилгээний үнийг урьдчилан тохирох бөгөөд энэ нь Монгол улс дахь бусад үйлчлүүлэгчдэд үзүүлдэг хэмжээнээс хэтрэхгүй.
- 25. Шалгалт**
- 25.1. Захиалагч эсхүл түүний төлөөлөгч нь бараа хүргэгдэх эцсийн цэг эсхүл ажлын талбай дээр системийг болон түүний аливаа хэсгийг техникийн шаардлагад заасны дагуу хэрэгжилт, үйл ажиллагаа нь гэрээний шаардлагад нийцэж буй эсэхийг нягтлах зорилгоор шалгах эрхтэй.
- 25.2. Захиалагч болон төслийн удирдагч эсхүл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид системийн бүрэлдэхүүн хэсгийн шалгалт, туршилтанд байлцах эрхтэй ба үүнтэй холбогдон гарах бүх зардлыг захиалагч хариуцна.
- 25.3. Шалгалт, туршилт хийгдсэн бүрэлдэхүүн хэсэг нь гэрээний шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч тухайн бүрэлдэхүүн хэсгийг хүлээн авахаас татгалзах ба нийлүүлэгч нь уг хэсгийг гэрээний шаардлагад нийцүүлэн солих, шаардлагатай өөрчлөлтийг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.
- 26. Системийг суурилуулах**
- 26.1. Нийлүүлэгч нь систем, дэд систем нийлүүлэгдэж, урьдчилсан байдлаар туршилтад орж, ГТН, техникийн шаардлага, эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу туршилт хийх, ашиглалтанд хүлээлгэн өгөх шалгалт хийхэд бэлэн болсон гэж үзсэн даруй энэ тухайгаа захиалагчид бичгээр мэдэгдэнэ.
- 26.2. Төслийн удирдагч нь ГЕН-ийн 26.1 дүгээр зүйлийн дагуу нийлүүлэгчийн мэдэгдлийг хүлээн авсанаас хойш арван дөрөв (14) хоногийн дотор тухайн систем, үндсэн хэсэг эсхүл дэд систем (хэрэв гэрээнд үндсэн хэсэг эсхүл дэд систем гэж заасан бол)-ийг тендерийн баримт бичгийн “Жишиг маягтууд” бүлэгт заасан хэлбэрээр суурилуулалт хийгдсэн тухай “Суурилуулалтын гэрчилгээ”-г нийлүүлэгчийн мэдэгдэл өгсөн он, сар, өдрөөр тэмдэглэн олгоно.
- Эсхүл аливаа зөрчил гологдол, дутагдал байгаа тухай нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ. Нийлүүлэгч нь төслийн удирдагчийн мэдэгдэлд дурдсан аливаа зөрчил, гологдол, дутагдалыг арилгах талаар хүчин чармайлт гаргана. Нийлүүлэгч нь систем, дэд системд дахин шалгалт хийн ашиглалтанд хүлээлгэн өгөх туршилт, шалгалт хийхэд бэлэн болсон гэж үзвэл ГЕН-ийн 26.1 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид бичгээр мэдэгдэнэ. ГЕН-ийн 26.2 дугаар зүйлд заасан журмыг “Суурилуулалтын гэрчилгээ”-г олгох хүртэл давтаж болно.
- 26.3. Хэрэв төслийн удирдагч ГЕН-ийн 26.1 дүгээр зүйлийн дагуу нийлүүлэгчийн мэдэгдлийг хүлээн авсанаас хойш арван дөрөв (14) хоногийн дотор “Суурилуулалтын гэрчилгээ”-г олгоогүй, аливаа зөрчил гологдол, дутагдал байгааг мэдэгдээгүй эсхүл захиалагч нь уг систем (эсхүл дэд систем)-ийг шууд ашиглаж эхэлсэн бол уг систем (эсхүл дэд систем)-ийг нийлүүлэгчийн мэдэгдэл эсхүл давтан мэдэгдэл гаргасан өдөр суурилуулалт амжилттай хийгдсэн гэж үзэж болно.

27. Системийн туршилт, ашиглалтанд хүлээн авах

27.1. Туршилт

27.1.1. Системийн туршилтыг нийлүүлэгч дараах тохиодолд эхлүүлнэ:

- (а) ГЕН 26.2 заасны дагуу төслийн удирдагч суурилуултын гэрчилгээ өгсөн даруйд; эсхүл
- (б) Техникийн шаардлагад эсхүл эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд өөрөөр заасан бол тэр дагуу; эсхүл
- (в) ГЕН 26.3-ын дагуу суурилуулалт дууссан гэж үзсэн даруйд

27.1.2. Нийлүүлэгчийг туршилттай холбоотой үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримт болон техникийн ба гүйцэтгэлийн ажилчдаар захиалагч хангах үүрэгтэй.

Систем эсхүл дэд системийн үндсэн ашиглалтыг ашиглалтанд хүлээн авах шалгалт албан ёсоор эхлэхээс өмнө эхлэх ёсгүй.

27.2. Ашиглалтанд хүлээн авах шалгалт

27.2.1. Ашиглалтанд хүлээн авах шалгалт (давтан шалгалт) нь ГЕН 10.9-д заасанаар захиалагчийн үндсэн үүрэг хариуцлага боловч нийлүүлэгчтэй бүрэн хамтран ажиллаж гүйцэтгэнэ. Ингэхдээ систем нь техникийн шаардлагыг хангасан болон нийлүүлэгчийн тендерт заасан ажил гүйцэтгэх стандарт, үйл ажиллагааны ба техникийн гүйцэтгэлийн шаардлагатай нийцэх эсэхийг балгаажуулна. Туршилтын явцад хийгдэх ашиглалтанд хүлээн авах шалгалт нь ГТН, техникийн шаардлага болон эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэнэ, Захиалагчийн хүсэлтээр ашиглалтанд хүлээн авах шалгалтыг барааг солих, шинэчлэн сайжруулах, шинэ төрлөөр өөрчлөх, мөн системийг хүлээн авсаны дараа барааг нэмэх болон өөрчлөх үед гүйцэтгэж болно.

27.2.2. Хэрэв захиалагчаас шалтгаалан системийн ашиглалтыг хүлээн авах шалгалт нь ГТН-д заасан хугацаанд хийгдэж дуусаагүй бол суурилуулсан өдрөөс эсхүл захиалагч болон нийлүүлэгчийн хооронд тохирсон хугацаанаас эхлэн нийлүүлэгч Техникийн тодрхойлолт, ГТН, эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөний техникийн болон үйл ажиллагааны хэсгийн үүргээ нийлүүлэгч биелүүлсэнд тооцож, ГЕН 28.2, 28.3-заалтууд үйлчлэхгүй болно.

27.3. Ашиглалтанд хүлээн авах

27.3.1 ГЕН-ийн 27.4-т өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд системийг ашиглалтанд хүлээж авна. Үүнд:

- (а) Техникийн шаардлага, ГТН, эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасны дагуу Ашиглалтанд хүлээн авах шалгалт бүрэн дууссан;
- (б) Ашиглалтанд хүлээн авах шалгалт захиалагчаас шалтгаалан суурилуулалтаас хойш эсхүл ГЕН 27.2.2-т тохиролцсон бусад хугацаанд багтаж хийгдээгүй; эсхүл
- (в) захиалагч системийг 60-аас дээш хоногоор боловсруулалт болон хэрэглээнд ашигласан. Хэрэв Системийг ийнхүү ашигласан бол нийлүүлэгч түүнийг баримтжуулж захиалагчид мэдэгдэнэ.

27.3.2 ГЕН 27.3.1-д заасан нөхцөл байдал үүссэн бол нийлүүлэгч төслийн удирдагчид Ашиглалтанд хүлээн авсан гэрчилгээг гаргаж өгөхийг хүссэн мэдэгдлийг хэдийд ч өгч болно.

- 27.3.3 Нийлүүлэгчийн мэдэгдлийг хүлээн авсанаас 14 хоногийн дотор Төслийн Удирдагч захиалагчтай зөвлөлдөж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- (а) Ашиглалтын хүлээн авсан гэрчилгээг олгоно; эсхүл
 - (б) Ашиглалтанд хүлээн авах шалгалтанд тэнцээгүй шалтгаан зөрчил гологдлыг бичгээр мэдэгдэнэ; эсхүл
 - (в) хэрэв ГЕН 27.3.1 (б) нөхцөл үүссэн бол Ашиглалтын хүлээн авах гэрчилгээг олгоно.
- 27.3.4 Ашиглалтанд хүлээн авах шалгалтын явцад илэрч Төслийн удирдагчийн мэдэгдсэн аливаа зөрчил, гологдол, шалтгаануудыг нийлүүлэгч бүх боломжит хэлбэрээр засч нөхөн гүйцэтгэнэ. Ажлыг нөхөн гүйцэтгэсний дараа нийлүүлэгч захиалагчид энэ тухай мэдэгдэх бөгөөд Захиалагч нийлүүлэгчтэй хамтран системийн дахин шалгалтыг гүйцэтгэнэ. Амжилттай үр дүн гарвал ГЕН 27.3.3 дагуу нийлүүлэгч захиалагчид Ашиглалтанд хүлээн авах гэрчилгээг авах хүсэлтийн мэдэгдэл өгнө. Мэдэгдэлийг аваад ГЕН 27.3.3 (а) дагуу захиалагч Ашиглалтанд хүлээн авах гэрчилгээг олгоно эсхүл Ашиглалтанд хүлээн авах шалгалтанд тэнцээгүй шалтгаан, зөрчил гологдлыг нийлүүлэгчид мэдэгдэнэ. Ашиглалтанд хүлээн авах гэрчилгээ олгогдтол ГЕН 27.3.4-ийг давтан гүйцэтгэнэ.
- 27.3.5 ГЕН 27.2 заасны дагуу Систем Ашиглалтанд хүлээн авах шалгалтанд тэнцээгүй бол:
- (а) Захиалагч ГЕН 40.2.2-ын дагуу гэрээг цуцлах эрхтэй; эсхүл
 - (б) Хэрэв захиалагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс заасан хугацаанд Ашиглалтын хүлээн авах ажиллагаа амжилтгүй болсон бол нийлүүлэгч техникийн болон үйл ажиллагааны хувьд гэрээгээр хүээсэн үүргээ биелүүлсэнд тооцож, ГЕН 30.3 дугаар заалт үйлчлэхгүй болно.
- 27.3.6 Хэрэв нийлүүлэгчийн мэдэгдлийг авсанаас 14 хоногийн дотор Төслийн удирдагч Ашиглалтанд хүлээн авах гэрчилгээг олгохгүй эсхүл нийлүүлэгчид үндэслэлтэй шалтгааныг мэдэгдээгүй бол системийг нийлүүлэгчийн мэдэгдсэн өдрөөс хүлээн авсанд тооцно.

БАТАЛГАА БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 28. Ашиглалтанд хүлээн авах үеийн баталгаа**
- 28.1. Нийлүүлэгч Системийн /гэрээнд заасан бол дэд системийн хамт/ нийлүүлэлт, суурилуулалт, туршилт болон ашиглалтанд хүлээлгэн өгөх ажлыг Техникийн шаардлагад заасан Хэрэгжилтийн хуваарь болон/эсхүл ГТН-ийн 8.2-т заасны дагуу эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд багтан эсхүл ГЕН-ийн 39 дүгээр зүйл /Ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах/-ийн дагуу нийлүүлэгчид зөвшөөрч сунгасан хугацаанд багтаан дуусгахыг баталгаажуулна.
- 28.2. Хэрэв Системийн /гэрээнд заасан бол дэд системийн хамт/ нийлүүлэлт, суурилуулалт, туршилт болон ашиглалтанд хүлээлгэн өгөх ажлыг нийлүүлэгч 5 дугаар бүлгийн “Техникийн шаардлага”-д заасан “Хэрэгжилтийн хуваарь” болон/эсхүл ГТН-ийн 8.2-т заасны дагуу эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан эсхүл ГЕН-ийн 39 дүгээр зүйл /Ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах/-ийн дагуу нийлүүлэгчид зөвшөөрч сунгасан хугацаанд багтаан дуусгаж чадахгүй бол гэрээний үнийн ГЕН-д заасан хувиар тооцсон алдангийг захиалагчид төлнө. Хэрэв зөвхөн

дэд системийг ашиглалтанд хүлээлгэж өгөөгүй бол гэрээний үнийн холбогдох хэсгээс алдангийг тооцно. Алдангийн нийт дүн нь ямар ч тохиолдолд ГТН-д /дээд хэмжээ/ заасан хэмжээнээс хэтрэх ёсгүй бөгөөд энэхүү дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд ГЕН-ийн 40.2.2-т заасны дагуу захиалагч гэрээг цуцлах асуудлыг авч үзнэ.

28.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол ГЕН-ийн 28.2-ын дагуу төлөх алданги нь системийг /гэрээнд заасан бол дэд системийн хамт/ 5 дугаар бүлгийн “Техникийн шаардлага”-д заасан “Хэрэгжилтийн хуваарь” болон/эсхүл ГТН-ийн 8.2-т заасны дагуу Эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгч чадаагүй тохиодолд хамаатай. Гэвч энэ 28.3 дахь заалт нь бусад хугацаа хоцролттой холбогдож гэрээний дагуу захиалагчийн хэрэгжүүлэх эрх эсхүл зөрчил арилгуулах арга хэмжээг хөндөхгүй.

28.4. Хэрэв Систем /эсхүл Дэд систем/-ийн талаар захиалагч алданги нэхэмжилсэн бол цаашид нийлүүлэгч Систем /эсхүл Дэд систем/-ийн ашиглалтанд хүлээн авах хугацааны баталгаатай холбогдсон аливаа үүрэг хариуцлагыг захиалагчийн өмнө хүлээхгүй. Гэвч алдангийн төлбөр нь нийлүүлэгчийг Системийг дуусгахтай холбоотой аливаа үүргээс эсхүл гэрээний дагуу хүлээсэн аливаа бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

**29. Эвдрэл
гэмтэл,
зөрчил
гологдлыг
хариуцах**

29.1. Нийлүүлэгч нь Системийн мэдээллийн технологи, бичиг баримт болон нийлүүлэгдэж буй бусад бараа, үйлчилгээний хамт Системийн хамгаалалт, зураг төсөл, тооцоо, бичиг баримт болон ажиллах хэрэгслүүдийн хувьд зөрчил гологдолгүй бөгөөд болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн Техникийн шаардлагад нийцсэн байдлыг алдагдуулсан эсхүл Систем нь материалын загварыг ажиллагаа, найдвартай байдал, өргөжих чадварыг хязгаарласан гологдол байхгүй гэдэгт баталгаа өгнө. Программ хангамжтай холбогдуулж энэхүү баталгаат засварт хамаарахгүй хязгаарлалт байгаа бол ГТН-д тусгана. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны худалдааны баталгаат засвар энэ гэрээний заалтуудтай зөрчилдөхгүй хэмжээнд үйлчилнэ.

29.2. Нийлүүлэгч мэдээллийн технологи, бичиг баримт болон гэрээний дагуу нийлүүлэгдэж буй бусад бараа нь шинэ, хэрэглэж эхлээгүй, Системийн Техникийн шаардлагад нийцэхэд нөлөөлөх шийдлийн хувьд хамгийн сүүлийн үеийн гэдэгт баталгаа өгнө.

29.3. Түүнчлэн нийлүүлэгч дараах баталгааг өгнө. Үүнд:

- (i) Системд орж буй барааны бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь нийлүүлэгч болон/эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн одоогийн үйлдвэрлэлийн дамжлагын нэг хэсгийг бүрдүүлж байгаа;
- (ii) тэдгээр нь зах зээлд өмнө нь нийлүүлэгдэж байсан;
- (iii) ГТН-д заасан тодорхой нэр төрлүүд нь хамгийн багадаа ГТН-д заасан хугацаанд зах зээлд борлогдсоор байгаа.

29.4. Баталгаат засварын хугацаа нь Системийг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс эхлэх бөгөөд ГТН-д заасан хугацаагаар сунгагдана.

29.5. Хэрэв баталгаат засварын хугацаанд нийлүүлэгчийн нийлүүлсэн мэдээллийн технологи, бичиг баримт болон нийлүүлэгдэж буй бусад бараа, үйлчилгээний зураг төсөл, тооцоо, бичиг баримт болон ажиллах хэрэгслүүдэд зөрчил гологдол илэрвэл захиалагчтай түүнийг арилгах тохирох арга хэмжээний талаар зөвшилцөж тохиролцсоны үндсэн дээр, өөрийн бүрэн зардлаар

эдгээр зөрчил гологдлыг болон түүнээс үүдэн Системд учирсан хохирлыг шуурхай засварлах, солих буюу сайжруулна. Нийлүүлэгчийн сольсон аливаа гэмтэл согогтой мэдээллийн технологи болон бусад бараа нь нийлүүлэгчийн өмч хэвээр үлдэнэ.

29.6. Нийлүүлэгч дараах шалтгаанаар Системд үүссэн зөрчил гологдол буюу гэмтэл согогыг засварлах, солих буюу сайжруулах үүрэг хүлээхгүй. Үүнд:

- (a) захиалагчийн зүгээс Системийг буруу ашиглах буюу засварласан;
- (б) ердийн урагдалт, хагаралт;
- (в) Техникийн шаардлагад тодорхойлсон болон нийлүүлэгчийн зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд Системийг түүний нийлүүлээгүй нэр төрлийн барааны хамт ашигласан;
- (г) Захиалагчийн зүгээс эсхүл нийлүүлэгчийн зөвшөөрөлгүй гуравдагч этгээдээр Системд өөрчлөлт оруулсан.

29.7. ГЕН-ийн 29 дэх заалт нь дараах зүйлд хамаарахгүй.:

- (a) ердийн хэрэглээний бараа материал буюу баталгаат засварын хугацаанаас богино амьдралын хугацаатай материал;
- (б) Захиалагчийн эсхүл түүний өмнөөс боловсруулж гаргаж өгсөн аливаа зураг төсөл, техникийн тооцоо, үзүүлэлт, тоо баримт буюу ГЕН-ийн 21.1.2.-т заасны дагуу нийлүүлэгчийн хариуцахаас татгалзсан асуудлууд.

29.8. Захиалагч гэмтэл согог илрүүлсэн бол түүний шинж чанарыг дурдан хэрхэн илэрсэнийг тусгасан мэдэгдэлийг даруй нийлүүлэгчид өгнө. Захиалагч энэ гэмтэл согогийг шалгах боломжийг нийлүүлэгчид гаргаж өгнө. Захиалагч ГЕН-ийн 29-ийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхээр ажлын талбай болон Системд нэвтрэх бүх боломжоор нийлүүлэгчийг хангана.

29.9. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согогийг ГТН-д заасан хугацаанд түүнийг арилгахгүй бол захиалагч мэдэгдэл өгсөний үндсэн дээр уг гэмтэл согогийг өөрөө буюу гуравдагч этгээдээр дамжуулан арилгах арга хэмжээ авах эрхтэй ба энэ ажилтай холбогдож гарсан зардлыг нийлүүлэгч захиалагчид төлөх буюу эсхүл нийлүүлэгчид төлөгдөх ёстой төлбөрөөс захиалагч суутган тооцох буюу эсхүл гүйцэтгэлийн баталгаагаар нэхэмжилж авна.

29.10. Хэрэв Системийн зөрчил гологдол гарч засварлах болсоны улмаас захиалагч ашиглах боломжгүй болсон бол энэ хугацаагаар баталгаат засварын хугацааг сунгана.

29.11. Системийн гологдолтой хэсэгт сольж тавьсан нэр төрлүүд нь зөрчил гологдлыг хариуцах баталгаат засварын үлдсэн хугацаанд эсхүл сольж тавьсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд /аль урт байх хугацаанд нь/ баталгаат засварт хамрагдана.

30. Үйл ажиллагааны баталгаа

30.1. Ашиглалтанд хүлээн авсан гэрчилгээ /акт/ үйлдэгдсэнээр нийлүүлэгч Систем нь Техникийн шаардлагад тусгасан захиалагчийн шаардлагуудыг бүрэн хангасан шийдэл болж чадсан бөгөөд гэрээний бусад бүх заалтад нийцсэн гэдэгт баталгаа өгнө. ГЕН-ийн 27–д заасан Туршилт ба ашиглалтанд хүлээн авах асуудал нь Систем гэрээний шаардлагуудад техникийн хувьд нийцсэнийг тодорхойлно.

30.2. Хэрэв нийлүүлэгчид хамаарах шалтгаанаар Систем Техникийн шаардлага, эсхүл гэрээний бусад шаардлагыг хангахгүй бол нийлүүлэгч Техникийн шаардлагыг хангаж үйл ажиллагааны хувьд тавигдах стандартад нийцүүлэхэд шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт, нэмэлтийг Системд оруулж зардлыг бүрэн хариуцана. Нийлүүлэгч шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт, нэмэлтийг Системд оруулсан даруй захиалагчид ашиглалтанд хүлээн авах шалгалтыг дахин хийх хүсэлт тавина.

30.3. Хэрэв шалгалтын дүнд Системийг ашиглалтанд хүлээн авах боломжгүй бол ГЕНийн 40.2.2-т заасны дагуу захиалагч гэрээ цуцлах асуудлыг авч үзнэ. Мөн үүнээс үүдэн гарч болох хугацаа хоцролт болон нэмэлт зардлыг нөхөх үүднээс захиалагч ГЕН-ийн 13.3-т заасны дагуу нийлүүлэгчийн гүйцэтгэлийн баталгааг гүйцэтгүүлнэ.

**31. Оюуны
өмчийн
эрхийн
баталгаа**

31.1. Нийлүүлэгч дараах баталгааг өгнө. Үүнд:
(а) нийлүүлэгдэж, суурилуулагдаж, шалгагдаж туршин ашиглалтанд хүлээлгэн өгсөн Систем нь;
(б) гэрээний дагуу энэ Системийн ашиглалт нь;
(в) гэрээний дагуу захиалагчид өгсөн программ хангамж, бичиг баримтын хуулбарлалт нь нийлүүлэгчийн болон аливаа гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй буюу зөрчихгүй гэдгийг баталж байгаа бөгөөд тэрээр гэрээнд заасан шаардлагатай бүх оюуны өмчийг ашиглах болон бусад бүх шилжүүлэлт, гэрээнд заасны дагуу захиалагчийн эзэмших, ашиглах оюуны өмч, баталгаат хугацаатай холбоотой эрхийг эзэмшсэн эсхүл өөрийн зардлаар бичгээр баталгаажуулж шилжүүлэх буюу ашиглах эрхтэй гэдгийг батална. Үүгээр хязгаарлахгүйгээр, нийлүүлэгч Системийн боловсруулахад ашиглагдах үйлчилгээг нийлүүлэх байгууллага, хувь хүнээс эрх шилжүүлэх, ашиглах болон бичгээр хийсэн бусад тохиролцоог хариуцана.

**32. Оюуны
өмчийн эрх
зөрчигдөх**

32.1. Мэдээллийн систем эсхүл түүний аливаа хэсгийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцана.

Ж. ЭРСДЭЛИЙН ХУВААРИЛАЛТ

**33. Эзэмших
эрхийг
шилжүүлэх**

33.1. Программ хангамж болон бичиг баримтыг оруулахгүйгээр Мэдээллийн технологи ба бусад бараануудын эзэмших эрхийг тэдгээрийг нийлүүлэгдэх үед эсхүл гэрээнийн маягтад зааж тохиролцсон нөхцөлийн дагуу захиалагчид шилжүүлнэ.

33.2. Гэрээний дагуу нийлүүлэгдсэн Программ хангамж болон бичиг баримтыг эзэмших ба ашиглах нөхцөл нь ГЕН-ийн 15 болон Техникийн шаардлагад тусгагдсаны дагуу байна.

33.3. Гэрээтэй холбогдуулж нийлүүлэгчийн болон туслан гүйцэтгэгчийн хэрэглэж байсан нийлүүлэгчийн багаж ТШӨХөөрөмжийн эзэмших эрх нь тэдэнд хэвээр үлдэнэ.

**34. Системийг
хяналтанд
байлгах**

34.1. Захиалагч нь систем болон туслах дэд системийн тээвэрлэлтийн бүрэн бүтэн байдал, хяналтыг хариуцна. Нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн ажилтны үйлдлээс үүссэн гэмтэл, алдагдлаас бусад тохиолдолд ГЕН 27-д зааснаар систем болон дэд системийн

нийлүүлэгдсэн өдрөөс ашиглалтанд хүлээж авах хүртэлх ямар нэг гэмтэл, алдагдлыг захиалагч өөрийн зардлаар засварлана.

- 34.2. Хэрэв систем болон түүний аль нэг хэсэгт дараах шалтгаанаар гэмтэл эсхүл алдагдал үүссэн бол,
- (а) Цөмийн урвал, туяа радио идэвхт цацрагийн тархалт, агаарын даралтын долгион зэрэг урьдчилан харах боломжгүй үзэгдлүүд эсхүл урьдчилан харсан ч түүнийг шийдвэрлэх, даатгах боломжгүй, ГЕН 36-д заасан даатгалын хамрах хүрээнд ороогүй;
 - (б) Захиалагч болон аль нэг гуравдагч этгээдийн гэрээнд заагаагүй ашиглалт, ямарваа хэрэглээ;
 - (в) ГЕН 21.1.2-ын дагуу нийлүүлэгч хариуцахгүй гэж мэдэгдсэн буюу захиалагчийн эсхүл түүний өмнөөс гаргаж өгсөн аливаа зураг төсөл, техникийн тооцоо, үзүүлэлт, тоо баримтын найдвартай байдал буюу тэдгээрийг ашигласнаас үүдсэн.

захиалагч нь ашиглалтанд хүлээн авсан Систем болон дэд системд үүссэн гэмтэл алдагдалыг үл харгалзан холбогдох төлбөрийг нийлүүлэгчид бүрэн төлнө. Хэрэв захиалагч нийлүүлэгчээс эдгээр гэмтэл, алдагдлыг засахыг бичгээр хүссэн тохиолдолд нийлүүлэгч түүнийг ГЕН-ийн 38-д заасны дагуу захиалагчийн зардлаар засварлана. Хэрэв захиалагч гэмтэл алдагдалыг засварлахыг нийлүүлэгчээс бичгээр хүсээгүй тохиолдолд захиалагч ГЕН 38-д зааснаар гэмтэж алдагдсан хэсгийн үйл ажиллагааг оруулахгүйгээр Системийг солихыг шаардана. Эсхүл гэмтэл, алдагдал нь Системийн дийлэнх хэсгийг хамарсан тохиолдолд ГЕН 40.1-ийн дагуу захиалагч гэрээг цуцална.

- 34.3. Захиалагчийн эзэмшилд буй гэрээний дагуу үүргээ гүйцэтгэхэд хэрэглэгдэх нийлүүлэгчийн багаж тоног ТШӨХөөрөмжийн гэмтэл алдагдалыг захиалагч хариуцна. Нийлүүлэгчийн болон туслан гүйцэтгэгчийн ажилтны үйлдлээс үүссэн гэмтэл алдагдлыг захиалагч хариуцахгүй.

- 35. Өмч алдах, гэнэтийн аюул осол, хохирлын нөхөн төлбөр**
- 35.1. Захиалагч болон гэрээнд оролцогч бүр нь ажлын аюулгүй байдал, даатгал, гааль ба цагаачлалтай холбоотой арга хэмжээг Монгол улсын хуулийн дагуу авч хэрэгжүүлнэ.
- 35.2. ГЕН 35.3 ын үндэслэлээр нийлүүлэгч нь захиалагч түүний ажилтнуудад Системийг нийлүүлэх, суурилуулах, шалгах, ашиглалтанд хүлээн авахад үүсч болох өмч хөрөнгийн эвдрэл, гэмтэл, осол аваараас захиалагч түүний ажилтнуудыг сэргийлэх арга хэмжээ авах ба нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч, тэдний ажилтны буруугаас гарсан аливаа хохирол, зардал, хариуцлагыг нөхөн барагдуулна. Хэрэв захиалагчийн болон түүний ажилтнуудын буруутай ажиллагаанаас аливаа гэмтэл, хохирол, зардал үүссэн бол нийлүүлэгч хариуцахгүй.

- 35.3. ГЕН 35.2 –ын дагуу нийлүүлэгчийн хариуцлагатай холбогдсон захиалагчийн эсрэг үүссэн аливаа гомдлын талаар захиалагч нийлүүлэгчид тухай бүрт нь мэдэгдэх шаардлагатай бөгөөд нийлүүлэгч захиалагчийн өмнөөс гомдол барагдуулах ажиллагаа, зөвшилцөл зэргийг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Хэрэв нийлүүлэгч захиалагчаас мэдэгдэл хүлээн авсанаас 28 хоногийн дотор гомдлыг барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэхгүй бол захиалагч өөрийн нэрийн өмнөөс түүнийг хэрэгжүүлж болно.

Нийлүүлэгчээс хохирлыг барагдуулахаар гүйцэтгэж буй ажиллагаанд захиалагч боломжит бүх тусламжийг үзүүлнэ.

35.4. ГЕН 36-д заасан даатгалаас гадна, захиалагчийн ажилтнуудад болон хүлээн аваагүй байгаа системээс бусад системд учирсан эд хөрөнгийн алдагдал, болон осол аваараас болж үүссэн хохирлоос нийлүүлэгчийн ажилтнуудыг сэргийлэх арга хэмжээ авах ба нийлүүлэгчийн буруугаас болж үүсээгүй (гал түймэр, дэлбэрэлт зэрэг бусад эрсдэл) захиалагчийн эзэмшилд үүссэн аливаа хохирол мөн нийлүүлэгчид ба түүний ажилтанд үүссэн гэмтэл хохирлыг захиалагч нөхөн барагдуулна.

35.5. ГЕН-ийн 35.4-д заасан үндэслэлээр захиалагчийн хариуцлагатай холбогдсон нийлүүлэгчийн эсрэг үүссэн аливаа гомдлын талаар нийлүүлэгч захиалагчид даруй мэдэгдэх шаардлагатай бөгөөд захиалагч нийлүүлэгчийн өмнөөс гомдол барагдуулах ажиллагаа, зөвшилцөл зэргийг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Хэрэв захиалагч нийлүүлэгчээс мэдэгдэл хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор гомдлыг барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол нийлүүлэгч өөрийн нэрийн өмнөөс түүнийг хэрэгжүүлж болно. Захиалагчаас хохирлыг барагдуулахаар гүйцэтгэж буй ажиллагаанд нийлүүлэгч боломжит бүх тусламжийг үзүүлнэ.

36. Даатгал

36.1. Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай ГТН-д заасан даатгалын багцын зардлыг нийлүүлэгч хариуцана. Даатгалын гэрээний нөхцөл, даатгагчийг захиалагчаар зөвшөөрүүлсэн байна. Захиалагч үндэслэлгүйгээр зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болохгүй.

37. Давагдашгүй хүчин зүйл

37.1. “Давагдашгүй хүчин зүйл” гэдэгт Захиалагч болон Нийлүүлэгчээс хамаарч шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал, буюу түүнд өртсөн талуудын арга урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үл хамааран учирч буй нөхцөл байдлыг оруулна.

37.2. Аль ч тал давагдашгүй хүчин зүйл тохиолдсоноос гэрээнд заасан үүргийн дагуу аливаа үүргээ биелүүлж чадаагүй, хугацаа хоцорсон зэргийг тухайн нөхцөл байдал үүссэнээс 14 хоногийн дотор нөгөө талдаа бичгээр энэ тухай мэдэгдэнэ.

37.3. Мэдэгдэл гаргасан тал гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл буюу хэвийн гүйцэтгэлээс биелүүлэх боломжгүй хэмжээнд тухайн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөл байдал үргэлжлэн дуусах хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх бөгөөд ашиглалтанд хүлээн авах хугацааг ГЕН-ийн 39-д заасны дагуу сунгана.

37.4. Давагдашгүй хүчин зүйлийн үр дагаварыг түүнд өртсөн тал(ууд) гэрээний хэрэгжилт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс хөнгөвчлөх боломжит арга хэмжээг авах бөгөөд энэ нь аль нэг талын гэрээ цуцлах хүсэлт гаргах, гэрээ цуцлах эрхийг хөндөхгүй.

37.5. ГЕН-ийн 37.4 дүгээр зүйлийн дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд Захиалагч болон Нийлүүлэгчийн эрх үүрэг ГЕН-ийн 40.1.2 болон 40.1.3-т заасны дагуу зохицуулагдана.

37.6. Давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал нь энэ гэрээний дагуу нийлүүлэгчид төлбөр төлөх захиалагчийн аливаа үүрэгт үйлчлэхгүй.

3. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

38. Системд өөрчлөлт оруулах

- 38.1 Өөрчлөлт оруулах
- 38.1.1. Захиалагч нь Төслийн удирдагчид гэрээний хэрэгжилтийн үед Нийлүүлэгчээс тухай бүр тоног ТШӨХөөрөмжийг өөрчлүүлэх, эд анги нэмүүлэх, хасуулах /цаашид өөрчлөлт гэх/, санал гаргах, шаардлага тавих эрхтэй. Энэ нь системийн ерөнхий цар хүрээнд багтсан байх бөгөөд түүнд хамааралгүй ажлыг оролцуулахгүй гэрээнд заасан системийн үндсэн шинж чанарыг өөрчлөхгүй байна. Өөрчлөлт нь ГЕН-ийн 23-т заасны дагуу Мэдээлэл технологийн болон холбогдох үйлчилгээг шинэчлэх хэсгийг хамарч болох боловч үүгээр хязгаарлахгүй.
- 38.1.2. Гэрээ хэрэгжүүлэх явцад Нийлүүлэгч нь Захиалагчид /мөн Төслийн удирдагчид/ тоног ТШӨХөөрөмжийн чанарыг сайжруулах, үр ашиг, найдвартай байдлыг дээшлүүлэх аливаа өөрчлөлт хийх саналыг тухай бүр мэдэгдэнэ Харин Захиалагч тухайн хийгдэх өөрчлөлтийг нягталж үзсэний үндсэн дээр холбогдох зөвшөөрөл өгөх эсхүл татгалзаж болно.
- 38.1.3. ГЕН-ийн 38.1.1, 38.1.2-т заасныг харгалзахгүйгээр, нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл хангалтгүй байснаас хийх шаардлагатай болсон өөрчлөлтийг өөрчлөлт гэж үзэхгүй бөгөөд ийм өөрчлөлт нь гэрээний үнэ болон ашиглалтанд хүлээн авах хугацааны зохицуулалтанд хамрагдахгүй.
- 38.1.4. Өөрчлөлтийг хийх журмыг ГЕН-ийн 38.2, 38.3-т заасан бөгөөд илүү дэлгэрэнгүй мэдээлэл, жишиг маягыг Тендерийн бичиг баримтын Маягтууд бүлэгт заасан болно.
- 38.1.5. Талууд ажлын төлөвлөгөөг боловсруулах явцад ашиглалтанд хүлээн авах төлөвлөсөн өдрөөс өмнө бөгөөд түүнээс хойш системийн техникийн шаардлагад өөрчлөлт орохгүй байх өдрийг тохирно. Энэ өдрөөс хойшхи өөрчлөлтийг ашиглалтанд хүлээн авах ажиллагаанаас хойш авч үзнэ.
- 38.2. Захиалагчийн санал болгосон өөрчлөлт
- 38.2.1. ГЕН-ийн 38.1.1-ийн дагуу захиалагч гэрээнд өөрчлөлт оруулахдаа “Өөрчлөлтийн саналын мэдэгдэл”-ийг хүргүүлж аль болох богино хугацаанд дор дурдсан зүйлийг багтаасан “Өөрчлөлтийн санал” бэлтгэж Төслийн удирдагчид ирүүлэхийг шаардана. Үүнд:
- (а) Өөрчлөлтийн талаар товч тодорхойлолт;
 - (б) ашиглалтанд хүлээн авах хугацаанд үзүүлэх нөлөө;
 - (в) Өөрчлөлтийн зардлын тооцоо;
 - (г) үйл ажиллагааны баталгаанд үзүүлэх нөлөө (байгаа бол);
 - (д) гэрээний бусад заалтад үзүүлэх нөлөө.
- 38.2.2. Нийлүүлэгч өөрчлөлтөөс гарах зардлын үнийг санал болгохдоо гэрээнд заасан нэгж үнэ, бусад үнэд үндэслэн аль болох бодитой хандана. Хэрэв гэрээнд байгаа нэгж үнэ, бусад үнэ нь адилтгах боломжгүй бол гэрээний талууд харилцан тохиролцож өөрчлөлтийн үнийг тогтооно.
- 38.2.3. Нийлүүлэгч өөрчлөлтийн саналын мэдэгдэлийг зөвшөөрөхгүй байх нь түүний бусад өөрчлөлтийг шаардах, зөвшөөрөх эрх, зөвшөөрсөн бусад өөрчлөлтийн дүнд гэрээний үнэ өөрчлөгдөх зэрэгт нөлөөлөхгүй.

38.2.4. Захиалагч өөрчлөлтийн саналыг хүлээн авмагц түүнийг харилцан тохиролцоно. Ийнхүү тохиролцоноос хойш 14 хоногийн дотор захиалагч өөрчлөлт хийхийг баталсан “Өөрчлөлтийн захиалга” гаргана. Захиалагч ямарваа нэг шалтгаанаар “Өөрчлөлтийн захиалга”-ыг 14 хоногт багтаан гаргаж чадаагүй тохиолдолд энэ хугацаанд багтан нийлүүлэгчид мэдэгдэж, өөрчлөлтийн санал бэлтгэхэд нийлүүлэгчид гарсан зардлыг нөхөн төлнө.

38.3. Нийлүүлэгчийн санал болгосон өөрчлөлт

38.3.1 Нийлүүлэгч ГЕН-ийн 38.1.2-т заасны дагуу өөрчлөлт оруулахдаа “Өөрчлөлтийн саналын мэдүүлэг”-ийг үндэслэлийн хамт хүргүүлж түүнд ГЕН-ийн 38.2.1-д заасан мэдээллийг багтаана. Өөрчлөлтийн саналын мэдүүлгийн хүлээн авсаны дараа талууд 38.2.6-д заасан журмыг мөрдөнө. Ингэхдээ “Өөрчлөлтийн санал” гэдгийг “Өөрчлөлтийн саналын мэдүүлэг” гэж уншина. Гэвч өөрчлөлтийн саналын мэдүүлэгт нийлүүлэгчийн заасан хүчинтэй хугацаанд захиалагч өөрчлөлтийн саналын мэдүүлгийг зөвшөөрөөгүй эсхүл нийлүүлэгчтэй тохиролцоонд хүрээгүй тохиолдолд түүнийг бэлтгэхэд гарсан зардлыг захиалагч төлөхгүй.

39. Ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах

39.1. Нийлүүлэгч дараах шалтгаанаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүйгээс үйл ажиллагаа зогссон эсхүл хугацаа хоцорсон бол Хэрэгжилтийн хуваарь-т заасан ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгана. Үүнд:

- (a) ГЕН-ийн 38-д заасаны дагуу Системд оруулсан аливаа өөрчлөлт;
- (б) ГЕН-ийн 37-д заасны дагуу бий болсон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал;
- (в) Захиалагчийн буруу үйл ажиллагаа; эсхүл
- (г) гэрээнд тусгайлан заасан бусад асуудлууд;

Сунгах хугацаа нь үүссэн нөхцөл байдлаас хамаарч шударга, бодитой байх бөгөөд нийлүүлэгчийн хугацаа хоцролт, зогсолтыг шударгаар тусган харгалзсан байна.

39.2. Гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол нийлүүлэгч ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах хүсэлтийг ийм шаардлагад хүргэсэн нөхцөл байдлын үндэслэлийн хамт Төслийн удирдагчид тэдгээр нөхцөл байдал үүссэнээс хойш аль болох хурдан ирүүлнэ. Талууд мэдэгдэл, холбогдох мэдээллийг хүлээн аваад аль болох хурдан хугацаанд сунгах хугацааг тохирно. Нийлүүлэгч захиалагчийн шударга, бодитой гэж тогтоосон хугацааг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд ГЕН-ийн 6 дугаар зүйлийн дагуу маргааныг шийдвэрлүүлнэ.

39.3. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийн хугацаа хоцролтыг аль болох багасгах боломжит бүх арга хэмжээг аль ч үед авна.

40. Гэрээ цуцлах

40.1. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах

40.1.1. ГЕН-ийн 40.1-д заасны дагуу гэрээ цуцлах тухай мэдэгдэл өгснөөр Захиалагч шаардлагатай тохиолдолд гэрээг хэдийд ч цуцалж болно.

40.1.2. ГЕН-ийн 40.1.1-д заасны дагуу нийлүүлэгч мэдэгдэл авсан даруй эсхүл мэдэгдэлд заагдсан хугацаанд:

- (а) Системийн хэрэгжсэн хэсгийг хамгаалах эсхүл ажлын талбайг чөлөөлөх, цэвэрлэх, хамгаалахад шаардагдах ажлын зорилгоор Захиалагчийн мэдэгдэлд заасанаас бусад бүх ажлыг зогсооно;
- (б) ГЕН-ийн 40.1.2 (г) (ii)-д заасны дагуу захиалагчид шилжүүлэхээс бусад бүх туслан гүйцэтгэх гэрээг цуцална;
- (в) нийлүүлэгчийн бүх багаж ТШӨХөөрөмжийг ажлын талбайгаас шилжүүлэх, нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн ажилтнуудыг ажлын талбай дээрээс чөлөөлөх, эвдэрч хэмхэрсэн багаж, хог хаягдал, үлдэгдлийг цэвэрлэх;
- (г) Үүнээс гадна, ГЕН-ийн 40.1.3-т заасны дагуу хийх төлбөрт хамаарах дараах ажлуудыг гүйцэтгэнэ.
 - (i) Гэрээг цуцлах хүртэл нийлүүлэгчээс захиалагчид нийлүүлэхээр гүйцэтгэсэн системийн хэсгүүдийг хүргүүлэх;
 - (ii) Гэрээ цуцлагдах үед болон нийлүүлэгч туслан гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээгээр захиалагчид шаардагдах Системд хамаарах нийлүүлэгчийн эрх, хангамжийг хууль зүйн хүрээнд боломжит хэмжээгээр захиалагчид шилжүүлэх;
 - (iii) Системтэй холбоотой гэрээг цуцлах хүртэлх хугацаанд нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн зохиогчийн эрхээр хамгаалагдаагүй бүх зураг төсөл, бусад бичиг баримтыг захиалагчид хүргүүлэх.

40.1.3. ГЕН-ийн 40.1.1-д заасны дагуу гэрээ цуцлагдах үед захиалагч нийлүүлэгчид дор дурдсан төлбөр төлнө :

- (а) Гэрээг цуцлах хүртэл нийлүүлэгчээс хэвийн гүйцэтгэсэн системийн хэсгийн гэрээний үнэ;
- (б) Нийлүүлэгчийн багаж ТШӨХөөрөмжийг ажлын талбайгаас шилжүүлэх ба тэдгээрийг болон туслан гүйцэтгэгчийг буцаан хүргэхэд нийлүүлэгчээс гарсан бодит зардал;
- (в) Гэрээг цуцалсантай холбоотой нийлүүлэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх аливаа дүн;
- (г) ГЕН 40.1.2 (а) заасны дагуу системийг хамгаалж ажлын талбайг цэвэрлэх, аюулгүй болгохтой холбогдон нийлүүлэгчээс гарсан зардал;
- (д) ГЕН 40.1.3 (а–г) заалтуудад хамрагдаагүй бөгөөд гэрээтэй холбогдолтойгоор нийлүүлэгчийн гуравдагч этгээдтэй хамтран гүйцэтгэсэн болон бусад үүрэг хариуцлагатай холбоотой гарах зардал.

40.2. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах

40.2.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгуулах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн ГЕН-ийн 40.2-т заасны дагуу гэрээ цуцлах болсоныг нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

- (а) Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол;
- (б) Хэрэв нийлүүлэгч гэрээг эсхүл түүнд заасан аливаа эрх болон сонирхлыг ГЕН-ийн 41 дүгээр зүйлийг зөрчин шилжүүлсэн бол); эсхүл

- (в) Хэрэв нийлүүлэгч нь гэрээг олж авахаар өрсөлдөх, гэрээг хэрэгжүүлэх явцад авилгал, хээл хахуульд холбогдсон, гэрээтэй холбогдуулж илт худал мэдээлэл ирүүлсэн нь шүүх, эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол.

40.2.2. Хэрэв нийлүүлэгч:

- (а) гэрээг орхиж хэрэгжүүлэхгүй болсон бол;
- (б) Системийн ажлыг үндэслэлгүй шалтгаанаар эхлүүлж чадаагүй бол;
- (в) гэрээнд заасны дагуу гэрээг удаа дараа хэрэгжүүлэхгүй, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ шалтгаангүйгээр биелүүлэхгүй байгаа бол;
- (г) ГЕН-ийн 19-д заасны дагуу Эцэслэн баталсан ажлын төлөвлөгөөнд заасан хэлбэрээр Системийг хэрэгжүүлж дуусгахад хангалттай бичиг баримт, үйлчилгээ, ажиллах хүчнээр хангаж байгаа байдал нь нийлүүлэгч Системийг сунгасан хугацаанд ашиглалтанд хүлээлгэж өгөх боломжгүй гэж захиалагч үзсэн бол

Захиалагч гэрээний дагуу зөрчлийг арилгуулах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн нийлүүлэгчид зөрчлийн талаар болон түүнийг арилгах шаардлагыг дурдсан мэдэгдэлийг бичгээр өгнө. Хэрэв нийлүүлэгч мэдэгдэл хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор зөрчлийг арилгаагүй буюу арилгах арга хэмжээ аваагүй бол захиалагч ГЕН-ийн 40.2-т заасны дагуу гэрээ цуцлах болсоныг нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг цуцлах эрхтэй.

40.2.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 40.2.1 эсхүл 40.2.2-ын дагуу гэрээ цуцлах тухай мэдэгдэлийг авсан даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд:

- (а) Системийн хэрэгжсэн хэсгийг хамгаалах эсхүл ажлын талбайг чөлөөлөх, цэвэрлэх, хамгаалах зорилгоор захиалагчийн мэдэгдэлд заасанаас бусад бүх ажлыг зогсооно;
- (б) ГЕН-ийн 40.1.2 (г) (ii) дагуу захиалагчид шилжүүлэхээс бусад бүх туслан гүйцэтгэх гэрээг цуцлана;
- (в) Гэрээг цуцлах хүртэл нийлүүлэгчээс захиалагчид нийлүүлэхээр гүйцэтгэсэн системийн хэсгүүдийг хүргүүлэх;
- (г) Гэрээ цуцлагдах үед болон нийлүүлэгч туслан гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээгээр захиалагчид шаардагдах Системд хамаарах нийлүүлэгчийн эрх, хангамжийг хууль зүйн хүрээнд боломжит хэмжээгээр захиалагчид шилжүүлэх;
- (д) Системтэй холбоотой гэрээг цуцлах хүртэлх хугацаанд нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн бүх зураг төсөл, бусад бичиг баримтыг захиалагчид хүргүүлэх.

40.2.4. Захиалагч ажлын талбайд нэвтрэн орж Системийг өөрөө эсхүл гуравдагч этгээдийг хөлслөн гүйцэтгүүлнэ. Системийг суурилуулж дуусгасны дараа захиалагч нийлүүлэгчид мэдэгдэл өгч түүнийг тоног тоног ТШӨХөөрөмжийг буцаан өгөх эсхүл ойролцоох ажлын талбайд хүргэн өгөх тухай мэдэгдэнэ. Нийлүүлэгч энэ мэдэгдлийг авсан даруй өөрийн зардлаар тоног ТШӨХөөрөмжөө ажлын талбайгаас гаргана.

40.2.5. ГЕН 40.2.6-д өөрөөр заагаагүй бол гэрээ цуцлагдах үед захиалагч нийлүүлэгчид гэрээг цуцлах хүртэл

нийлүүлэгчээс хэвийн гүйцэтгэсэн системийн хэсгийн гэрээний үнэ, ГЕН 40.2.3 (а)-д заасны дагуу системийг хамгаалж ажлын талбайг цэвэрлэх, аюулгүй болгохтой холбогдон нийлүүлэгчээс гарсан зардалыг төлнө. Нийлүүлэгчээс гэрээ цуцлагдахаас өмнө захиалагчид төлөх ёстой байсан аливаа дүнг гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрөөс хасна.

40.2.6. Захиалагч Системийг дуусгасан бол үүнд гарсан зардлыг тогтооно. Нийлүүлэгчид төлөх ГЕН-ийн 40.2.5-д заасан төлбөрийн дүн дээр Системийг дуусгахад захиалагчаас гарсан зардлыг нэмсэн дүн нь гэрээний үнээс давсан бол илүү гарсан дүнг нийлүүлэгч хариуцана. Энэхүү илүү гарсан дүн нь ГЕН-ийн 40.2.5-ын дагуу нийлүүлэгчид төлөх дүнгээс илүү бол нийлүүлэгч зөрүүг захиалагчид төлнө, эсрэг тохиолдолд захиалагч нийлүүлэгчид зөрүүг төлнө. Захиалагч, нийлүүлэгч хоёр дээр дурдсаны дагуу ямар дүн төлөгдөх тооцоог харилцан тохиролцоно.

40.3. Нийлүүлэгчийн шаардлагаар гэрээг цуцлах

40.3.1. Хэрэв

(а) захиалагч гэрээний дагуу заасан хугацаанд ГТН-д заасан үндэслэлгүйгээр нийлүүлэгчид төлөх аливаа төлбөрийг төлөөгүй, аливаа нэхэмжлэх дагалдах бичиг баримтыг хүлээн авч батлаагүй, эсхүл гэрээг ноцтойгоор зөрчсөн бол нийлүүлэгч уг төлбөрийг ГЕН-ийн 12.3-т заасан торгуулийн хамт төлөх, нэхэмжлэх болон дагалдах бичиг баримтыг батлах, зөрчлийг арилгах шаардлагыг бичгээр захиалагчид мэдэгдэнэ. Хэрэв захиалагч шаардсан төлбөрийг торгуулийн хамт төлөх, нэхэмжлэх болон дагалдах бичиг баримтыг баталж, зөрчлийг арилгах шаардлагыг мэдэгдэл хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор биелүүлээгүй бол ; эсхүл

(б) хэрэв нийлүүлэгч захиалагчийн буруугаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон, түүнчлэн ялангуяа Системийг гүйцэтгэх, дуусахтай холбогдуулж захиалагч ажлын талбай болон бусад талбайг чөлөөлөх, нэвтрэх зөвшөөрөл олгох, засгийн газрын бусад байгууллагын зөвшөөрөл авч өгөх асуудлыг зохион байгуулж чадаагүй бол

Нийлүүлэгч захиалагчид гэрээний дагуу зөрчлийг арилгах шаардлагыг дурдсан мэдэгдэлийг бичгээр өгнө. Хэрэв нийлүүлэгч мэдэгдэл хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор зөрчлийг арилгаагүй буюу арилгах арга хэмжээ аваагүй бол нийлүүлэгч энэ хугацаанд ГЕН-ийн 40.3.1-т заасны дагуу гэрээ цуцлах болсоныг захиалагчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг цуцлах эрхтэй.

40.3.2. Захиалагч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол нийлүүлэгч ГЕН 40.3.2 заасны дагуу гэрээ цуцлах тухай мэдэгдэл өгч гэрээ цуцлах эрхтэй.

40.3.3. ГЕН-ийн 40.3.1 ба 40.3.2-д заасны дагуу гэрээ цуцлагдах тохиолдолд нийлүүлэгч дараах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) Системийн хэрэгжсэн хэсгийг хамгаалах эсхүл ажлын талбайг чөлөөлөх, цэвэрлэх, хамгаалахад шаардагдах ажлаас бусад бүх ажлыг зогсооно;

- (б) ГЕН-ийн 40.3.3 (г) (ii)-д заасны дагуу захиалагчид шилжүүлэхээс бусад бүх туслан гүйцэтгэх гэрээг цуцлана;
- (в) нийлүүлэгчийн бүх багаж ТШӨХөөрөмжийг ажлын талбайгаас шилжүүлэх, нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн ажилтнуудыг ажлын талбай дээрээс чөлөөлөх, эвдэрч хэмхэрсэн багаж, хог хаягдал, үлдэгдлийг цэвэрлэх;
- (г) Үүнээс гадна, ГЕН 40.3.4-т заасны дагуу хийх төлбөрт хамаарах дараах ажлыг гүйцэтгэнэ.
 - (i) гэрээг цуцлах хүртэл нийлүүлэгчээс захиалагчид нийлүүлэхээр гүйцэтгэсэн системийн хэсгүүдийг хүргүүлэх;
 - (ii) гэрээ цуцлагдах үед болон нийлүүлэгч туслан гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээгээр захиалагчид шаардагдах Системд хамаарах нийлүүлэгчийн эрх, хангамжийг хууль зүйн хүрээнд боломжит хэмжээгээр захиалагчид шилжүүлэх;
 - (iii) системтэй холбоотой гэрээг цуцлах хүртэлх хугацаанд нийлүүлэгч болон туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн хууль зүйн хүрээнд боломжит хэмжээнд зөвшөөрөгдөх бүх зураг төсөл, бусад бичиг баримтыг захиалагчид хүргүүлэх.

40.3.4. Хэрэв ГЕН-ийн 40.3.1 ба 40.3.2-т заасны дагуу гэрээ цуцлагдсан бол захиалагч нийлүүлэгчид ГЕН-ийн 40.1.3-д заасан төлбөрийг болон энэхүү цуцлалтаас үүдэн захиалагчид үүссэн ашгаас бусад алдагдал, хохирлыг нөхөн төлнө.

40.3.5. ГЕН-ийн 40.3 дугаар зүйлийн дагуу нийлүүлэгчийн шаардлагаар гэрээ цуцлагдах нь гэрээний дагуу нийлүүлэгчийн бусад эрх, зөрчлийг арилгуулах арга хэмжээг хөндөхгүй.

41. Эрх шилжүүлэх

41.1 Захиалагч болон нийлүүлэгч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэх санамж

Гэрээний ерөнхий нөхцөлд дурдсан захиалагч, бараа зэрэг нэр томъёо тухайн гэрээнд юуг илэрхийлэхийг гэрээний тусгай нөхцөлд заадаг. Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэхдээ дараах зүйлсийг шалгана. Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөлийн аль нэг зүйлд гэрээний тусгай нөхцөлийг ишилсэн бол холбогдох нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд заавал оруулна.
2. Тухайн гэрээний шаардлагаар гэрээний ерөнхий нөхцөлийг засварлах, илүү дэлгэрүүлэх тохиолдолд эдгээрийг гэрээний ерөнхий нөхцөлд бус тусгай нөхцөлд тусгана.
3. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтлана. Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаарыг хаалтад хийж ишлэв.
4. [ГТН-ийг хэрхэн бэлтгэх тухай зааврыг дөрвөлжин хаалтанд бичив. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч боловсруулна.]

А. ГЭРЭЭ БА ТАЙЛБАР

1. Нэр томьёо (ГЕН 1 дүгээр зүйл)

ГЕН 1.1 (а) (ix)	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох заавар, дүрэм, журмууд
ГЕН 1.1 (б) (i)	Захиалагч: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ГЕН 1.1 (д) (ii)	Ажлын талбай (ууд) нь: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, Засгийн газрын XII байр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

2. Гэрээний баримт бичиг (ГЕН 2 дугаар зүйл)

ГЕН 2	ГЕН-ийн 2 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй.
-------	---

3. Тайлбар (ГЕН 3 дугаар зүйл)

ГЕН 3.1.1	Техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу явагдах бүх харилцаа холбоо, боловсруулж гаргах, солилцох бүх баримт бичигт ашиглагдах хэл нь Монгол хэл байна.
-----------	---

4. Мэдэгдэл (ГЕН 4 дүгээр зүйл)

ГЕН 4.1	Мэдэгдлийг дараах хаягаар хаяглана. “ГЕН-ийн 1.1 (б) (i)-д заасан нэрээр. Мэдэгдлийг дэр дурдсан этгээдэд шуудангаар, биечлэн хүргэх, факсаар хүргүүлнэ.
---------	---

Б. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

8. Эхлүүлэх болон ашиглалтанд хүлээн авах хугацаа (ГЕН-ийн 8 дугаар зүйл)

ГЕН 8.1	Нийлүүлэгч нь системийн ажлыг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор эхлүүлнэ.
ГЕН 8.2	Ашиглалтанд хүлээн авах хугацаа нь 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр эсхүл үүнээс өмнө байж болно.

9. Нийлүүлэгчийн үүрэг хариуцлага (ГЕН-ийн 9 дүгээр зүйл)

ГЕН 9.9	Нийлүүлэгч нь дараахь нэмэлт үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд: “нэмэлт үүрэг хариуцлага байхгүй” .
---------	---

10. Захиалагчийн үүрэг хариуцлага (ГЕН-ийн 10 дугаар зүйл)

ГЕН 10.12	Захиалагч нь дараахь нэмэлт үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд: “нэмэлт үүрэг хариуцлага байхгүй” .
-----------	--

В. Төлбөр

11. Гэрээний үнэ

(ГЕН-ийн 11 дүгээр зүйл)

ГЕН 11.2 (б)	Гэрээний үнэд дараах байдлаар тохируулга хийнэ. “тохируулга байхгүй”
-----------------	---

12. Төлбөрийн нөхцөл (ГЕН-ийн 12 дугаар зүйл)

ГЕН 12.1	<p>ГЕН-ийн 12 дугаар зүйлийн дагуу (Төлбөрийн нөхцөл) захиалагч нь нийлүүлэгчид гэрээний үнийг дор дурдсан хэлбэрээр төлнө. Хэрэв өөрөөр заагаагүй бол бүх төлбөрийг гэрээ хэрэгжүүлэх хуваарийн дагуу нийлүүлэгдэж, суурилуулагдаж эсхүл ашиглалтанд хүлээн авагдсан бараа, үйлчилгээнд харгалзах гэрээний үнийн хэсэгт хийх бөгөөд гэрээний маягтын үнийн хуваарьт заасан нэгж үнэ, мөнгөний нэгжээр тооцон төлнө.</p> <p>(а) Урьдчилгаа төлбөр нийт үнийн тэг (0%) хувийг</p> <p>(б) Системийн нэгтгэл бүрэн дуусахад: Бүрэн нэгтгэгдэж дууссан системийг ашиглалтанд хүлээн авсны дараа гэрээний нийт үнийн зуун (100%) хувийг</p>
----------	--

14. Татвар хураамж (ГЕН-ийн 14 дүгээр зүйл)

ГЕН 14	“ГЕН-ийн 14 дүгээр зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

Г. ОЮУНЫ ӨМЧ

15. Зохиогчийн эрх

(ГЕН-ийн 15 дугаар зүйл)

ГЕН 15.2	Захиалагч тусгай стандарт программ хангамж болон түүний хэсгийг дараах нөхцөл байдал үүсэхэд нийлүүлэгчийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад хариуцуулах, ашиглах эрхийн лиценз өгөх эсхүл сайн дураар шилжүүлж болно. “байхгүй”
ГЕН 15.5	Хэрэв шаардлагагүй бол заах: “Гэрээг гүйцэтгэхэд программ хангамжийн “escrow” гэрээ шаардлагагүй”

17. Нууц мэдээлэл (ГЕН-ийн 17 дугаар зүйл)

ГЕН 17.1	“ГЕН-ийн 17.1 дүгээр зүйлд заасан нууцлалын нөхцөлд нэмэлт өөрчлөлт орохгүй”
----------	---

**Д. СИСТЕМИЙН НИЙЛҮҮЛЭЛТ, СУУРИЛУУЛАЛТ, ШАЛГАЛТ,
ТУРШИЛТ, АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭН АВАХ**

**18. Төлөөлөгчид
(ГЕН-ийн 18 дугаар зүйл)**

ГЕН 18.1	Гэрээтэй холбоотойгоор захиалагчийг төлөөлөх төслийн удирдагч нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараах нэмэлт эрх мэдэл болон / эсхүл хязгаарлалт: “Нэмэлт эрх мэдэл эсхүл хязгаарлалт байхгүй.”
ГЕН 18.2.2	Гэрээтэй холбоотойгоор нийлүүлэгчийг төлөөлөх төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараах нэмэлт эрх мэдэл болон / эсхүл хязгаарлалт: “Нэмэлт эрх мэдэл эсхүл хязгаарлалт байхгүй.”

**21. Зураг төсөл-дизайн, инженерчлэл
(ГЕН-ийн 21 дүгээр зүйл)**

ГЕН 21.2	Гэрээг хэрэгжүүлэхэд холбогдох бүх стандарт, кодын “ГЕН-д заасны дагуу” шинэчлэгдсэн эсхүл сүүлийн хувилбарыг мөрдөнө.
ГЕН 21.2.1	Нийлүүлэгч нь систем болон дэд системийн ажлыг хийж гүйцэтгэхийн өмнө төслийн удирдагчийн зөвшөөрсөн байх шаардлагатай дор дурдсан баримт бичгийг бэлтгэн түүнд хүргүүлнэ. Үүнд: “байхгүй”

**23. Бүтээгдэхүүнийг шинэчлэх
(ГЕН-ийн 23 дугаар зүйл)**

ГЕН 23.4	Нийлүүлэгч нь захиалагчид: “баталгаат хугацааны туршид бүх стандарт программ хангамжийн сүүлийн хувилбар, шинэчлэлийг ГЕН-д зааснаар үнэгүй” нийлүүлнэ.
----------	--

**25. Шалгалт
(ГЕН-ийн 25 дугаар зүйл)**

ГЕН 25	“ГЕН-ийн 25 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

**26. Системийг суурилуулах
(ГЕН-ийн 26 дугаар зүйл)**

ГЕН 26	“ГЕН-ийн 26 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

**27. Системийн туршилт, ашиглалтанд хүлээн авах
(ГЕН-ийн 27 дугаар зүйл)**

ГЕН 27.2.1	Ашиглалтанд хүлээн авах шалгалтыг “систем эсхүл дэд системүүд, шалгалт туршилт, туршилт хийх журам болон ашиглалтанд хүлээн авахад шаардах үр дүнгийн” дагуу зохион байгуулна.
ГЕН 27.2.2	Хэрэв систем, дэд системийг ашиглалтанд хүлээн авах шалгалт нь суурилуулалгдсан өдрөөс эсхүл захиалагч, нийлүүлэгчийн тохиролцсон бусад өдрөөс хойш 10 хоногийн дотор амжилттай хийгдэж дуусаагүй бол тухайн нөхцөл байдлаас хамааран ГЕН-ийн 27.3.5 (а) эсхүл (б) заалтууд үйлчилнэ.

Е. БАТАЛГАА БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

28. Ашиглалтанд хүлээн авах үеийн баталгаа (ГЕН-ийн 28 дугаар зүйл)

ГЕН 28.2	Алданги нь долоо хоног тутам 0.5 хувь байна. Алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн эсхүл хэрэв уг алданги нь дэд системд хамаарах бол гэрээний үнийн холбогдох хэсгийн дүнгийн 10 хувь байна.
ГЕН 28.3	Алданги нь “зөвхөн ашиглалтанд хүлээлгэн өгөх хугацаа” -нд тооцогдоно.

31. Оюуны өмчийн эрхийн баталгаа (ГЕН-ийн 31 дүгээр зүйл)

ГЕН 31	“ГЕН-ийн 31 дүгээр зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

32. Оюуны өмчийн эрх зөрчигдөх (ГЕН-ийн 32 дугаар зүйл)

ГЕН 32	“ГЕН-ийн 32 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

Ж. ЭРСДЭЛИЙН ХУВААРИЛАЛТ

33. Эзэмших эрхийг шилжүүлэх (ГЕН-ийн 33 дугаар зүйл)

ГЕН 33	“ГЕН-ийн 33 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

34. Системийг хяналтанд байлгах (ГЕН-ийн 34 дүгээр зүйл)

ГЕН 34	“ГЕН-ийн 34 дүгээр зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

35. Өмч алдах, гэнэтийн аюул осол, хохирлын нөхөн төлбөр (ГЕН-ийн 35 дугаар зүйл)

ГЕН 35	“ГЕН-ийн 35 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

37. Давагдашгүй хүчин зүйл (ГЕН-ийн 37 дугаар зүйл)

ГЕН 37	“ГЕН-ийн 37 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

З. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

38. Системд өөрчлөлт оруулах (ГЕН-ийн 38 дугаар зүйл)

ГЕН 38	“ГЕН-ийн 38 дугаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

39. Ашиглалтанд хүлээн авах хугацааг сунгах (ГЕН-ийн 39 дүгээр зүйл)

ГЕН 39	“ГЕН-ийн 39 дүгээр зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

**40. Гэрээ цуцлах
(ГЕН-ийн 40 дүгээр зүйл)**

ГЕН 40	“ГЕН-ийн 40 дүгээр зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	--

**41. Эрх шилжүүлэх
(ГЕН-ийн 41 дүгээр зүйл)**

ГЕН 41	“ГЕН-ийн 41 дүгээругаар зүйлд холбогдох гэрээний тусгай нөхцөл байхгүй”
--------	---

ХАВСРАЛТ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендерийн урилгыг бэлтгэх санамж

Тендерийн урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2013 оны 81 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-д заасны дагуу бэлтгэж, зарлан мэдээлнэ.

Тендерийн урилгын зорилго нь эрх бүхий тендерт оролцогчид тендер шалгаруулалтад оролцох боломж олгож энэ тухай шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Урьдчилсан сонголт явуулсан нөхцөлд урилга болон тендерийн баримт бичгийг зөвхөн урьдчилсан сонголтод шалгарсан оролцогчдод илгээж, тендер шалгаруулалтад оролцуулна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **МХЕГ/202010020**

“Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх”** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянган)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь 12,500,000 /арван хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **6,250,000 /зургаан сая хоёр зуун тавин мянган/ төгрөг байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **12,500,000 /арван хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс багагүй байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагагүй.

Тендерийн хамт **500,000 /таван зуун мянган/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 10:00** цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 10:30** цагт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар,
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж,
Засгийн газрын XII байр, Утас: 51-264261
Цахим хаяг: www.tender.gov.mn**